



**МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ
БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТТЭЙ
ХОЛБООТОЙ ГЭМТ ЯВДЛЫГ СУДАЛСАН
БАЙДЛЫН ТОЙМ
(2018-2024)**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2025 он

“МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТТЭЙ
ХОЛБООТОЙ ГЭМТ ЯВДЛЫГ СУДАЛСАН БАЙДЛЫН ТОЙМ (2018-2024)”

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судалгааны ахлагч:	багийн	Доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа С.Гантулга
-----------------------	--------	--

Гишүүд:	Доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа Б.Эрдэнэбат
---------	---

Доктор, цагдаагийн хошууч Д.Энхтөр

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчлол	Агуулга
АШУҮИС	Анагаахын шинжлэх ухааны их сургууль
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГХУСАЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
ДХИС	Дотоод хэргийн их сургууль
ЗГХА	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
НҮТББ	Нийтэд үйлчилдэг төрийн бус байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
НЭМГ	Нийслэлийн эрүүл мэндийн газар
МУБИС	Монгол Улсын Боловсролын Их Сургууль
МУИС	Монгол улсын их сургууль
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ТББ	Төрийн бус байгууллага
СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЭМШИС	Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМГ	Эрүүл мэндийн газар

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График	Агуулга
График №1.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт явдлын талаар докторын зэрэг горилсон нийт бүтээлийн харьцуулалтыг харуулав.
График №2.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт явдлын талаар магистрын зэрэг горилсон нийт бүтээлийн харьцуулалтыг харуулав.
График №3.	Суурь болон хэрэглээний судалгааны ажил (Эрдмийн цол, зэрэг)
График №4.	Суурь болон хэрэглээний судалгааны ажил
График №5.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт явдлын талаар судлагдсан эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлэгдсэн сэтгүүлийг харуулав.
График №6.	Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллийн судлагдсан байдлын тоймыг бүлэглэн харуулав.
График №7.	Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл нийтлэн судлаачдын эрдмийн зэрэг, цолыг харуулав.
График №8.	Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл нийтлэн судлаачдын ажил эрхлэлтийн байдлыг харуулав.
График №9.	Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл нийтлэн судлаачдын бичилтийн хэлбэрийг харуулав.
График №10.	Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн харьцааг харуулав.
График №11.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой судалгааны ажлын чиглэлийг дэлгэрэнгүй байдлаар харуулав
График №12.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой судалгааны ажил хийсэн хүмүүсийн эрдмийн зэрэг цолыг харуулав
График №13.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой судалгаа явуулсан судлаачдын хөдөлмөр эрхлэлтийн байдлыг харуулав
График №14.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой судалгааг боловсруулсан байдлыг харуулав

АГУУЛГА

УДИРТГАЛ	6
1.1 Судалгааны ажлын шаардлага, үндэслэл	7
1.2. Судалгааны ажлын зорилго, зорилт	9
1.3. Сэдвийн шинэлэг тал	10
1.4. Судалгааны арга зүй, түүвэрлэлт	10
1.5. Судалгааны ажлын эх сурвалж	11
1.6. Судалгааны хамрах хүрээ, хязгаарлалт	11
 МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТТЭЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ЯВДЛЫГ СУДАЛСАН БАЙДАЛ	
2.1. Докторын зэрэг горилсон бүтээл	13
2.2. Магистрын зэрэг горилсон судалгааны ажил	17
2.3. Судалгааны тайлан	22
2.4. Гарын авлага, сурах бичиг, нэг сэдэвт бүтээл	45
2.5. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл	48
2.6. Эрдэм шинжилгээний өгүүлэл	82
 МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТТЭЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ЯВДЛЫГ СУДАЛСАН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ	
3.1. Магистр, докторын зэрэг горилсон бүтээл, суурь болон хэрэглээний судалгааны тайлангийн үр дүнд хийсэн дүн шинжилгээ	94
3.2. Гарын авлага, сурах бичиг, нэг сэдэвт бүтээлд хийсэн судалгааны үр дүн	99
3.3. Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэлд хийсэн судалгааны үр дүн	101
4.4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт явдлыг судалсан байдалд хийсэн дүн шинжилгээ	104
 ДҮГНЭЛТ, САНАЛ	109
ХАВСРАЛТ	113



УДИРТГАЛ



УДИРТГАЛ

1.1 Судалгааны ажлын шаардлага, үндэслэл

Хүн төрөлхтний нийгмийн хөгжил дэвшлийн зэрэгцээ сөрөг үзэгдлүүд тасралтгүй нэмэгдсээр байгаа бөгөөд тэдгээрийн дундаас мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээ, түүнтэй холбоотой гэмт хэрэг нь дэлхий дахинд төдийгүй Монгол Улсад ч нийгэм, эдийн засаг, эрүүл мэнд, үндэсний аюулгүй байдалд ноцтой заналхийлэл учруулж буй асуудлын нэг болоод байна. Энэхүү нийгмийн сөрөг үзэгдэл нь зөвхөн хувь хүний бие махбодын болон сэтгэл санааны эрүүл мэндэд нөлөөлөөд зогсохгүй, гэр бүл, нийгмийн тогтолцоо, эдийн засгийн бүтцэд гүн гүнзгий сөрөг үр дагавар үзүүлж, цаашлаад улс орны тогтвортой хөгжлийг алдагдуулах аюултай болж байна. Монгол Улсын Засгийн газраас батлан хэрэгжүүлж буй “Хар тамхи, мансууралтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-т уг асуудлыг “иргэдийн хэвийн амьдрал, хүн амын эрүүл мэнд, үндэсний аюулгүй байдалд бодит бэрхшээл учруулж болзошгүй” хэмээн тодорхойлсон нь энэ асуудлын ноцтой байдлыг онцлон харуулж байна.

Түүхийн судалгаанд дурдсанаар, хүн төрөлхтөн мансууруулах бодисыг МЭӨ таван мянган жилийн өмнөөс хэрэглэж ирсэн бөгөөд археологийн олдвор, бичгийн эх сурвалжууд үүнийг нотолдог. Монголчуудын хувьд эртнээс олсны төрлийн ургамлыг “муу өвс” хэмээн нэрийдэж, ургасан газрыг “бузартсан” гэж үздэг байсныг судлаачид тэмдэглэсэн байдаг. Энэ нь мансууруулах шинж чанартай бодисын аюулыг эртнээс танин мэдэж, нийгмийн хүрээнд хориглон цээрлэж ирснийг илтгэнэ. Харин XVIII зууны үеэс хилийн худалдаа, тэр дундаа хятадын худалдаачдын үйл ажиллагааны нөлөөгөөр хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ Монгол нутагт нэвтэрч, тодорхой хүрээнд дэлгэрч эхэлжээ. 1912 онд Богд хаанаас гаргасан “хар тамхи хэмээгч бодис хамаг хортой бузар зүйл тул Монгол нутагт хэрэглэх, худалдах, тариалах явдлыг хатуу цаазалсугай” гэсэн зарлиг нь энэ төрлийн бодисын хор уршгийг төрийн бодлогоор хязгаарлах оролдлогын анхны илэрхийлэл байв. Гэвч ардчиллын шилжилтийн дараа нийгмийн зохицуулалт сулран, хил нээлттэй болж, дэлхийн глобалчлалын нөлөөгөөр энэ төрлийн гэмт хэргийн гаралт нэмэгдэх хандлагатай болсон нь өнөө цагийн тулгамдсан асуудлын нэг болж байна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар олж авах, боловсруулах, хэрэглэх, тээвэрлэх, илгээх, худалдаалах зэрэг гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдлийн тоо өсөж, энэ төрлийн эм, бодис хэрэглэгчийн нас улам залуужиж байна. Энэ үзэгдэл нь нийгмийн шилжилт, эдийн засгийн ялгарал, ажилгүйдэл, ядуурал, гэр бүлийн орчны сөрөг нөлөө, өсвөр үеийнхний сэтгэл зүйн тогтворгүй байдал, цахим орчны сөрөг нөлөөлөл зэрэг олон хүчин зүйлтэй нягт холбоотой гэж үзэх үндэстэй. Мөн Монгол Улсын газар зүйн байршил буюу хоёр том зах зээл болох ОХУ, БНХАУ-тай хил залгаа оршдог онцлог нь мансууруулах бодисын хууль бус эргэлт, тээвэрлэлтийн замд өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Хууль сахиулах байгууллагын статистик мэдээллээр мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн илрүүлэлт, баривчлагдсан этгээдийн тоо, хураагдсан бодисын хэмжээ жилээс жилд өсөж байгаа нь энэ асуудал нийгмийн аюулгүй байдалд бодит заналхийлэл болж байна гэж тайлбарлаж болохоор байна.

Олон улсын судалгааны байгууллагуудаас гүйцэтгэсэн судалгааны тайлангаас үзэхэд, мансууруулах бодисын хэрэглээ дэлхий дахинд залуужих, төрөл олшрох, тээвэрлэлтийн хэлбэр нарийсах, боловсронгуй болох чиг хандлагатай болж байна. Тухайлбал, ОХУ-д мансууруулах бодисын хэрэглэгчийн тоо 18 саяд хүрч, жил бүр дунджаар 70 мянга орчим хүн энэ шалтгаанаар нас бардаг бол БНХАУ-д 2.3 сая гаруй хүн донтогчоор бүртгэгдэж, жил бүр 200 мянга гаруй шинэ хэрэглэгч нэмж бүртгэгдэж буй нь уг сөрөг үзэгдлийн бодит аюулын түвшнийг илэрхийлж байна. Энэ нь Монгол Улсын хувьд ч мөн адил нэн тэргүүнд анхаарал хандуулах шаардлагатай асуудалд зүй ёсоор тооцогдож, аюул заналын түвшин нь ирээдүйд хүн амын эрүүл мэнд, нийгмийн тогтвортой байдалд ноцтой үр дагавар үүсгэж болзошгүйг илтгэж байна.

Монгол Улсад өнөөгийн байдлаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ нь архидалт, тамхидалт зэрэг уламжлалт сөрөг үзэгдлүүдтэй харьцуулахад харьцангуй бага түвшинд байгаа хэдий ч түүний өсөлтийн хандлага, тархалтын хурд, хэрэглэгчдийн залуужилт нь ирээдүйд энэ асуудал нийгмийн гүнзгий хямралд хүргэх аюултай болохыг харуулж байна. Мансууруулах бодисын хэрэглээний цар хүрээ, нийгмийн дотоод бүтэцтэй уялдах шалтгаануудыг системтэй судлахгүйгээр урьдчилан сэргийлэх, хяналт тавих, таслан зогсоох бодлого үр дүнгүй болох эрсдэлтэй юм.

Иймд энэхүү сэдвийг судлах нь цаг үеийн зайлшгүй шаардлага бөгөөд судалгаагаар дамжуулан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хэрэглээний бодит байдал, шалтгаан, нөхцөл, үр дагаврыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлох, бодлогын зөвлөмж боловсруулж, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх нь нэн чухал зорилго байх ёстой юм.

Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэсэн гол шаардлага нь 2018-2024 оны хугацаанд Монгол Улсад мансууруулах, эм сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт явдлыг судалсан хэлбэр, төрөл, ашигласан арга зүй, тухайн судалгаануудын онцлог, голлох үр дүн, онол болон практик байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх боломж, нөхцөлийг нэгтгэн дүгнэж, цаашид энэ төрлийн гэмт явдалтай тэмцэх үйл ажиллагаа төгөлдөржүүлэхэд эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагааг аль чиглэлд тусгайлан явуулах шаардлагыг тодорхойлоход оршино. Мөн Монгол Улсад мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг өсөж, үндэсний аюулгүй байдалд заналхийлж буй бодит нөхцөл байдал; хоёрдугаарт, нийгмийн бүлгүүд, ялангуяа өсвөр үе, залуучуудын дунд хэрэглээний түвшин нэмэгдэж, сэтгэл зүйн болон соёлын хүчин зүйлсийн нөлөө нэмэгдэж байгаа байдал; гуравдугаарт, хууль эрх зүйн орчин, хяналт шалгалтын тогтолцоо сул байгаагаас үүдэлтэй доголдол; дөрөвдүгээрт, олон улсын туршлагыг үндэсний нөхцөлд нийцүүлэн хэрэгжүүлэх шаардлага зэрэг бодит шалтгаанууд нь энэхүү судалгааг гүйцэтгэх үндэслэл боллоо.

Иймд уг судалгааны үр дүн нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хэрэглээтэй холбоотой гэмт явдлын шалтгаан, нөхцөл, нийгэм-эдийн засаг, хууль эрх зүйн хүчин зүйлсийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлох замаар холбогдох бодлого, хууль тогтоомж, хяналт шалгалтын арга хэмжээг сайжруулахад бодит хувь нэмэр оруулах ач холбогдолтой юм.

Судалгаанд үндэслэсэн дүгнэлт, санал зөвлөмжийг хууль тогтоох, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагууд (төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Эрүүл мэндийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам гэх мэт)-ын үйл ажиллагаанд ашиглах боломжтой бөгөөд энэ нь энэ төрлийн гэмт хэрэгтэй илүү үр нөлөөтэй, уялдаа холбоотой, нотолгоонд суурилсан арга замаар тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого, сургалт, соён гэгээрүүлэх ажлын чанар, хүртээмжийг сайжруулах, мөн хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, бодлогын шийдвэр гаргах үндэс суурийг бүрдүүлэх ач холбогдолтой юм.

Нөгөөтээгүүр, судалгааны үр дүнг боловсрол, соён гэгээрүүлэх байгууллагууд, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд ашигласнаар өсвөр үе, залуучууд болон нийт иргэдийн дунд мансууруулах бодисын хор уршгийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, хандлагыг өөрчлөх, сэргийлэх боловсролыг бэхжүүлэхэд түлхэц өгнө. Үүнээс гадна судалгаанд тулгуурласан бодит мэдээлэл, нотолгоо нь төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргах, нийгэмд соён гэгээрүүлэх ухуулга, сургалт, нөлөөллийн хөтөлбөрүүдийг шинэлэг хэлбэрээр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чухал хэрэгсэл болох юм.

Ингэснээр энэхүү судалгаа нь зөвхөн онолын ач холбогдолтой бус, практик хэрэглээний чухал үнэ цэн бүхий бүтээл болж, Монгол Улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгтэй шинжлэх ухаанд суурилсан, нэгдсэн бодлогоор, урьдчилан сэргийлэх чиглэлд илүү анхаарал хандуулсан байдлаар тэмцэх суурийг бүрдүүлэх юм.

1.2. Судалгааны ажлын зорилго, зорилт

Энэхүү судалгааны ажлын үндсэн зорилго нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн судлагдсан байдлыг шинжилж, түүхэн хөгжил, өнөөгийн нөхцөл байдал, эрх зүйн орчин, төрийн бодлого болон олон улсын чиг хандлагатай уялдуулан шинжлэх ухааны үндэслэл бүхий цогц үнэлгээ хийхэд оршино. Судалгаагаар уг төрлийн гэмт хэргийн үүсэл, хөгжлийн чиг хандлага, нийгэм-эдийн засагт үзүүлж буй нөлөө, хууль эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг судлан дүгнэж, түүнээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих, таслан зогсоох бодлого, арга хэмжээг оновчтой болгох боломжийг тодорхойлох зорилготой юм.

Үүний зэрэгцээ, өмнө нь хийгдсэн эрдэм шинжилгээний бүтээл, судалгааны үр дүн, дотоод болон гадаадын туршлагыг нэгтгэн дүгнэж, шинэлэг хандлага, арга зүйг тодорхойлох, шинэ мэдлэг, дүгнэлт бий болгохыг зорьж байна. Энэ хүрээнд судалгааны үр дүн нь мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн талаарх судалгааны орон зайг нөхөх, улмаар цаашдын судалгааны чиглэл, арга зүйн үндсийг боловсруулахад хувь нэмэр оруулах ач холбогдолтой юм.

Мөн уг судалгаанаас гарсан дүгнэлт, санал, зөвлөмж нь хууль сахиулах, хяналт шалгалтын болон холбогдох бусад мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд шууд хэрэглэхүйц практик ач холбогдолтой байх бөгөөд алба хаагч, мэргэжилтнүүдийн өдөр тутмын ажилд бодит туслалцаа үзүүлэхүйц мэдээлэл,

арга зүй, чиглэлийг санал болгох юм. Ийнхүү боловсруулсан дүгнэлт, зөвлөмж нь “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” болон “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай” хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг илүү оновчтой, үр нөлөөтэй зохион байгуулахад бодит дэмжлэг үзүүлэх онолын болон практик ач холбогдолтой юм.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд дараах **зорилтыг** дэвшүүлсэн. Үүнд:

1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр урьд гүйцэтгэсэн судалгааны ажлуудыг цуглуулах, дүн шинжилгээ хийх;
2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр докторын зэрэг хамгаалсан диссертаци, магистрын ажил, эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх;
3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр урьд бичигдсэн нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, гарын авлагыг цуглуулах, дүн шинжилгээ хийх;
4. Сэдвийн хүрээнд нэгдсэн санал, зөвлөмж боловсруулах.

1.3. Сэдвийн шинэлэг тал

Энэхүү судалгааны ажлын шинэлэг тал нь Монгол Улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотойгоор өмнө нь хийгдсэн эрдэм шинжилгээний бүтээл, судалгааны ажлыг нэгтгэн дүгнэж, цогц байдлаар тоймлон шинжилгээ хийсэнд оршино. Судалгаанд зөвхөн орчин үеийн нөхцөл байдлыг авч үзэхээс гадна мансууруулах бодисын хэрэглээний Монгол дахь түүхэн үүсэл, уламжлалт цээрлэл, эрх зүйн зохицуулалтын эх үүсвэрийг орчин цагийн бодит байдал, олон улсын чиг хандлагатай уялдуулан харьцуулсан нь онцлог шинжийг бүрдүүлж байна. Мөн хөрш орнуудын бодит статистик мэдээлэл, эрх зүйн зохицуулалт, туршлага, тэмцлийн арга барилыг Монголын нөхцөл байдалтай харьцуулан дүн шинжилгээ хийснээр практик ач холбогдол бүхий үр дүн гаргах боломжийг бий болгосон. Түүнчлэн өсвөр үе, залуучуудын дунд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээг өдөөгч стресс, мэдээллийн орчин, соёлын дуурайл, эдийн засгийн хүндрэл зэрэг нийгэм, сэтгэл зүйн хүчин зүйлсийг тусгайлан авч үзсэн нь өмнөх судалгаанаас ялгарах онцлогтой. Үүн дээр үндэслэн хууль хяналт, эрүүл мэнд, боловсролын байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд шууд хэрэгжүүлж болохуйц шинжлэх ухааны үндэслэлтэй зөвлөмж боловсруулсан нь судалгааны ажлын практик ач холбогдлыг улам нэмэгдүүлж байгаа юм. Мөн энэхүү судалгаа нь цаашид энэ чиглэлээр хийх эрдэм шинжилгээний ажлын үндсэн чиглэл, арга зүйг тодорхойлох суурь баримт бичгийн шинж чанартайгаар шинжлэх ухаанд хувь нэмэр оруулж байгаа нь уг ажлын хамгийн том шинэлэг талд тооцогдоно.

1.4. Судалгааны арга зүй, түүвэрлэлт

Судалгааны ажлын арга зүйн үндэс нь танин мэдэхүйн диалектикийн арга бөгөөд задлан шинжлэх (анализ), нэгтгэн дүгнэх (синтез), харьцуулах, үзэгдлийг ерөнхийгөөс эхлэн нарийвчлан судлах (индукц), үзэгдлийг үр дүнгээс эргэж

мөшгөн судлах (дедукц), таамаглал дэвшүүлэх (гипотез), системт харьцуулалтын арга зүйг ашигласнаас гадна онол, арга зүйн тулгуур ойлголт, гол үзэл санаа, судалгааны үр дүнг нээн гаргахдаа шинжлэх ухааны дараах тусгай аргуудыг хэрэглэсэн болно.

- Баримт бичгийн шинжилгээний арга: Монгол Улсад болон олон улсын түвшинд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотойгоор боловсруулсан хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, стратеги, үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайлан, эрдэм шинжилгээний бүтээлийг системтэйгээр цуглуулан шинжилж, онолын суурь мэдээллийг бүрдүүлсэн.

- Харьцуулалт, жишиг судалгааны арга: Сэдвийн хүрээнд урьд бичигдсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, магистр, докторын судалгааны ажил, судалгааны тайлан, ном бүтээлийн ерөнхий агуулга, онцлог, үр дүнг харьцуулан авч үзсэн.

Баримт бичиг, эх сурвалжийн түүвэрлэлт – 2018-2024 оны жилийн хугацаанд Монгол Улсын оюутан, суралцагч, эрдэмтэн, судлаачдын бүтээлийг их, дээд сургуулиудын номын сан, цахим эх сурвалж, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын архиваас түүвэрлэн авсан.

1.5. Судалгааны ажлын эх сурвалж

Монгол Улсын хэмжээнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт явдал судлалын чиглэлээр бичигдсэн судалгааны бүтээлд үндэслэгдсэн болно. Үүнд:

- 1) ном, сурах бичиг, нэг сэдэвт бүтээл;
- 2) эрдмийн зэрэг горилсон бүтээл (доктор);
- 3) магистрын судалгааны ажил;
- 4) эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл;
- 5) суурь болон хэрэглээний судалгааны ажлууд багтсан болно.

1.6. Судалгааны хамрах хүрээ, хязгаарлалт

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвхөн 2018-2024 онд бичигдсэн эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлүүдийн хүрээнд судалгааг гүйцэтгэсэн болно.



МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТТЭЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ЯВДЛЫГ СУДАЛСАН БАЙДАЛ



2.1. Докторын зэрэг горилсон бүтээл

Сүүлийн жилүүдэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн улс орны үндэсний аюулгүй байдал, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжил, хүн амын эрүүл мэндэд учруулж буй аюул занал, хор уршгийн түвшин улам бүр нэмэгдэж байна. Энэхүү нийгмийн сөрөг үзэгдэл нь зөвхөн гэмт хэргийн гаралт, статистик үзүүлэлтээр илрэхээс гадна нийгмийн суурь бүтэц, гэр бүл, хамт олон, боловсролын болон амьдралын орчны тогтвортой байдалд гүнзгий нөлөө үзүүлж, нийгмийн сэтгэл зүйн дархлааг доройтуулах, залуучуудын амьдралын чанар, эрүүл мэндийн түвшнийг бууруулах зэрэг олон талт, урт хугацааны сөрөг үр дагавартайгаар илэрч байна.

Энэ төрлийн гэмт хэрэг нь нэг талаас хууль сахиулах байгууллагын илрүүлэлт, хяналт, мөрдөн шалгах үйл ажиллагааны үр нөлөөг сорьж, нөгөө талаас нийгмийн хөгжлийн гол нөөц болох залуучуудын ёс суртахуун, сэтгэл зүйн эрүүл мэнд, нийгмийн үнэт зүйлсийн тогтолцоонд нөлөөлдөг гэдгээрээ олон улсын түвшинд ч анхаарал татаж байна.

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC)-аас жил бүр гаргадаг дэлхийн тайланд дурдсанаар, дэлхий даяар мансууруулах бодисын хэрэглээ тогтмол өсөж байгаа бөгөөд үүний нөлөө нь хөгжиж буй улс орнуудад илүү хүчтэй илэрч байна. Энэ чиг хандлагаас Монгол Улс ангид бус бөгөөд сүүлийн арван жилд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн гаралт, холбогдогчдын тоо, залуучуудын дундах хэрэглээ, сэтгэцийн донтолтын түвшин тогтмол өсөх хандлагатай байгаа нь бодит эрсдэлийг нотолж байна.


Монгол Улсад энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл нь олон хүчин зүйлийн улмаас үүсдэг бөгөөд үүнд хууль эрх зүйн зохицуулалтын хийдэл, хуулийн хэрэгжилтийн үр нөлөө сул байх, хяналт-шинжилгээний тогтолцоо бүрэн төлөвшөөгүй байх, эмнэлгийн болон сэргээн засах үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал, урьдчилан сэргийлэх боловсролын ажил хангалтгүй зэрэг институцийн болон нийгмийн түвшний хүчин зүйлс нөлөөлж байна. Энэ нь энэ төрлийн гэмт хэргийг зөвхөн эрүүгийн эрх зүйн хүрээнд авч үзэхээс илүү өргөн — нийгмийн эрүүл мэнд, боловсрол, сэтгэл зүй, эдийн засгийн хөгжлийн бодлого, үндэсний аюулгүй байдлын хүрээнд хамтатган судлах шаардлагатайг илтгэнэ.

Иймд энэхүү сэдвийг шинжлэх ухаанд үндэслэн олон өнцгөөс судлан дүгнэх нь нийгмийн бодлого боловсруулах, хууль хэрэгжилтийг үнэлэх, төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, иргэдийн эрх зүйн боловсрол болон урьдчилан сэргийлэх соёлыг төлөвшүүлэх зэрэг бодит практик ач холбогдолтой юм. Өөрөөр хэлбэл, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийг бууруулах нь зөвхөн хуулийн сахилга баттай холбоотой асуудал бус, харин нийгмийн тогтвортой хөгжил, хүний хөгжлийн индекс, залуучуудын сэтгэл зүйн дархлаа, эрүүл амьдралын соёлыг хамгаалах үндэсний хэмжээний зорилт юм.

Сүүлийн долоон жилд энэ чиглэлээр хийгдсэн судалгааны бүтээлүүдийг авч үзвэл, Монгол Улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт явдал судлал нь харьцангуй олон талт, салбар хоорондын шинжтэй болж хөгжиж байна. Хууль эрх зүйн хүрээнд хийгдсэн судалгаанууд нь эрүүгийн хууль тогтоомж, ялын бодлого, хэрэгжилтийн онол-практикийн зөрчил, олон улсын эрх зүйн хэм хэмжээтэй нийцүүлэх асуудлыг голчлон авч үзсэн бол нийгмийн эрүүл мэнд, сэтгэл зүйн чиглэлийн судалгаанууд нь хэрэглээний түвшин, мэдлэг, хандлага, донтолтын шалтгаан, урьдчилан сэргийлэх боловсролын үр нөлөөг судалсан байна. Үүнээс гадна бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн дүн шинжилгээ хийсэн судалгаанууд төрийн байгууллагуудын уялдаа холбоо, институц хоорондын зохион байгуулалтын чадавх, мэдээллийн нэгдсэн сангийн төлөвшлийн түвшнийг тодорхойлсон байдаг.

Эдгээр судалгаанууд нь мансууруулах бодистой холбоотой гэмт явдал судлалын онол, арга зүйн суурийг тодорхой хэмжээнд бүрдүүлж, улмаар энэ асуудлыг шинжлэх ухааны судлагдахуун болгон гүнзгийрүүлэх суурийг тавьсан ч зарим чухал чиглэлд судалгааны хоосон орон зай байсаар байна. Тухайлбал, хэрэглэгч төвтэй буюу эрэлт талын нийгэм-сэтгэл зүйн судалгаа, сэргээн засах болон нийгэмд дахин нэгтгэх үйлчилгээний үр нөлөөний үнэлгээ, олон улсын хамтын ажиллагаа, хил дамнасан гэмт хэргийн бүтэц, технологийн хэрэгжилтийн судалгаа хомс байна. Мөн бодлогын хэрэгжилтийн чанарыг үнэлэх нотолгоонд суурилсан арга зүй, KPI-д суурилсан хяналт-шинжилгээний систем бүрэн төлөвшөөгүй байгаа нь судалгааны шинжлэх ухааны чанарт нөлөөлж байна.

График №1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт явдлын талаар докторын зэрэг горилсон нийт бүтээлийн харьцуулалтыг харуулав.



Иймд энэ төрлийн гэмт хэргийг судлах нь Монгол Улсад зөвхөн хуулийн болон нийгмийн шинжлэх ухааны асуудал биш, харин нийгмийн дархлаа, хүний

хөгжлийн баталгааг хамгаалах цогц судалгааны чиглэл байх шаардлагатай. Энэхүү чиглэлд хийгдэж буй академик судалгаануудыг уялдуулан нэгтгэж, онол, арга зүйн дүн шинжилгээ хийх, бодлогын түвшний нотолгоонд суурилсан зөвлөмж боловсруулах нь энэхүү судалгааны ажлын үндсэн зорилго юм. Үүний үр дүнд Монгол Улсад мансууруулах бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, нийгэм-эрүүл мэндийн нөлөөллийг цогц байдлаар тодорхойлох, хууль хэрэгжилтийн механизмыг шинжлэх ухааны үндэстэйгээр үнэлэх, цаашдын бодлого боловсруулахад шинжлэх ухааны үндэслэл бүхий санал, зөвлөмж гаргах боломж бүрдэх юм.



Б.Эрдэнэдалай, “Хар тамхитай тэмцэх байгууллагын үйл ажиллагааны хяналтад хийсэн дүн шинжилгээ”, Дотоод хэргийн их сургууль, 2023 он.

Энэхүү судалгааны ажилд Монгол Улсад хар тамхи, мансууруулах болон сэтгэгцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт нэмэгдэж, түүний хор хохирол болон нийгмийн аюул өсөж буйг үндэслэн, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа, тэр дундаа хар тамхитай тэмцэх байгууллагын үйл ажиллагааны хяналтын тогтолцооны онол, арга зүй, эрх зүйн орчныг цогцоор нь судлах шаардлагыг тулгамдсан асуудал болгон дэвшүүлжээ.

Судалгаанд байгууллагын үйл ажиллагааны хяналтын онолын суурь ойлголт, хяналтын хөгжил, чиг үүрэг, ангилал, мөн мансууруулах бодисын онцлог, ангилал, нийгэмд үзүүлж буй хор уршгийг авч үзсэн байх бөгөөд хууль сахиулах байгууллагын хяналтын үйл ажиллагаанд нөлөөлөх хүчин зүйлүүдийг дотоод, гадаад орчны шинжилгээний аргаар задлан шинжилжээ. Үүнээс гадна, олон улсын болон үндэсний эрх зүйн орчныг харьцуулан судалж, Монгол Улсын хууль тогтоомжийн давуу болон сул талыг тодорхойлсон байна. Судалгааны арга зүйд тоон ба чанарын шинжилгээ, хувьсагчдын хоорондын хамаарлын шинжилгээ, замын шинжилгээ болон асуумж, ярилцлага зэрэг аргыг хослуулан хэрэглэж, цагдаагийн алба хаагчид, багш, эцэг эхийн оролцоотойгоор хяналтын тогтолцооны бодит нөхцөлд суурилсан судалгааг гүйцэтгэсэн нь онцлог болжээ.

Судалгааны үр дүнд хар тамхитай тэмцэх байгууллагын хяналтын үйл ажиллагаа нь олон улсын эрх зүйн хэм хэмжээтэй тодорхой хэмжээгээр нийцэж байгаа боловч зарим чухал зохицуулалтыг орхигдуулсан, “имплементаци” буюу үндэсний хууль тогтоомжид бүрэн шингээгүй байдал ажиглагдсан бөгөөд байгууллагын үйл ажиллагааны журмыг нарийвчлан боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзжээ. Мөн судалгаагаар хяналтын тогтолцооны уялдаа сул, илрүүлэлтийн хувь бага, мэргэжлийн хүний нөөц болон техник, технологийн чадавх хангалтгүй байгаа нь хэрэгжилтийн үр нөлөөг бууруулж буйг тогтоосон байна.

Судалгааны ажлын гол дүгнэлт нь хар тамхитай тэмцэх байгууллагын үйл ажиллагааны хяналтыг зөвхөн хууль эрх зүйн хүрээнд бус, удирдлагын шинжлэх ухаан, менежментийн хяналтын онолд тулгуурлан судалж, шинжлэх ухааны үндэстэйгээр боловсронгуй болгох хэрэгтэй гэсэн санаа юм. Үүнтэй уялдан судалгааны ажлын саналд цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж буй стратеги төлөвлөгөөг өргөжүүлэн хэрэгжүүлэх, олон улсын эрх зүйн зарим хэм хэмжээг үндэсний хууль тогтоомжид тусгах, хар тамхитай тэмцэх байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах нарийвчилсан журам боловсруулах, хяналт-шинжилгээний тогтолцоог чанаржуулах, судалгаа-шинжилгээний бааз суурийг бэхжүүлэх зэрэг бодлогын түвшний зөвлөмжүүдийг боловсруулсан байна.

2.2. Магистрын зэрэг горилсон судалгааны ажил

АШУҮИС-д 2019 онд хамгаалсан “Мансуурах бодисын талаарх өсвөр үе, залуучуудын мэдлэг, хандлага, хэрэглээ” сэдэвт магистрын ажилд нийгмийн эрүүл мэнд, сэтгэл зүйн талаас нь буюу хэрэглээний талд төвлөрөн судалгаа хийсэн бөгөөд өсвөр үе, залуучуудын дунд мансууруулах бодисын талаарх мэдлэг хангалтгүй, хэрэглээний эрсдэл нэмэгдэж буй асуудлыг онцолжээ. Судалгааны дүгнэлтээр мэдлэгийн түвшин харилцан адилгүй, хандлага нь сөрөг нөлөөтэй, зарим бүлэгт хэрэглээний бодит туршлага байсан нь тогтоогдсон бөгөөд урьдчилан сэргийлэх сургалт, боловсролын хөтөлбөрийг өргөжүүлэх, эрт илрүүлэлт хийх механизмыг бий болгох шаардлагатай гэж санал дэвшүүлсэн байна.

Хууль сахиулахын их сургуульд хийгдсэн “Монгол Улс дахь мансуурах бодис, сэтгэцэд нөлөөт эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэргийн ял шийтгэл, тулгамдсан асуудал” сэдэвт магистрын ажилд эрүүгийн эрх зүй, шүүхийн практик болон ял оногдуулах бодлогын хүрээнд судалгаа хийж, 1986–2002 оны Эрүүгийн хуульд ял оногдуулахад жигд бус байдал гарсан, хэрэг бүрийн онцлогийг харгалзаагүй, зарим заалт олон улсын конвенцтой нийцээгүй гэдгийг тодорхойлжээ. Судалгааны дүгнэлтээр ижил төстэй хэргүүдэд ял оноохдоо ялгаа гарч байсныг харуулсан бөгөөд Эрүүгийн хуулийг олон улсын стандарттай нийцүүлэн шинэчлэх, ял оноох практикийг нэг мөр журамлах, прокурор, судлаачдын хамтарсан сургалтыг зохион байгуулахыг санал болгосон байна.

График №2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт явдлын талаар магистрын зэрэг горилсон нийт бүтээлийн харьцуулалтыг харуулав.



Харин 2017–2020 онд МУИС болон ШУТИС-д хийгдсэн “Хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдсан асуудал” сэдэвт дипломын ажилд хууль тогтоомжийн хэрэгжилт, бодлогын шинжилгээний талаас нь судалгаа хийж, хууль хэрэгжүүлэгч

байгууллагын чадавх сул, лабораторийн шинжилгээний хүчин чадал хязгаарлагдмал, хил дамнасан хамтын ажиллагаа хангалтгүй байгаа асуудлыг хөндсөн байна. Судалгааны дүгнэлтээр хууль тогтоомж бүрэн хэрэгжээгүйгээс мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэхэд үр нөлөө багатай гэж үзээд, хилийн хяналтыг сайжруулах, лабораторийн чадавхыг нэмэгдүүлэх, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг санал дэвшүүлжээ.

С.Чинзориг “Мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх зарим асуудал”, Отгонтэнгэр их сургууль, 2004 он.

2004 онд Отгонтэнгэр их сургуульд хамгаалсан “Мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх зарим асуудал” сэдэвт магистрын зэрэг горилсон судалгааны ажил нь Монгол Улсад энэ төрлийн гэмт хэргийн онол, практикийн тулгамдсан асуудлуудыг авч үзсэн байна. Уг судалгаанд мансууруулах бодисын хууль бус эргэлтээс үүдэн бий болж буй нийгмийн хор аюулыг тодорхойлж, уг гэмт хэргийг илрүүлэх үйл ажиллагаанд тусгай мэдлэг ашиглах хэрэгцээ шаардлагыг онцлон тэмдэглэсэн нь онолын ач холбогдолтой дүгнэлт болжээ. Мөн мансууруулах бодисын хууль бус эргэлтийг эрүүгийн хууль тогтоомжид тусган зохицуулсан түүхэн уламжлал, олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийг хангах эрх зүйн зохицуулалтын асуудлыг судалж, Монгол Улсын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатайг тодорхойлсон байна.

Судалгаанд онцлон тэмдэглэснээр мансууруулах бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх үйлдлийг таслан зогсоохын тулд Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрийн хэрэгжилт, хамтын ажиллагааны үр дүнг дээшлүүлэх нь чухал бөгөөд хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэхэд олон улсын хамтын ажиллагааны ач холбогдлыг онцлон харуулжээ. Үр дүнд нь эрх зүйн орчныг шинэчлэх, хууль сахиулах байгууллагын алба хаагчдыг мэргэшүүлэх, гадаад орнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэхэд гүйцэтгэх ажлын арга хэрэгслийн үр нөлөөг нэмэгдүүлэх, иж бүрэн шинжилгээ томилох, нотлох ажиллагааг боловсронгуй болгох шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.

Судалгааны гол санал, зөвлөмжүүдийн дотор хар тамхи, мансууруулах бодисын хууль бус хэрэглээ болон хил дамнасан гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэхийн тулд хяналт, удирдлагын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгож, хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх асуудлыг хариуцсан тусгай албан тушаал бий болгох хэрэгцээг тодорхойлсон байна. Мөн хууль бус эргэлт, хэрэглээг бууруулах, хяналт шалгалтын чанарыг дээшлүүлэх, мэргэжлийн ажилтнуудыг үе шаттайгаар бэлтгэх, сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг бүх түвшинд өргөжүүлэн хөгжүүлэх шаардлагатай гэж үзжээ. Түүнчлэн хүүхэд, залуучуудын дунд урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх замаар эрсдэлийг бууруулах, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, ялангуяа хил орчмын бүс нутагт хяналт, хамтын ажиллагааны тогтолцоог сайжруулах, тэмцлийн үр дүнтэй байдлыг хангахын тулд эдийн засаг, санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлэх шаардлагатайг судалгаанд онцлон дурдсан нь практик ач холбогдол бүхий чухал санал болж байна.

Т.Райса “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын хууль бус эргэлтийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт, түүнийг боловсронгуй болгох зарим асуудал” Отгонтэнгэр их сургууль. 2014 он.

2014 онд Отгонтэнгэр их сургуульд хамгаалсан “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын хууль бус эргэлтийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт, түүнийг боловсронгуй болгох зарим асуудал” сэдэвт магистрын зэрэг горилсон судалгааны ажил нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтыг онол, практикийн түвшинд судалж, олон улсын болон үндэсний зохицуулалтыг харьцуулан дүн шинжилгээ хийх замаар түүнийг боловсронгуй болгох арга замыг тодорхойлоход чиглэжээ. Судалгааны ажлын хүрээнд Монгол Улсад мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрдсэн хэдий ч практикт хэрэгжилт хангалтгүй, зарим талаараа хийдэл, давхардал, зөрчилдөөн байгааг илрүүлсэн байна.

Тодруулбал, Монгол Улсын Эрүүгийн хуульд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой үйлдлүүдийг хэт ерөнхий байдлаар хуульчилсан, зарим ноцтой шинжтэй үйлдлийг огт тусгаагүй нь эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг сулруулж, хууль хэрэгжүүлэх байгууллагуудын ажлын гүйцэтгэлд хүндрэл учруулж байгааг судалгаанд дүгнэжээ. Энэ нь олон улсын гэрээ, конвенц, тухайлбал, НҮБ-ын “Мансууруулах бодисын тухай 1961 оны Нэгдсэн конвенц”, “Сэтгэцэд нөлөөт бодисын тухай 1971 оны конвенц”, “Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг 1988 оны Венийн конвенц”-д нийцүүлэх шаардлагыг хангалтгүй болгож буйг онцолсон байна.

Судалгааны үр дүнд үндэслэн Монгол Улсад хэрэгжиж буй эрүүгийн хууль тогтоомжийг олон улсын эрх зүйн стандарт, гэрээ, конвенцтой уялдуулах, эрх зүйн хийдлийг арилгах, илүү нарийвчилсан зохицуулалт бий болгох шаардлагатай гэсэн санал, дүгнэлтийг дэвшүүлжээ. Тухайлбал, Эрүүгийн хууль болон түүнтэй уялдсан бусад салбар хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг илүү тодорхой, нэг мөр болгох, гэмт хэргийн илрүүлэлт, урьдчилан сэргийлэлт, шийдвэрлэлтийн чанарыг сайжруулах нь зүйтэй гэж үзсэн байна.

Ийнхүү уг судалгааны ажил нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдалд бодитой үнэлэлт өгч, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагыг онцлон тэмдэглэсэн төдийгүй хууль тогтоомжийн шинэчлэл хийхэд чиглэсэн санал дэвшүүлснээрээ онцлог болж байна (Т.Райса, 2014).

М.Жавхлантөгс “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хор хөнөөлөөс хүүхдийг урьдчилан сэргийлэх, түүний эрх зүйн зохицуулалтын зарим асуудал” Отгонтэнгэр их сургууль. 2014 он.

2015 онд Отгонтэнгэр их сургуульд хамгаалсан “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хор хөнөөлөөс хүүхдийг урьдчилан сэргийлэх, түүний эрх зүйн зохицуулалтын зарим асуудал” сэдэвт магистрын зэрэг горилсон

судалгааны ажил нь хүүхэд, өсвөр үеийг хар тамхи, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, түүний хор уршгаас хамгаалах асуудлыг эрх зүйн болон практик түвшинд авч үзсэн онцлогтой бүтээл юм. Судалгааны хүрээнд уг төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалт, хэрэглээний бодит нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх ажлын хэрэгжилт болон түүний тулгамдсан асуудлуудыг дүгнэж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатайг үндэслэлтэйгээр нотолжээ.

Тус судалгаанд 14-21 насны 300 гаруй залуучуудыг хамруулсан тандан судалгаа хийж, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээний түвшин, нийгмийн шалтгаан, орчны нөлөөллийг судалсан нь үр дүнтэй болж, өсвөр насныхны дунд хэрэглээ нэмэгдэх хандлага тодорхой хэмжээгээр илэрснийг тогтоосон байна. Судалгааны дүнгээс үзэхэд, хүүхэд, залуусын энэ төрлийн хэрэглээнд эцэг, эх, асран хамгаалагч болон ойр дотны хүмүүсийн архи, тамхины зүй бус хэрэглээ шууд болон шууд бусаар нөлөөлж байгаа нь онцгойлон тэмдэглэх асуудал болжээ. Энэ нь гэр бүл, орчны хүчин зүйлсийн сөрөг нөлөөлөлтэй уялдаж, хүүхэд багачуудыг мансууруулах бодисын хэрэглээ рүү татан оролцуулах эрсдэлийг нэмэгдүүлж буйг харуулсан байна.

Судалгааны ажлын явцад хууль тогтоомжийн түвшинд тодорхой хийдэл байгааг онцлон тэмдэглэжээ. Тухайлбал, 2002 онд батлагдан хэрэгжиж байсан Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлд “их, онц их хэмжээ” гэснийг тодорхой хэмжүүрээр нарийвчлан хуульчлах шаардлагатай байгааг, мөн олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу “мансууруулах бодисыг тараах, түгээх” үйлдлийг гэмт хэрэгт шууд тооцох, өөрөө хэрэглэх болон бусдад түгээх үйлдлийг ялгамжтайгаар хуульчлах хэрэгцээг дүгнэсэн байна. Үүнээс гадна мансууруулах эм, бодисын хор хөнөөлийг эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн түвшнээр нь ялган, ял шийтгэлийг оногдуулах зарчим нэвтрүүлэх, хүүхдийг хэрэглэх, түгээх үйл ажиллагаанд татан оролцуулах аливаа хэлбэрийн үйлдлийг эрүүгийн хуулиар тусгайлан гэмт хэрэгт тооцох шаардлагатай гэж дүгнэжээ.

Мөн “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль”-д заасан “хүүхдийг архи, тамхи, мансууруулах болон хордуулах бодис хэрэглэхэд татан оролцуулах” үйлдэлд эрүүгийн хариуцлага оногдуулах зохицуулалт хангалтгүй байгаа нь хуулийн хийдэлд тооцогдож байгааг тодотгожээ. Түүнчлэн “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль”-ийн 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь хэсэгт мансууруулах эм, бодисыг сурталчлах, түгээх, кино, дүрс бичлэг, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг хориглосон хэдий ч түүний хариуцлагын зохицуулалт сул байгаа тул цаашид чангатгах шаардлагатайг санал болгосон байна.

Энэхүү судалгааны ажил нь хүүхэд, өсвөр үеийг мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээнээс урьдчилан сэргийлэх ажлыг зөвхөн хууль сахиулах байгууллагын хүрээнд бус, олон нийтийг соён гэгээрүүлэх, мэдлэг боловсролыг нэмэгдүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог бэхжүүлэх замаар шинэ шатанд гаргах шаардлагатайг онцлон тэмдэглэсэнд ач холбогдол нь оршиж байна. Ийнхүү хүүхэд, өсвөр үеийг хар тамхи, мансууруулах бодисын хор хөнөөлөөс ангид байлгах эрх зүйн

зохицуулалт, бодлого, практик арга хэмжээг боловсронгуй болгох талаар суурь судалгаа хийж, цаашид хэрэгжүүлэх шаардлагатай бодлогын чиглэлийг тодорхойлсон бүтээл болсон байна (М.Жавхлантөгс, 2015 он).

М.Түмэннаст “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэргийг нотлох ажиллагааны онол, практикийн зарим асуудал” Отгонтэнгэр их сургууль. 2015 он.

2015 онд Отгонтэнгэр их сургуульд хамгаалсан “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэргийг нотлох ажиллагааны онол, практикийн зарим асуудал” сэдэвт магистрын зэрэг горилсон судалгааны ажил нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийг мөрдөн шалгах явцад нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, шалгах, үнэлэх ажиллагааны онцлог, тулгамдсан асуудлыг авч үзсэн байна. Судалгааны гол зорилго нь уг үйл ажиллагааг онол, практикийн түвшинд дүгнэн шинжилж, түүнийг боловсронгуй болгох арга замыг тодорхойлоход чиглэжээ.


Судалгааны үр дүнд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй лабораториудын чадавх харьцангуй хязгаарлагдмал бөгөөд зөвхөн цөөн нэр төрлийн мансууруулах бодист анхан шатны таних шинжилгээ хийх түвшинд байгааг тодорхойлсон байна. Энэ нөхцөл байдал нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн нотлох ажиллагаанд цогц, иж бүрэн шинжилгээ хийх боломжийг хязгаарлаж байгаа тул шинжилгээний чадавхыг өргөжүүлэх шаардлагатай гэж үзжээ. Тухайлбал, хими, гарын мөр, бичиг судлал, авиа бичлэгийн, биологийн, наркологийн, сэтгэц гэм судлалын болон полиграфийн зэрэг иж бүрэн шинжилгээ хийх, үүний зэрэгцээ үнэр судлалын шинжилгээг эрчимжүүлэх нь нотлох ажиллагааны найдвартай байдлыг хангахад чухал болохыг судалгаанд онцолсон байна.

Мөн судалгааны явцад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг нь үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэргийн шинжтэй тул зөвхөн дотоодын хууль сахиулах байгууллагын хүчин чармайлтаар бус, олон улсын хамтын ажиллагааны хүрээнд нэгдсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатайг дүгнэжээ.

Эдгээр дүгнэлтэд тулгуурлан судлаач шинжилгээний үйл ажиллагааг боловсронгуй болгох, лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, НҮБ-ын Мансууруулах бодист хяналт тавих хорооны зөвлөмжийг үндэслэн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай гэсэн саналыг дэвшүүлсэн байна. Үүнээс гадна төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын ажилтан, алба хаагчдыг анхан шат, албаны, давтан болон мэргэшүүлэх сургалтад тогтмол хамруулснаар энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ур чадвар, мэргэжлийн бэлтгэлийг дээшлүүлэхийг зөвлөжээ. Мөн олон улсын болон үндэсний хэмжээний төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон талт оролцоог хангах нь мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх ажлын үр нөлөөг нэмэгдүүлэхэд чухал болохыг судалгаанд онцлон тэмдэглэсэн байна (М.Түмэннаст, 2015).

2.3. Судалгааны тайлан

“Хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал”, Дотоод хэргийн их сургууль, 2016 он.



Энэхүү судалгааны ажилд Монгол Улсад хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргийн нөхцөл байдлыг олон улсын болон үндэсний эрх зүйн зохицуулалт, шүүхийн практик, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд нарийвчлан судалсан байна. Судалгаанд манай улсад 2002–2016 оны хооронд бүртгэгдсэн гэмт хэрэг, холбогдогчдын тоон мэдээлэл, төрлүүд, газар нутгийн байршил, шалтгаан нөхцөл, түүнчлэн эм, эмнэлгийн байгууллага, интернэт, хил дамнасан гэмт

бүлэглэлийн оролцоог авч үзжээ.


Асуудал болгон дэвшүүлсэн нь гэмт хэргийн гаралт жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа боловч тэмцэх бодлого нэгдмэл бус, илрүүлэх техник, боловсон хүчин, мэргэшсэн эмч, эмчилгээний тогтолцоо дутагдалтай, урьдчилан сэргийлэх сурталчилгаа хангалтгүй, олон улсын хамтын ажиллагаа сул байгаа явдал байв.

Судалгааны үр дүнд гэмт хэрэг голчлон залуучуудыг хамарч, ихэвчлэн интернэт болон хил дамнасан зохион байгуулалттай бүлэглэлүүдийн нөлөөгөөр тархаж, донтолт, хууль бус хэрэглээ нэмэгдэж байгаа нь тогтоогдсон. Үүнээс гадна шүүхийн практикт ял оногдуулахад жигд бус байдал гарч, нэг төрлийн хэрэгт ялгаатай шийдвэр гардаг болохыг тэмдэглэсэн байна.

Дүгнэлтэд нь гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын тогтолцоо бүрэн төлөвшөөгүй, төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоо сул байгаа нь гэмт хэргийн тоо буурахгүй өсөх хандлагатай байгааг онцолжээ. Санал болгосон зүйлсийн дотор үндэсний аюулгүй байдлын бодлоготой уялдуулсан стратеги боловсруулах, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, хил, гаалийн хяналт, илрүүлэх техник тоног төхөөрөмжийг сайжруулах, мэргэшсэн боловсон хүчин, наркологийн эмч, эмчилгээний төв байгуулах, урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг эмзэг бүлгийн иргэдэд чиглүүлэх зэрэг арга хэмжээг тусгажээ.

Онцлог нь энэ судалгаанд зөвхөн хууль зүйн тал төдийгүй нийгмийн шалтгаан, эмнэлгийн орчны сул тал, олон улсын туршлага, статистик тоон мэдээллийг хослуулан цогц байдлаар авч үзсэнд оршиж байна. Энэхүү “Хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал” судалгаанд Монгол Улсад энэ төрлийн гэмт хэрэг өсөж буйг бодлогын түвшний сул талтай (нэгдсэн бодлого, хөтөлбөр, эрх зүйн орчин хангалтгүй) холбон асуудал болгон дэвшүүлж, нөхцөлд нөлөөлөх хүчин зүйлсийг гурван чиглэлээр ангилж үнэлсэн нь онцлог юм. Судалгаанд, нэгт дотоодын

шалтгаан талаас мансууруулах үйлчилгээтэй ургамлын тархац их бөгөөд цагдаагийн байгууллагад бүртгэгддэг энэ төрлийн гэмт хэргийн 50–60 хувийг ургамалтай холбоотой хэрэг эзэлж байгааг тодотгож, хоёрт гадаад орчны нөлөөгөөр Зүүн өмнөд Ази болон хил залгаа БНХАУ-аас амфетамин, метамфетамин зэрэг синтетик бодис шуудан, хилээр дамжин нэвтрэх, борлуулагдах, хэрэглэх явдал нэмэгдэж буй хандлагыг харуулж, гуравт олон улсын шуудангийн сувгийн ашиглалт идэвхжиж байгааг тэмдэглэсэн; эдгээр нь нийлбэрээрээ манай улсын хууль бус эргэлттэй тэмцэх чадавх, уялдаа холбооны сул талыг ил болгож байна гэж үзжээ. Судалгааг 2016 онд хууль судлалын хүрээнд явуулж, баримт бичгийн болон социологийн, түүнчлэн харьцуулалт, задлан шинжилгээ, нэгтгэн дүгнэх аргыг хослуулсан бөгөөд гүйцэтгэгчээр Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Цагдаа судлалын төв ажилласан нь институц хоорондын (хууль сахиулах–эрүүл мэнд–бодлого) өгөг, нотолгоог нэгтгэн авч үзэх боломж олгосон. Судалгааны дүгнэлтээр манай улсад хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд төрийн байгууллагуудын уялдаа холбоо сул, нэгдмэл бодлого үгүйлэгдэж байгаа нь эрсдэлийг бууруулах механизмыг сулруулж байгааг онцолж, үүнийг арилгахын тулд төрийн нэгдсэн бодлогоор зангидсан стратеги хэрэгжүүлэх, хил ба гаалийн хяналт, илрүүлэх техник тоног төхөөрөмжийг сайжруулах, мэргэшсэн хүний нөөц, эмчилгээ–сэргээн засах бүтэц бий болгох, мөн эмзэг бүлэг рүү чиглэсэн урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийн ажлыг тогтолцоотой өргөжүүлэхийг санал болгожээ. Уг бүтээлийн онцлог нь нэг талын (зөвхөн эрүүгийн эрх зүй эсвэл зөвхөн эрүүл мэнд) биш, харин газар зүйн тархац (ургамал), дамжин нэвтрэх суваг (шуудан, хил), зах зээлийн бүтэц (синтетик бодисын урсгал), засаглалын хүчин зүйл (нэгдсэн бодлого, уялдаа холбоо) зэрэг олон өнцгийг хамтатган, аргын хувьд баримт бичгийн ба социологийн нотолгоог хослуулан цогц үнэлгээ хийсэнд оршино.



“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих Үндэсний хөтөлбөрт хийсэн дүн шинжилгээ”, Independent research institute of Mongolia - IRIM судалгааны хүрээлэн, 2018.

Энэхүү судалгааны тайлан нь Монгол Улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хэрэглээ, түүнтэй холбоотой гэмт хэргийн гаралтыг багцлан авч үзсэн үндэсний түвшний үнэлгээ бөгөөд судалгааны төв зорилго нь 2002 оны “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай” хууль болон 2017 онд батлагдсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн I үе шат (2017–2019)–

ийн хэрэгжилтийн бодит байдал, давуу болон сул талыг дүрслэн тогтоох, хуулийн болон бодлогын баримт бичгүүд хоорондын уялдаа, давхардал, зөрчил, хэрэгжилтийн саад тотгорыг илрүүлэн цаашид баримтлах бодлогын зөвлөмж боловсруулахад оршиж байна. Судалгааны хүрээнд тулгамдаж буй өргөн цар хүрээтэй асуудлуудыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодруулах зорилгоор уг тайлан нь эрх зүйн баримт бичгийн судалгаа, байгууллагын институтийн дүн шинжилгээ, төрийн салбарын мэргэжлийн албан хаагчдын фокус бүлэг, ганцаарчилсан ярилцлага, олон нийтийн тандалт зэрэг аргуудыг нэгтгэн хэрэгжүүлсэн бөгөөд эдгээр аргуудын хосолсон хэрэглээ нь судалгааны өгөгдлийг хууль зүйн үндэслэл, албан ёсны статистик, мэргэжлийн ажиглалт болон олон нийтийн мэдлэг, хандлагатай нийцүүлэн дүгнэх боломжийг бүрдүүлсэн байна.

Судалгаанд ашигласан арга зүй нь олон эх сурвалжид тулгуурласан холистик шинжилгээ бөгөөд баримт бичгийн судалгаагаар олон улсын конвенцууд, Үндэсний хөтөлбөр, хуулиуд, Засгийн газрын тогтоол, яам, агентлагийн тушаал, салбарын стандарт зэрэг эрх зүйн баримт бичгүүдийг хамруулан уялдуулсан дүн шинжилгээ хийгдэж, байгууллагуудын статистик мэдээлэл (цагдаагийн илрүүлэлт, шүүхийн шийдвэр, СЭМҮТ-д хэвтэн эмчлүүлсэн иргэдийн бүртгэл, лаборатори шинжилгээний тоон үзүүлэлт гэх мэт)–ийг хураан авч тоон судалгаа боловсруулагдсан байна.

Түүнчлэн мэргэжлийн фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагаар байгууллагын бодлого хэрэгжүүлэх чадвар, уялдаа холбоо, хүний нөөц, техник, санхүүгийн боломж, мэдээллийн хүртээмж, сургалтын хэрэгцээ зэргийг чанартайгаар гүнзгийрүүлэн шинжилсэн ба олон нийтийн тэсвэрт судалгаагаар (тандалт) Улаанбаатар хотын дөрвөн дүүрэгт суурилсан 200 хариулт бүхий асуумж ашиглан иргэдийн мэдлэг, ойлголт, хандлагыг тогтоон хуулийн болон урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүртээмж, нийтийн дэмжлэгийн түвшнийг үнэлж, цуглуулсан өгөгдлийг SPSS программаар боловсруулах замаар статистик шинжилгээ хийсэн нь судалгааны үр дүнгийн бодит суурийг бататгасан.

Судалгаагаар илэрсэн гол асуудлууд нь гурван том бүлэгт төвлөрч байна: эхнийх нь, эрх зүйн орчны хийдэл бөгөөд 2002 оны хууль болон түүнийг дагалдах журмууд, Засгийн газрын тогтоолууд хооронд зөрчил, хуулийн хориглосон үйлдлүүдийг Эрүүгийн болон Зөрчлийн хуульд тодорхой тусгаагүй, зарим журам нь хуулиас давсан зохицуулалттай байх зэрэг нь хэрэгжилтийн толгойг мушгиж, хариуцлагын тодорхой бус байдал үүсгэж байгааг тодруулсан; хоёрдугаарт, институц, зохион байгуулалтын дутагдал бөгөөд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх, үүргийг тодорхой, нэгдмэл хэрэгжүүлэх чадамж бүхий төв байгууллага, мэдээллийн нэгдсэн сан, хамтын ажиллагааны тогтолцоо дутагдаж байгаа нь салбар хоорондын уялдаа холбоог сулруулж, бодлого бодит гүйцэтгэлд шилжихэд саад болж байгаа; гурав дахь нь, практик түвшний бөгөөд хил, гаалийн хяналтад шаардлагатай илрүүлэх техник-төхөөрөмж, мэргэжлийн чадавх, лаборатори тестийн хүртээмж дутмаг, эмнэлгийн тусламж үйлчилгээ, сэргэн засах төвүүд цөөн, мансууруулах бодистой холбоотой сэтгэцийн тусламж, наркологи, нөхөн сэргээх үйлчилгээ нийлмэл байдлаар хангагдаагүй нь

хэрэглэгч-донтогчдод үзүүлэх тусламжийн хоцрогдол ба гэмт хэрэг дахин давтагдахад нөлөөлж байна гэж үзжээ.

Тайлан нь мөн мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг, илрүүлэлт, хэрэглээний динамикийг баримттайгаар дүрслэн үзүүлсэн бөгөөд цуглуулсан тоон мэдээллүүдээр 2008–2018 оны хооронд энэ төрлийн гэмт хэргийн гаралт эрс өссөн (зарим эх сурвалжаар хэдэн дахин өссөн гэж тэмдэглэгдсэн) ба гэмт хэрэгт холбогдогчдын хувьд 18–35 насны бүлэг зонхилсон, ажилгүй байдал нь өндөр хувьтай, сурагч, оюутнууд дунд түгээмэл байдал нэмэгдэж байгаа зэрэг нь энэхүү асуудлын нийгэмд үзүүлэх өнцгийг илэрхийлж байна. Мөн эдгээр ололт нь урьдчилан сэргийлэх, боловсрол, ажил эрхлэлт, хүүхэд-залуучуудын чөлөөт цагийн зохион байгуулалт, гэр бүл-нийтийн орчин зэрэг олон салбарын нөлөөллийг нэгтгэн авч үзэх шаардлагатайг нотолж байна.

Энэхүү судалгааны шинэлэг тал нь асуудлыг зөвхөн хууль зүйн ба захиргааны хэмжээнд бус, нийгмийн ойлголт, байгууллагын чадавх, клиникийн тусламжийн хүртээмж болон олон улсын конвенцын шаардлагатай нийцэл зэрэг олон тэнхлэг дээр нэгэн зэрэг үнэлсэн явдалд оршиж, энэ нь бодлого боловсруулагчдад асуудлыг иж бүрнээр ойлгон дараагийн үйл ажиллагаа, санхүүгийн эх үүсвэр, хүний нөөцийн шаардлагыг нарийн тогтоох боломжийг олгоход чиглэсэн байна. Нэмэлт дүгнэлтээр, эмнэлгийн стандартуудын шинэчлэл (жишээ нь наркологийн болон сэтгэцийн эмчилгээний MNS стандартыг боловсруулж баталсан үйл явц) нь клиник практикт шилжүүлэхэд дэмжлэг болно гэдгийг онцолж, эдгээр стандартыг бодит төвүүдэд хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэжлийн хүний нөөцийн бэлтгэл, санхүү, логиستيкийн бүтэц дутмаг хэвээр байгааг тэмдэглэжээ.


Судалгааны үндсэн үр дүн, дүгнэлт нь тодорхой бөгөөд үүний дотор эрх зүйн шинэчлэл шаардлагатайг онцолсон бөгөөд тэр дундаа 2002 оны хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ тулгарч байгаа нь голлох байр суурь эзэлж байна.

Холбогдох хууль тогтоомжийн хооронд үүссэн зөрчлийг арилгах, хариуцлагын институцийг нэгтгэх үүднээс Засгийн газрын түвшинд буюу Ерөнхий сайдын дэргэд хар тамхитай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах нэгтгэн чиглүүлэх байгууллага байгуулах санал дэвшүүлсэн нь институцийн зохион байгуулалтын шинэчлэлийн шинжтэй практик санал юм. Мөн хяналт-мэдээллийн нэгдсэн сан, KPI-тэд суурилсан үнэлгээний механизмыг нэвтрүүлэх, Үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагаа тус бүрд оновчтой, хэмжигдэх шалгуур үзүүлэлтийг тодорхойлох шаардлагыг онцлон тэмдэглэсэн.

Тайлан нь цаашид тэргүүлэх санал, зөвлөмж болгон хууль тогтоомжийг олон улсын конвенц, шилдэг жишигт нийцүүлэн шинэчлэх, ял шийтгэлийн бодлогыг бодит нөхцөлд тааруулан ялгамжтай, урьдчилан сэргийлэх ба эмчилгээнд чиглэсэн шийтгэлийн зохицуулалтыг тусгасан хэлбэрт шилжүүлэх, хил, гаалийн хяналтад илрүүлэх техник-төхөөрөмжийн хангалтыг сайжруулах, мэргэжилтнүүдийг тасралтгүй, шаталсан тогтолцоогоор бэлтгэх, СЭМҮТ болон нөхөн сэргээх төвүүдийн сүлжээг өргөтгөх, иргэний нийгмийн байгууллагуудыг үйл ажиллагаанд тогтмол оролцуулах эдийн засаг-зохион байгуулалтын

механизм бий болгох, олон нийтийн эрх зүйн боловсрол, эмийн зөв зохистой хэрэглээний талаарх мэдээллийг боловсролын хөтөлбөр, хэвлэл мэдээлэл, цахим платформуудаар тогтмол түгээх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхийг санал болгосон байна. Эдгээр зөвлөмжүүд нь судалгааны өгөгдөлд тулгуурласан, хэмжигдэхүйц үр дүнг бий болгоход чиглэсэн бодлого-үйлдлийн холбоосыг бататгах зорилготой байна.

Энэхүү судалгаа нь онол ба практик талуудыг холбосон шинжтэй бөгөөд мансууруулах бодистой холбоотой асуудлыг олон салбарт нөлөөлөх урт хугацааны аюул гэж үзэн, түүнийг багасгах, илрүүлэх, эмчлэх, сэргээх тогтолцоог иж бүрнээр бэхжүүлэхэд чиглэх бодлогын шийдвэр гаргахад шаардлагатай нарийвчилсан мэдээлэл, аргуудыг санал болгосон тул судалгаа нь Монгол Улсын энэ салбарт хийх бодит, хэмжигдэх ажил, төсвийн тооцоо, хүний нөөцийн бэлтгэл, олон улсын хамтын ажиллагааны түншлэлийг тодорхойлох хамгийн чухал эх сурвалж болохоор дүгнэж болно.



“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн дунд хугацааны үнэлгээ”, Эс Ай Си Эй (SICA) ХХК, 2020 он.

Энэхүү судалгааны тайлан нь “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 2017–2019 онд хэрэгжүүлсэн нэгдүгээр үе шатыг дунд хугацаанд үнэлэх зорилготой судалгааны үр дүнг системтэй тооцоолол, баримт бичгийн шинжилгээ болон чанарын судалгааны аргыг хослуулан гаргаж өгсөн дүнгээр өргөн хүрээнд дүгнэсэн бөгөөд үнэлгээний үндсэн зорилго нь хөтөлбөрийн зорилго, зорилтуудад тусгагдсан үйл ажиллагааны хэрэгжилт зорилтот түвшинд хүрсэн эсэхийг тогтоож, цаашид хэрэгжүүлэх бодлого, зохион

байгуулалт, санхүү, хүний нөөцийн төрөлжсөн санал зөвлөмж боловсруулахад оршино, үүний тулд судалгаанд холбогдох төрийн байгууллага болон иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүдтэй ганцаарчилсан ярилцлага явуулж, холбогдох хууль, журам, хөтөлбөрийн баримт бичгүүд, салбарын тайлан, статистик мэдээллийг баримт бичгийн судалгаагаар цуглуулан шинжилсэн арга зүйг хэрэглэсэн байна. Мөн үнэлгээний аргачлал нь Засгийн газрын “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын заалтуудад нийцүүлэн зорилтуудыг “үр дүнтэй”, “тодорхой үр дүнд хүрсэн”, “эрчимжүүлэх шаардлагатай”, “үр дүнгүй” зэрэг ангиллаар тооцсон нь үнэлгээний бодит байдал, харьцуулалтыг хангах үүднээс оновчтой зохион байгуулалттай болсноороо шинжлэх ухааны үндэслэлтэйгээр үнэлгээ хийх боломжийг бүрдүүлжээ.

Судалгааны явцад тогтоогдсон өнөөгийн нөхцөл байдал нь Монгол Улсын хэмжээнд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, түүнтэй холбоотой гэмт хэрэгт холбогдох үзүүлэлтүүд сүүлийн жилүүдэд тодорхой өсөлттэй байгааг баримтаар нотолж, уг өсөлт нь системтэй олон тулгуурт хандлага шаардаж байгааг харуулсан байна. Тухайлбал 2015 оноос 2019 оны 12-р сарын байдлаар мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн тоо 49-ээс 276 болж 5.6 дахин өссөн бөгөөд уг гэмт хэрэгт холбогдон шалгагдсан хүний тоо 169-с 415 болсон байдал, гэмт хэрэгт холбогдогчдын насны бүтцэд 19–35 насныхан давамгайлж, нийт холбогдогчдын 82.5 хувь нь 19–35 насанд орж байгааг, гэмт хэрэгт холбогдсон иргэдийн дийлэнх нь ажилгүй эсвэл хувийн хэвшилд эрхэлдэг, оюутан, сурагчдын оролцоо өсөх хандлагатай байгааг статистик талаас тодорхойлсон нь хөтөлбөрийн оновчтой чиглэл, урьдчилан сэргийлэх хяналтыг эрчимжүүлэх шаардлагыг илтгэж байна. Дээрхээс гадна эмнэлгийн тусламж үйлчилгээ, сэтгэл заслын тусламжийн үзүүлэлт болон шинжилгээний хүртээмж, тухайлбал 2019 оны 10-р сарын байдлаар ШШҮХ-д 1,364 шинжилгээ хийгдсэн нь 2017 оныхоос 35.8 хувь өссөн зэрэг үзүүлэлтүүд нь хяналт, оношилгооны хүчин чадал сайжирч буйг харуулж байгаа ч одоогийн нөөц, байгууллагын уялдаа холбоо, мэдээллийн нэгдсэн сантай холбоотой сул талыг мөн тодруулсан байна.

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний иж бүрэн тооцоогоор хөтөлбөрийн ерөнхий хэрэгжилт 82.2 хувиар үнэлэгдэж “тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэгдсэн бөгөөд хөтөлбөрийн таван үндсэн зорилтын тус бүр тусгайлан үнэлэгдэж, нэгдүгээр зорилт буюу эрх зүйн орчныг боловсронгуй болгох тал 87 хувиар, хоёрдугаар зорилт буюу төрийн байгууллагуудыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах тал 81.7 хувиар, гуравдугаар зорилт буюу иргэдийн соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах тал 84.7 хувиар, дөрөвдүгээр зорилт буюу шалтгаан нөхцөлийг судлах, арилгах арга замыг тодорхойлох тал 76.4 хувиар, тавдугаар зорилт буюу мэргэшүүлэлт, техник-технологийн шинэчлэлд бэлтгэх тал 72.6 хувиар тус тус үнэлэгдсэн нь зарим чиглэлд амжилттай бодлого хэрэгжсэн атлаа хүний нөөц, технологи, уялдаа холбоо, санхүүжилтийн талаар цаашид анхаарал хэрэгтэйг харуулсан байна. Мөн хөтөлбөрт тусгагдсан 41 үйл ажиллагаанаас 11-ийг “үр дүнтэй”, 24-ийг “тодорхой үр дүнд хүрсэн”, 6-г “эрчимжүүлэх шаардлагатай” гэх ангиллаар тодорхойлон шинжилсэн нь бодлогын түвшинд ямар чиглэлүүдийг бэхжүүлэх шаардлагатайг нарийн задалж өгсөн байна.

Судалгааны онцлог, шинэлэг тал нь үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зөвхөн хууль, эрх зүйн хүрээнд нэг өнцгөөс хянаж дүгнэхгүйгээр салбарын өнөөгийн нөхцөл байдал - гэмт хэргийн статистик, эмнэлгийн хэмжигдэхүүн, шинжилгээний хүчин чадал, хүүхэд-залуучуудын оролцоо, төр-иргэний нийгмийн байгууллагын уялдаа холбоо болон олон улсын хамтын ажиллагааны байдлыг нэгтгэн олон салбар дамнасан, чанарын болон баримт, бичгийн шинжилгээнд тулгуурлан үнэлсэн явдалд оршино; түүнчлэн эмнэлгийн мэргэжлийн стандартууд (MNS 5396-3-аас MNS 5396-10 хүртэл болон опиоидийн орлуулах эмчилгээний стандартууд) шинэчлэгдэн батлагдсан байдал нь клиник-оношилгоо, эмчилгээний стандартын түвшнийг сайжруулахад дэмжлэг үзүүлсэн ч эдгээр стандартуудыг өвчтөнд ойртуулан хэрэгжүүлэх, эсхүл тусламжийн

багийг тухайн үйлчилгээний төвүүдэд бүрдүүлэх, санхүү, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах шаардлагатай байгааг тодорхой илэрхийлжээ.

Тайланд гаргасан дүгнэлт, бодлогоор дамжуулан судалгаагаар тодорхойлогдсон гол үр дүн, дүгнэлт нь дараах үндсэн чиглэлүүдийг хамарч байна:

- нэг, эрх зүйн орчныг цаашид нарийвчлан сайжруулж, ашиглагдаж буй хуулийн шинэчлэлүүдийг хэрэгжүүлэх, ялын бодлогыг бодит нөхцөл-үр дүнтэй уялдуулах;

- хоёр, салбар дундын уялдаа холбоог бэхжүүлэх, ялангуяа төрийн байгууллагууд болон иргэний нийгмийн байгууллагууд хоорондын мэдээлэл солилцоо, хамтын ажиллагааг тогтмол байлгах, мэдээллийн нэгдсэн санд түшиглэсэн мониторинг, үнэлгээний тогтолцоо байгуулах;

- гурав, урьдчилан сэргийлэх болон иргэдийг соён гэгээрүүлэх ажлыг зорилтот бүлгүүд, ялангуяа 19–35 насны залуучууд, сургуулийн насны хүүхдүүд рүү чиглэсэн, үр дүнтэй аргуудтай хийж, боловсролын байгууллагуудтай уялдуулан программ хэрэгжүүлэх;

- дөрөв, эмнэлгийн тусламж, сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ, сэргэн засах төвийн хүртээмж, чанарыг сайжруулах, мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх болон шинжилгээ, лабораторийн чадавхыг нэмэгдүүлэх;

- тав, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлж, хил орчмын хяналтыг сайжруулах замаар дамжуулан орж ирж буй зориулалтын бодисын урсгалыг хязгаарлах зэрэг санал зөвлөмжийг тайлан дэвшүүлсэн бөгөөд эдгээр саналуудыг хэрэгжүүлэхэд тодорхой шалгуур үзүүлэлт, гүйцэтгэлийг хэмжиж болох KPI-г хөтөлбөрийн дараагийн шатанд суулгах шаардлагатайг онцлон санал болгожээ.

Эцэст нь, энэхүү дунд хугацааны үнэлгээ нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын асуудлыг олон салбарын хамтын ажиллагаа, нийгмийн эрүүл мэндийн хандлага, хууль эрх зүйн зохицуулалт, клиник үйлчилгээний стандарт зэрэг олон түвшинд нэгтгэн шинжилж, бодлого боловсруулагчид, хэрэгжүүлэгч төрийн байгууллагууд болон иргэний нийгмийн байгууллагуудад тодорхой, хэрэгжихүйц санал зөвлөмжийг нэгтгэн өгсөн бөгөөд тус тайлан нь хөтөлбөрийн дараагийн үе шатанд хэрэгжүүлэх арга хэмжээг илүү зорилтод, хэмжигдэхүйц болгоход хэрэглэгдэх үнэлгээний практик хэрэгсэл болж чадна хэмээн судалгааны баг дүгнэн тайландаа санал болгосон байна.



“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ”, Эс Ай Си Эй (SICA) ХХК, 2023 он.

Энэхүү судалгааны ажил нь Монгол Улсад 2017 оноос хэрэгжиж эхэлсэн “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн бодит байдлыг шинжлэх ухааны үндэстэйгээр үнэлж, үр нөлөө, үр дүнг тооцох, цаашдын бодлого, үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилготой хийгдсэн иж бүрэн судалгаа байна. Судалгаагаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хэрэглээ, түүнд холбогдох гэмт хэрэг, нийгмийн хор уршгийн өнөөгийн нөхцөл байдлыг дүгнэж, үндэсний

хөтөлбөрийн хэрэгжилтийн түвшнийг үнэлэх, үр нөлөөг тодорхойлох, холбогдох байгууллагуудын уялдаа холбоо, зохион байгуулалтын үр ашигт байдлыг судалсан байх бөгөөд энэ нь мансууруулах бодистой холбоотой нийгмийн аюулын бодит дүр төрхийг харуулсан цогц судалгаа болсон гэж үзэж болохоор байна.

Судалгааны үндсэн зорилго нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр хэрэгжиж буй бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн түвшин, үр нөлөөг тодорхойлох, хөтөлбөрийн таван зорилт, дөчин нэгэн үйл ажиллагаа тус бүрийн хэрэгжилт, үр дүн, үр нөлөөг тооцох, түүний үндсэн дээр бодлогын санал, зөвлөмж боловсруулахад чиглэсэн байна. Энэхүү зорилгын хүрээнд судалгааны баг нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, мөн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас (OECD-DAC) гаргасан бодлогын үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг ашиглаж, бодлогын хэрэгжилтийн үр дүнтэй, үр нөлөөтэй, тогтвортой байдлыг дүгнэх арга зүйг нэвтрүүлжээ.

Судалгааны арга зүйн хувьд анхдагч ба хоёрдогч мэдээллийн эх үүсвэрийг хослуулсан бөгөөд чанарын болон тоон аргуудыг хослуулсан холимог судалгааны хэлбэрийг ашигласан байна. Анхдагч мэдээллийг төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, мэргэжлийн байгууллагуудын ажилтнууд, холбогдох төрийн захиргааны байгууллагуудын удирдлагууд, хөтөлбөрийн хэрэгжилтэд оролцогч албан хаагчидтай хийсэн ганцаарчилсан ярилцлага, цахим судалгаа, олон нийтийн санал асуулгаар цуглуулсан бол хоёрдогч мэдээлэлд хууль, бодлогын баримт бичгүүд, статистик тайлан, өмнөх жилүүдийн хяналт-шинжилгээ, судалгааны дүн шинжилгээг багтаасан байна. Судалгаанд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Эрүүл

мэндийн яам, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Гаалийн ерөнхий газар, Гадаад харилцааны яам, Хил хамгаалах ерөнхий газар зэрэг байгууллагуудын төлөөлөл оролцсон бөгөөд эдгээр байгууллагуудын өгсөн мэдээлэл, үзэл бодол, туршлагад үндэслэн хөтөлбөрийн хэрэгжилтийн бодит байдлыг олон талт байдлаар үнэлсэн байна.

Судалгааны мэдээллийн чанар, найдвартай байдлыг хангах үүднээс мэдээлэл цуглуулах, шивэх, боловсруулалтын бүх үе шатанд давхар хяналт, баталгаажуулалт хийсэн бөгөөд дуу хураагуур ашиглан ярилцлагыг бичиж, дахин сонсож баталгаажуулах, өгөгдлийн логик алдаа шалгах, ярилцлага авсан судлаачаар агуулгын давхцал, орхигдлыг шалгах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь судалгааны үр дүнг шинжлэх ухааны түвшинд хүргэхэд чухал ач холбогдолтой болсон гэж үзэж байна.

Судалгааны явцад хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн тоо сүүлийн таван жилд өссөн хандлагатай байгаа бөгөөд холбогдогчдын дийлэнхийг 18-35 насны залуус эзэлж байна. Мөн гадаад улсад энэ төрлийн гэмт хэрэгт холбогдсон Монгол Улсын иргэдийн тоо нэмэгдэж буй нь үндэсний хэмжээнд урьдчилан сэргийлэх бодлого, мэдээлэл, боловсролын ажлыг эрчимжүүлэх шаардлагатайг харуулжээ. Эрүүл мэндийн салбарын хувьд, донтох эмгэгтэй иргэдийн тоо өсөж байгаа нь сэтгэцийн эмгэгийн оношилгоо, эмчилгээний хүртээмж, хяналтыг сайжруулах хэрэгцээ байгааг илтгэж байна.

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний үр дүнгээр зарим зорилт тодорхой үр дүнд хүрсэн, байгууллагуудын хамтын ажиллагаа, хүний нөөцийн чадавх сайжирсан, хууль, эрх зүйн шинэчлэл хийгдсэн зэрэг эерэг өөрчлөлт гарсан боловч, хэрэгжилтийн түвшин жигд бус, зарим арга хэмжээ хангалтгүй хэрэгжсэн, хөтөлбөрийн үр нөлөөг хэмжих үзүүлэлтүүд тодорхой бус, мэдээллийн сангийн уялдаа сул, хяналт-шинжилгээний тогтолцоо бүрэн төлөвшөөгүй зэрэг хүндрэлтэй асуудлууд илэрсэн байна.


Судалгааны үр дүн нь бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг үр нөлөөний үүднээс нарийвчлан тооцсон анхны иж бүрэн үнэлгээ болсон бөгөөд шинэлэг тал нь хөгжлийн бодлого, стратегийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний олон улсын аргачлалыг (OECD-DAC) үндэсний түвшинд нутагшуулж, бодлогын хэрэгжилтийн дүнг тоон болон чанарын хосолсон үзүүлэлтээр хэмжсэн явдал юм. Энэ нь Монгол Улсад бодлогын үр нөлөөг системтэй хэмжих, нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтыг хөгжүүлэхэд бодит хувь нэмэр оруулсан байна.

Судалгааны багийн гаргасан дүгнэлтээр, хөтөлбөр нь үндэсний хэмжээнд мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх бодлогын уялдаа холбоог тодорхой хэмжээгээр сайжруулж, төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, олон нийтийн мэдлэг, ойлголтод эерэг нөлөө үзүүлсэн боловч бодлогын хэрэгжилтийн тогтвортой байдлыг хангах эрх зүйн болон институцийн үндэс хангалтгүй, нийгмийн зорилтот бүлгүүдийн оролцоо сул байгааг онцлон тэмдэглэжээ.

Дүгнэлтэд үндэслэн дараах гол санал, зөвлөмжийг боловсруулсан байна.
Үүнд:

- Үндэсний хөтөлбөрийг дунд хугацааны зорилго, хэмжүүртэйгээр шинэчлэн боловсруулах;
- Хэрэгжилтийн хяналт-шинжилгээний тогтолцоог сайжруулж, мэдээллийн нэгдсэн сан байгуулах;
- Хөтөлбөрийн хүрээнд урьдчилан сэргийлэх ажлыг сургалт, мэдээлэл, олон нийтийн нөлөөллийн бодлогоор нэгтгэн хэрэгжүүлэх;
- Сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Хууль сахиулах байгууллагын техникийн болон хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх;
- Судалгаа, шинжилгээний тогтолцоог тогтмолжуулах зэрэг санал багтсан байна.

Ийнхүү уг судалгаа нь мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний бодлогын хэрэгжилтийн бодит байдлыг нотолгоонд тулгуурлан тодорхойлж, цаашдын бодлого боловсруулах, хууль эрх зүйн орчныг сайжруулах, урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулахад онол, практикийн чухал ач холбогдолтой шинжлэх ухааны бүтээл болсон гэж дүгнэж байна.



“Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч нарын дунд дахь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийн талаарх мэдлэг, ойлголт болон тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид үнэлгээ, дүн шинжилгээ хийх судалгааны тайлан”, Нийгэм эдийн засгийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх сургалт, судалгааны хүрээлэн НҮТББ, 2024 он.

Энэхүү судалгааны ажил нь Монгол Улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээтэй холбоотой нийгмийн эрүүл мэнд, сэтгэл зүйн үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдлыг судалж, мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын чадавх, орчны бодит байдлыг үнэлэх, цаашдын бодлого боловсруулахад нотолгоонд тулгуурласан суурь мэдээлэл гаргах зорилготой хийгдсэн байна.

Судалгаагаар мансууруулах бодис хэрэглэгчдийн нөхөн сэргээх үйлчилгээ, сэтгэл зүйн тусламж, нийгэмд дахин нэгтгэх бодлого хэр үр дүнтэй хэрэгжиж байгаа, эдгээр үйлчилгээг үзүүлэгч байгууллагуудын чадавх, нөөц, хандлага, хамтын ажиллагааны бодит байдлыг шинжилсэн байна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээний цар хүрээ өсөн нэмэгдэж, үүнтэй холбоотой гэмт хэрэг, зөрчил, нийгмийн сөрөг үзэгдэл даамжирч буй нь зөвхөн хууль сахиулах асуудал биш, нийгмийн эрүүл мэнд, боловсрол, халамжийн салбарын уялдаа холбоотой, олон талт хариу арга хэмжээ шаардсан үндэсний хэмжээний сорилт болж

байгааг онцолжээ. Энэ нөхцөл байдал нь хэрэглэгчдэд чиглэсэн үйлчилгээний чанар, хүртээмжийг үнэлэх, мэргэжлийн ажилтнуудын мэдлэг, ур чадвар, хандлагыг судлан дүгнэх шаардлагыг бий болгосон бөгөөд уг судалгаа нь энэ чиглэлээр анх удаа системтэй, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хийгдсэн онцлогтой байна.

Судалгааны зорилго нь мансууруулах бодисын хэрэглэгчдэд үзүүлж буй сэтгэл зүйн болон нийгмийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг бодитоор үнэлэх, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хүний нөөц, чадавх, ажлын зохион байгуулалт, салбар хоорондын хамтын ажиллагаанд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, улмаар үйлчилгээний чанарыг сайжруулах бодлогын санал боловсруулахад чиглэжээ.

Судалгааны зорилтыг хэрэгжүүлэхийн тулд чанарын судалгааны арга зүйг голлон ашигласан бөгөөд зорилтот бүлгийн төлөөлөлтэй ярилцлага, ажиглалт, агуулгын шинжилгээ зэрэг аргуудыг хэрэглэсэн байна. Судалгаанд Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хорих анги, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, дүүргийн эмнэлэг, сэтгэл зүйн зөвлөгөөний төвүүд, донтолтын эмчилгээний тасгийн эмч, сувилагч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан зэрэг мансууруулах бодисын хэрэглэгчидтэй шууд харьцдаг мэргэжлийн ажилтнууд оролцсон байна. Мэдээлэл цуглуулах үе шатанд дуу хураагч ашиглан ярилцлагыг бүрэн бичиж, дараа нь дахин сонсож баталгаажуулах, өгөгдөлд логик алдаа шалгах, судлаачийн тэмдэглэлээр хяналт хийх, өгөгдлийн нягтлан шалгалт явуулах зэргээр мэдээллийн найдвартай байдлыг хангажээ.

Судалгааны үр дүнгээс харахад мансууруулах бодис хэрэглэгчдэд чиглэсэн тусламж үйлчилгээний тогтолцоо Монгол Улсад бүрэн төлөвшөөгүй, үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал байгааг илтгэж байна. Сэтгэл зүйн зөвлөгөө, донтолтын эмчилгээ, нөхөн сэргээх болон нийгэмд дахин нэгтгэх үйлчилгээний систем сул, үйлчилгээний чанарт нөлөөлж буй гол хүчин зүйл нь хүний нөөцийн хомсдол, мэргэжлийн сургалт, арга зүйн дутагдал, санхүүжилтийн тогтворгүй байдал болохыг судалгаанд оролцогчдын дийлэнх нь онцолжээ. Сэтгэцийн эрүүл мэндийн салбарт донтолтой иргэдэд үзүүлэх үйлчилгээ хэт төвлөрсөн хэлбэртэй байгаагаас орон нутагт эмчилгээ, зөвлөгөө, нөхөн сэргээх үйлчилгээний хүртээмж бараг байхгүй байгаа нь үйлчилгээний ялгаатай байдлыг бий болгосон байна гэж үзжээ.

Мөн судалгаагаар мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч ажилтнуудын мансууруулах бодисын хор уршгийн талаарх мэдлэг, хандлага, ойлголт харилцан адилгүй байгаа нь хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлж буйг тогтоосон байна. Зарим тохиолдолд хэрэглэгчийг гэмт хэрэгтэн гэхээсээ илүү эмчлэгдэх ёстой өвчтөн хэмээн хүлээн зөвшөөрөх хандлага дутмаг, сэтгэл зүйн эмчилгээ, донтолтын нөхөн сэргээх арга зүйд суурилсан сургалт хангалтгүй байгаа нь хүний эрхийн түвшинд сөрөг үр дагавартай болохыг судалгаанд дурджээ.

Судалгааны шинэлэг тал нь мансууруулах бодис хэрэглэгчдэд зориулсан тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг зөвхөн байгууллагын түвшинд бус,

үйлчилгээ үзүүлэгчдийн сэтгэл зүй, хандлага, мэдлэг, ур чадварын талаас нь гүнзгий шинжилсэн явдалд оршиж байна. Энэхүү судалгаа нь хэрэглэгчийн төвтэй тусламж үйлчилгээний шинэ загварыг боловсруулахад бодит баримт, нотолгоонд тулгуурласан дүн шинжилгээний үндэс суурь болж өгсөн гэж үзэж болохоор байна. Мөн төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог үнэлсэн нь энэ чиглэлийн өмнөх судалгаануудтай харьцуулахад илүү системтэй, уялдаатай шинжилгээ болсон гэж үзэж болохоор байна.

Судалгааны үр дүнгээс дараах гол дүгнэлтүүдийг гаргасан байна. Нэгдүгээрт, мансууруулах бодис хэрэглэгчдэд чиглэсэн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй байгаа нь нийгмийн эрүүл мэндийн бодлого, хүний нөөцийн төлөвлөлт, санхүүжилтийн тогтолцооны сул талтай холбоотой. Хоёрдугаарт, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн чадавхыг нэмэгдүүлэх сургалт, арга зүйн нэгдсэн бодлого хэрэгждэггүйгээс үйлчилгээний чанар тогтворгүй байна. Гуравдугаарт, донтолтын эмчилгээний дараах нөхөн сэргээх, нийгэмд эргэн нэгтгэх үйлчилгээний тогтолцоо бүрдээгүйгээс дахин хэрэглээний эрсдэл өндөр байна. Дөрөвдүгээрт, төрийн байгууллагууд хоорондын мэдээлэл солилцох систем сул, хамтын ажиллагааны тогтолцоо бүрэн төлөвшөөгүй, хяналт-шинжилгээний нэгдсэн аргачлал байхгүй байгаа нь бодлогын хэрэгжилтийн үр нөлөөг бууруулж байна.

Эдгээр дүгнэлтэд үндэслэн судалгааны баг дараах санал, зөвлөмжийг дэвшүүлсэн. Үүнд:

- Сэтгэл зүйн болон нөхөн сэргээх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд улсын болон орон нутгийн түвшинд “Сэтгэл зүйн зөвлөгөөний төв”, “Нөхөн сэргээх төв”-үүдийг төрийн дэмжлэгтэйгээр байгуулж, мэргэжлийн боловсон хүчнээр хангах;

- Хэрэглэгчдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд үйлчилгээний стандартыг шинэчлэх, чанарын шалгуур үзүүлэлтийг нэвтрүүлэх;

- Мэргэжлийн ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор сэтгэцийн эрүүл мэнд, донтолтын эмчилгээний чиглэлээр тогтмол сургалт, чадавхжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх;

- Төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог сайжруулахын тулд мэдээлэл солилцох цахим платформ бий болгож, нэгдсэн мэдээллийн санг хөгжүүлэх;

- Нийгэмд эргэн нэгтгэх бодлогын хүрээнд донтолттой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамж, сэтгэл зүйн дэмжлэгийн хөтөлбөрүүдийг уялдуулах зэрэг санал дэвшүүлжээ.

Ийнхүү энэхүү судалгаа нь мансууруулах бодисын хэрэглээтэй тэмцэх бодлого, үйлчилгээний чанарыг сайжруулахад нотолгоонд суурилсан бодит дүн шинжилгээг хийж, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хууль сахиулах салбаруудын уялдаа холбоог боловсронгуй болгох, бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэхэд шинжлэх ухааны чухал хувь нэмэр оруулсан бүтээл болсон байна.



“Иргэдийн дунд дахь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийн талаарх мэдлэг, ойлголт болон далд хэрэглээг тогтоох судалгааны тайлан”, “Имижлоги” сургалт судалгааны төв НҮТББ, 2024 он.

Энэхүү судалгааны ажил нь Монгол Улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээтэй холбоотой нийгмийн хандлага, олон нийтийн мэдлэг, ойлголт, мэдээлэл хүлээн авах байдал, зан үйлд нөлөөлж буй хүчин зүйлсийг судалж, бодлогын түвшинд урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй, нотолгоонд тулгуурлан боловсронгуй болгох зорилготой гүйцэтгэсэн судалгаа байна. Судалгаагаар мансууруулах бодисын хэрэглээний талаарх олон нийтийн ойлголт, мэдээлэлтэй байх түвшин, хандлага, хэрэглээний эрсдэлийн талаарх итгэл үнэмшил, түүнийг бууруулахад чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны үр нөлөөг дүгнэж, нийгмийн түвшинд зан үйлийн хариу урвал хэрхэн бүрэлдэж байгааг судалсан нь онцлог болсон байна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээний тохиолдол нэмэгдэж, уг үзэгдэл нь залуучуудын дунд эрчимтэй тархаж, нийгмийн аюулгүй байдал, эрүүл мэнд, боловсрол, ёс суртахууны асуудал болон хувирч байна. Үүний зэрэгцээ мансууруулах бодисын хор уршгийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголт сул, мэдээллийн орон зайд ташаа ойлголт давамгайлж, урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажил хангалтгүй байгаа нь бодлогын шинэчлэлийн зайлшгүй шаардлагыг бий болгожээ. Иймээс уг судалгаа нь олон нийтийн мэдлэг, ойлголт, хандлагын бодит төлөв байдлыг үнэлж, нийгмийн зан үйлийн түвшинд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох, бодлого боловсруулагч, боловсрол, мэдээллийн байгууллагуудад чиглэсэн практик зөвлөмж гаргахад зорьсон байна.

Судалгааны зорилго нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийн талаарх олон нийтийн ойлголт, мэдээлэл хүлээн авах хэлбэр, хандлага, мэдлэгийн түвшнийг бодитоор тодорхойлох, түүнийг нийгмийн бүлэг, нас, боловсрол, оршин суугаа орчноор ялган шинжлэх, улмаар олон нийтийн зан үйлийн хэв маяг, эрсдэлд хандах хандлагыг судлахад чиглэжээ. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:

1. Мансууруулах бодисын хэрэглээний талаарх олон нийтийн мэдээлэл, мэдлэгийн эх үүсвэр, түүний найдвартай байдлыг судлах;
2. Иргэдийн мансууруулах бодисын хэрэглээнд хандах ёс суртахууны болон зан үйлийн хандлагыг тодорхойлох;
3. Урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлын үр нөлөө, хүртээмжийг үнэлэх;

4. Олон нийтийн оролцоо, мэдээлэл хүлээн авах болон нөлөөллийн сувгийн үр ашигт байдлыг тодорхойлох;

5. Судалгааны үр дүнд тулгуурлан бодлогын түвшинд хэрэгжүүлэх зөвлөмж боловсруулж, олон нийтийн боловсролын хөтөлбөрийн суурь мэдээлэл боловсруулах.

Судалгааны арга зүй нь тоон болон чанарын аргуудыг хослуулсан холимог судалгааны хэлбэртэй бөгөөд судалгааны үндсэн мэдээллийг анкетын судалгаа, гүнзгий ярилцлага, фокус бүлгийн хэлэлцүүлэг, байгууллагын төлөөлөгчдийн санал асуулгын аргаар цуглуулсан байна. Олон нийтийн төлөөлөл бүхий анкетын судалгаа нь хот, хөдөө орон нутгийн 8 аймаг, 4 дүүргийн 1200 гаруй иргэнийг хамруулсан бөгөөд насны бүлэг, боловсрол, орлогын түвшнээр ялгавартай байдлыг тусгаж өгснөөр мэдээлэл статистикийн хувьд төлөөлөх чадвартай болжээ. Харин чанарын мэдээллийг боловсрол, эрүүл мэнд, хууль сахиулах, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын төлөөлөлтэй хийсэн гүнзгий ярилцлага, олон нийтийн сүлжээнд идэвхтэй оролцогч иргэдийн үзэл бодлын шинжилгээгээр баталгаажуулсан байна.

Судалгаанд Statistical Package for the Social Sciences (SPSS) болон NVivo программ ашиглан өгөгдөл боловсруулж, тоон мэдээлэлд статистик шинжилгээ, чанарын мэдээлэлд агуулгын шинжилгээ хийсэн бөгөөд судалгааны найдвартай байдлыг баталгаажуулахын тулд өгөгдлийн давхар хяналт, кодлох системийг хэрэглэжээ.

Судалгааны үр дүнгээс харахад, олон нийтийн дунд мансууруулах бодисын хэрэглээний хор уршгийн талаарх мэдлэг хангалтгүй, эрсдэлд хандах ухамсар сул байгаа нь хамгийн ноцтой дүгнэлтүүдийн нэг болсон байна. Судалгаанд оролцогчдын 73.4 хувь нь “мансууруулах бодисын хэрэглээ нь зөвхөн хууль зөрчих асуудал” гэж ойлгодог бөгөөд үүний цаад сэтгэл зүйн, нийгмийн болон эрүүл мэндийн шалтгааныг мэдэхгүй, хандлагын түвшинд буруу төсөөлөл давамгайлж байв. Түүнчлэн 18–25 насны залуусын 12 хувь нь “мансууруулах бодисыг нэг удаа хэрэглэх нь ноцтой хор уршиггүй” гэж үзсэн нь мэдээлэл, боловсролын дутагдлыг тод харуулсан үзүүлэлт болсон байна.

Судалгааны дүнгээс мөн мансууруулах бодисын хэрэглээнээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажил, олон нийтийн мэдээлэл, сурталчилгааны үр нөлөө сул байгаа нь илэрсэн. Судалгаанд хамрагдагсдын 68 хувь нь “мансууруулах бодисын хор уршгийн талаарх мэдээлэл ховор” гэж хариулсан бөгөөд мэдээлэл олж авдаг гол эх сурвалж нь цахим орчин, найз нөхдийн хүрээ байгаа нь албан ёсны, мэргэжлийн эх үүсвэр хангалтгүй байгааг харуулсан байна.

Судалгааны шинэлэг тал нь олон нийтийн мэдлэг, хандлагыг сэтгэл зүйн үзүүлэлтүүдтэй уялдуулан шинжилсэнд оршино. Судалгаанд хувь хүний үнэт зүйл, өөрийгөө хянах чадвар, нийгмийн нөлөөлөлд өртөмтгий байдал, ёс суртахууны үнэлэмж зэрэг хүчин зүйлийг тоон үзүүлэлтээр хэмжиж, нийгмийн хандлагын зан үйлийн шинж чанарыг илрүүлсэн нь Монгол Улсад энэ чиглэлээр анх удаа хийгдсэн судалгааны ажил болжээ.

Судалгааны дүгнэлтээр, олон нийтийн дунд мансууруулах бодисын хэрэглээний талаарх мэдээлэл, ойлголт дутмаг байгаа нь урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг бууруулж, нийгмийн хариуцлага, хамтын оролцоог сулруулж байна гэж дүгнэжээ. Мөн хүүхэд, өсвөр үеийнхэнд чиглэсэн боловсролын системийн хүрээнд сэтгэл зүйн боловсрол, донтолтын талаарх мэдлэг олгох сургалтын хөтөлбөр дутагдалтай байгаа нь хэрэглээний эрт үеийг илрүүлэх, таслан зогсоох бодлогын сул талыг илэрхийлж байна.

Судалгааны баг эдгээр дүгнэлтэд үндэслэн дараах санал, зөвлөмжийг боловсруулсан байна. Үүнд:

- Нэгдүгээрт, мансууруулах бодисын хор уршгийн талаарх мэдлэгийг өсвөр наснаас эхлэн олгох зорилгоор ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт тусгай хичээл, сургалт оруулах;


- Хоёрдугаарт, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийгэмд сөрөг нөлөөтэй мэдээллийг хязгаарлаж, бодит, шинжлэх ухаанд тулгуурласан мэдээллийг түгээх стратеги боловсруулах;

- Гуравдугаарт, урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлыг мэргэжлийн байгууллагуудын уялдаанд суурилуулж, цахим орчин дахь мэдээллийн хяналтыг сайжруулах;

- Дөрөвдүгээрт, олон нийтийн оролцоо, сайн дурын хөтөлбөр, эцэг эхийн боловсролыг дэмжих бодлого хэрэгжүүлэх;

- Тавдугаарт, нийгмийн сэтгэл зүйн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төв”-үүдийг орон нутгийн түвшинд байгуулах.

Ийнхүү энэхүү судалгаа нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээтэй холбоотой нийгмийн хандлага, зан үйлийн хэв шинжийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлсон, бодлого боловсруулах, олон нийтийн боловсрол, урьдчилан сэргийлэх ажлыг шинэлэг хэлбэрээр төлөвлөхөд чухал суурь баримт болсон бүтээл байна. Судалгааны ач холбогдол нь зөвхөн бодит нөхцөл байдлыг илрүүлэхээс гадна, нийгмийн зан үйлийн судалгааны шинэ арга зүйг нэвтрүүлсэн, улмаар Монгол Улсын хэмжээнд нотолгоонд суурилсан бодлого боловсруулахад чиглэсэнд оршиж байна.



Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх донтой этгээд дахин хэрэглэхэд нөлөөлж буй хүчин зүйлийг тогтоох, дүн шинжилгээ хийх судалгааны тайлан, “Түгээмэл эрх, эрх зүйн боловсрол” НҮТББ, 2024 он.

Энэхүү судалгааны ажил нь Монгол Улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, түүний тархалт, хэрэглэгчийн зан үйл, донтолттой этгээдүүдийн дахин хэрэглэх хандлага болон тус асуудалд нөлөөлж буй хувь хүн, гэр бүл, орчин, байгууллагын хүчин зүйлсийг иж бүрнээр тодорхойлж, урьдчилан сэргийлэх, эмчилгээ, нөхөн сэргээх үйлчилгээг бодлого болон практикт илүү үр дүнтэй зохион байгуулах суурь мэдээллийг гаргах зорилготой өргөн хүрээний, нотолгоонд суурилсан судалгаа байна.

Энэхүү судалгаа нь уг асуудлын онцлог, цар хүрээг тодруулахын зэрэгцээ донтолтын дахин давтагдах эрсдэлийн шалтгааныг сэтгэл зүйн болон нийгмийн өнцгөөс шинжлэх ухааны аргад тулгуурлан задлан шинжилж, бодлого боловсруулах, үйлчилгээний зохион байгуулалт, хүний нөөцийн чадавх, мэдээлэл түгээх стратегийн чиглэлийг тодорхойлон санал болгох цогц зорилтыг хэрэгжүүлжээ.

Судалгааны хүрээнд хийгдсэн ажлын цар хүрээ нь олон талт бөгөөд тухайн сэдвийг олшруулж буй үндсэн асуудлууд - өсвөр нас, залуучуудын дунд тархаж буй хэрэглээ, найз нөхдийн нөлөө, гэр бүлийн уур амьсгал, санхүүгийн үзүүлэлтүүд, мэдээллийн эх үүсвэрүүд болон эмчилгээ, нөхөн сэргээх үйлчилгээний хүртээмж, чанарын асуудлууд зэрэг олон түвшний үзүүлэлтийг хамарч, хэрэглэгч, үйлчилгээ үзүүлэгч, төрийн холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулсан.

Урьд гүйцэтгэсэн судалгаа, баримт бичиг, албан статистик, нүүр тулсан ярилцлага (face-to-face interviews), анкет судалгаа болон агуулгын шинжилгээ зэрэг анхдагч ба хоёрдогч мэдээллийн эх сурвалжуудыг нэгтгэсэн холимог арга зүйгээр энэхүү судалгааг гүйцэтгэсэн байна.

Тоон мэдээллийг SPSS-т боловсруулж статистик шинжилгээ хийж, чанарын мэдээллийг агуулгын шинжилгээ, кейс судлал, ярилцлагад тулгуурласан кодчиллын аргаар гүнзгийрүүлэн шинжилсэн бөгөөд өгөгдлийн найдвартай байдлыг хангах зорилгоор ярилцлагын бичлэгүүдийг дуу хураагчаар баталгаажуулж, өгөгдлийн шивэлт, шивэлтийн хяналт, логик алдаа шалгалт зэрэг олон шатлалт хяналтын арга хэмжээг хэрэгжүүлжээ.

Судалгааны гол ололт, үр дүн нь мансууруулах бодисын хэрэглээ зөвхөн хууль зүйн тулгамдсан асуудал төдийгүй нийгмийн сэтгэл зүйн, хүмүүжил, орчны шалтгаантай цогц үзэгдэл болохыг тодорхойлон харуулж, хэрэглэгчдийн дунд найз нөхөд, цахим орчин, танил талын нөлөө нь анхны хэрэглээнд түлхэц

үзүүлдэг ба дахин хэрэглээний гол драйверууд нь бие махбодын хамаарал, стресс, гэр бүлийн маргаан, сэтгэл гутрал зэрэг сэтгэл зүйн хүчин зүйлс мөн эмчилгээ, нөхөн сэргээх үйлчилгээний хүртээмж, чанарын дутагдалтай шууд уялдаатай байгаа нь судалгааны тоон болон чанарын дүнгээс тогтоогдсон байна. Үүнээс гадна хэрэглэгчид болон үйлчилгээ үзүүлэгчдийн өгсөн мэдээллээр эмийн сангуудаар жоргүй олгодог тайвшруулах болон нойрны эмийн хяналт сул байгааг онцолж, дээрх нөхцөл нь шинэ синтетик бодисын нэвтрэлт, ургацын тархалттай холбогдон илүү их эрсдэл үүсгэж байгааг тодорхойлжээ.

Онол болон практикийн ач холбогдлын хувьд энэхүү судалгаа нь мансууруулах бодис хэрэглээний шалтгаан, үр дагаврыг сэтгэл зүйн болон нийгмийн контекстэд нэгтгэн системчилсэн бөгөөд донтолтын дахин хэрэглээнд нөлөөлж буй хүчин зүйлсийн уялдааг бодитоор илрүүлж, эмчилгээ, урьдчилан сэргийлэх, олон нийтийн боловсролын бодлого болон хууль, байгууллагын зохион байгуулалтыг эрэмбэлэн шинэчлэн боловсруулах шаардлагатайг нотолгоотой санал болгосон нь шинжлэх ухааны болон бодлого төлөвлөлтийн талбарт үнэтэй хувь нэмэр болж байна. Судалгааны онцлог нь хэрэглэгчид, үйлчилгээ үзүүлэгчид, төрийн байгууллагын тэнцвэрт бус харилцаа, мэдээллийн эх үүсвэр, сэтгэл зүйн дэмжлэгийн дутагдал зэрэг субъектив үзүүлэлтийг тоон үзүүлэлттэй уялдуулж, дахин хэрэглэх эрсдэлийн цогц загварыг Монголын нөхцөлд анх удаа тогтоосон явдал гэж хэлж болохоор байна.

Судалгааны үндсэн дүгнэлтүүд нь мансууруулах бодисын хэрэглээ, донтолтын асуудлыг шийдвэрлэхэд зөвхөн хуулийн арга хэмжээ хангалтгүй бөгөөд цогцолбор эмчилгээнээс гадна сэтгэл зүйн иж бүрэн дэмжлэг, нөхөн сэргээх үйл ажиллагаа, гэр бүлд чиглэсэн сургалт, олон нийтийн мэдээллийн тогтолцоо, эмийн хяналтын хүчийг чангатгах зэрэг олон талт арга хэмжээ шаардлагатай гэдэгт төвлөрчээ.

Мөн эмчилгээний дараах эрсдэлийг бууруулах, дахин сэргээх (relapse prevention) механизмыг стандартчилах, сэтгэл зүйн болон нийгмийн дэмжлэгийн төвүүдийг хүртээмжтэй байгуулах, мэргэжлийн хүний нөөцийг чадавхжуулах, эмийн сангийн хяналтыг боловсронгуй болгох, урлаг-соёл, цахим орчинд түгж буй далд сурталчилгааг хязгаарлах бодлогын алхмуудыг нэн шаардлагатай гэж тогтоосон байна.

Дүгнэлтэд тулгуурлан судалгааны баг дараах санал, зөвлөмжийг боловсруулжээ. Үүнд:

Нэгдүгээрт, сэтгэл зүйн зөвлөгөө, нөхөн сэргээх үйлчилгээг улсын болон орон нутгийн түвшинд хүртээмжтэй болгон байгуулж, эмчилгээний дараах дэмжлэг ба эрсдэлийг бууруулах хөтөлбөрүүдийг тогтмол санхүүжүүлэх;


Хоёрдугаарт, донтолтын эмчилгээ, нөхөн сэргээх үйлчилгээний чанар, хүний нөөцийг сайжруулахын тулд мэргэжлийн сургалт, арга зүйн нэгдсэн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;

Гуравдугаарт, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт мансууруулах бодисын хор уршгийн талаарх сэтгэл зүйн боловсрол, урьдчилан сэргийлэх сургалтыг оруулах;

Дөрөвдүгээрт, эмийн сангуудын жоргүй эмийн олголтыг хязгаарлах, эмийн хяналтыг бэхжүүлэх замаар холбогдох эмийн бүтээгдэхүүний хялбар олдцын асуудлыг шийдвэрлэх;

Тавдугаарт, олон нийтийн мэдээллийн стратегийг боловсронгуй болгох, цахим орчныг хянах механизм, инфлюенсер, урлаг соёлын хүмүүстэй ажиллах журмыг тодорхойлох зэрэг бодлогын арга хэмжээг тусгасан бөгөөд эдгээр зөвлөмжүүд хэрэгжсэнээр дахин хэрэглэх эрсдэлийг тодорхой хэмжээгээр бууруулж, эмчилгээний үр бүтээмж, нийгмийн сэргээн нэгтгэх үйл ажиллагааны чанар сайжрах боломжтойг судалгаа нотолж байна.

Дээрхээс дүгнэхэд, энэхүү судалгаа нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, донтолтын дахин хэрэглээний шалтгаан, түүнд нөлөөлж буй олон талт хүчин зүйлсийг нэгдмэл, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлж, бодлого боловсруулах, эмчилгээний үйлчилгээг оновчтой болгох талаар практик, бодлогын ач холбогдол бүхий баримт, зөвлөмжийг нэгтгэн хүргэснээр Монгол Улсын холбогдох байгууллагуудын шийдвэр гаргалт, үйл ажиллагааны шинэчлэлд үнэтэй суурь мэдээлэл болон гарц шийдлийг санал болгосон байна.



“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ”. Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2023 он.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2023 онд гүйцэтгэсэн “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ” судалгаанд уг хуулийн бодлого-эрх зүйн хэрэгжилтийн үр нөлөө, хэрэгжилтийн механизмуудын үйл ажиллагаа, хэрэгжүүлэлтийн явцад тулгарч буй институциональ болон техник-административ хүчин зүйлсийг нарийвчлан дүгнэсэн байна. Судалгааны арга зүйд “хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ” аргачлалыг ашиглаж, баримт бичгийн тойм, холбогдох байгууллагын өгөгдөл, түнш байгууллагуудын ярилцлага, чанарын болон тоон мэдээллийн шинжилгээг хослуулан хэрэглэжээ.

Судалгаанд дэвшүүлсэн гол асуудал нь хуулийн заалтууд онолын түвшинд бүрэн хуульчлагдсан боловч тэдгээрийн бодит хэрэгжилтийг хангах институциональ уялдаа, хяналт-мониторингийн тогтолцоо, мэргэжлийн хүний нөөц, техникийн чадавх (ялангуяа лаборатори, илрүүлэх төхөөрөмж) болон мэдээлэл солилцооны нэгдсэн платформ дутмаг байгаагаас хуульд тусгасан зорилт болох хууль бус эргэлтийг бууруулах үйл явц бүрэн дүүрэн хэрэгжиж чадахгүй байгаа явдал хэмээн тодорхойлогджээ.

Дүн шинжилгээнд цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэл, баривчилгаа, хураан авсан бодисын төрөл, газарзүйн тархалтын үзүүлэлтийг авч үзэхийн

Энэхүү судалгааны онцлог нь зөвхөн хууль зүйн зохицуулалт болон шүүх-эрүүгийн практикийг шинжлэхээс гадна хэрэг бүртгэл, газарзүйн тархалт, гадаад транзитын суваг, эмчилгээний үйлчилгээний хүртээмж зэрэг олон давхаргат хүчин зүйлсийг хамруулан үнэлсэнд оршино. Ийм байдлаар гаргасан зөвлөмжүүд нь хууль хэрэгжилтийг бодитоор дэмжих институциональ, техник болон хүний нөөцийн бодлогыг зэрэгцээ хөндсөн цогц шинжтэйгээрээ ач холбогдолтой болсон байна..

Энэхүү “Монгол Улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэх мэдээллийн санг бүрдүүлж холбогдох байгууллагуудын нэгдсэн сүлжээг үүсгэх” сэдэвт судалгааны ажил нь Монгол Улсад амиа хорлолт болон архи, мансууруулах бодисын хэрэглээний улмаас үүсэж буй эмгэг, нас баралтын бодит нөхцөл байдлыг бүрэн




дүүрэн хянахад шаардлагатай нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн дутагдал нь нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал болж буйг асуудал болгон дэвшүүлжээ. Судалгааны зорилго нь дээрх үзүүлэлтүүдийг бүртгэх стандарт маягт, асуумжийг боловсруулж, холбогдох байгууллагуудын дунд нэгдсэн цахим мэдээллийн сан, сүлжээ бий болгох эрх зүйн болон техникийн суурийг тавихад чиглэсэн байна.

Судалгааг аналитик болон чанарын судалгааны нэг агшны загвараар хэрэгжүүлсэн бөгөөд асуумж, баримтын судалгаа, бүлгийн ярилцлага зэрэг аргыг ашигласан байна. Үүнд, Эрүүл мэндийн яам, ХЗДХЯ, БШУЯ, ХНХЯ, ЦЕГ, ҮСХ, ЭМХТ, СЭМҮТ зэрэг нийт 23 байгууллагыг хамруулж, нэгдсэн мэдээллийн тогтолцоонд шаардлагатай өгөгдлийг тодорхойлох зорилгоор 4 бүлэг, 231 асуултаас бүрдэх судалгааны асуумж боловсруулсан. Судалгааны үр дүнг боловсруулахдаа SPSS программ, статистик үнэлгээ, Delphi аргачлал ашиглан өгөгдлийн ач холбогдлыг мэргэжлийн түвшинд үнэлж, хасах болон багтаах шалгуурыг тогтоожээ.

Судалгааны онцлог нь зөвхөн нэг салбарын хүрээнд бус, эрүүл мэнд, боловсрол, хууль зүй, хөдөлмөр, нийгмийн хамгаалал зэрэг олон салбарын байгууллагуудыг уялдуулан хамруулсан, олон улсын стандартад нийцсэн асуумж, бүртгэлийн маягтыг боловсруулж, мэдээллийн урсгалыг нэгдсэн системд нэгтгэхийг зорьсонд оршино. Мөн өмнөх судалгаанууд зөвхөн хэсэгчилсэн байдлаар хийгдэж байсан бол энэ удаагийн судалгаа нь улс даяар хэрэгжих боломжтой нэгдсэн бүртгэлийн журам, цахим сангийн эх суурийг тавьсан гэдгээрээ шинэлэг хандлагатай гэж ойлгож болно.

Судалгааны үр дүнд амиа хорлолт болон архи, мансууруулах бодисын хэрэглээтэй холбоотой тохиолдлыг бүртгэхэд ашиглах 10 төрлийн шинэчилсэн маягт, мөн эрүүл мэндийн болон эрүүл мэндийн бус салбар, боловсролын байгууллагуудад хэрэглэх гурван ангиллын бүртгэлийн тогтолцоог боловсруулж, цаашид “Амиа хорлох болон архи, мансууруулах бодисын хэрэглэгч, донтогчийг бүртгэл, тандалтын журам”-ыг батлуулах шаардлагатай гэж санал болгожээ. Үүнээс гадна байгууллагуудын мэдээллийг нэгтгэж, нууцлалыг хангах, мэдээллийн давхардлыг арилгах, орон даяар нэгдсэн цахим сервер ашиглах хэрэгцээ илэрсэн байна.

Судалгааны дүгнэлтээр одоогийн нөхцөлд бүртгэлийн системүүдийн уялдаа сул, салбар бүр өөрийн тогтолцоогоор ажиллаж байгаа нь бодит нөхцөл байдлыг үнэн зөвөөр илэрхийлэх боломжийг алдагдуулж буйг тодорхойлсон. Иймд тус судалгааны саналд эрүүл мэнд, хууль зүй, боловсрол, хөдөлмөрийн салбаруудын хамтарсан журам эсвэл Засгийн газрын тогтоолоор баталсан нэгдсэн журам боловсруулж хэрэгжүүлэх, мэдээллийн нэгдсэн цахим сан, сервер бий болгох, орон нутгийн бүх шатны байгууллагуудад хэрэгжүүлэх үүрэг чиглэл өгөх, цаашлаад мэдээлэлд суурилсан урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай гэж зөвлөжээ.



“Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном – 2023” бүтээл. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, 2024 он.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны захиалгаар 2016 оноос эхлэн жил бүр эрхлэн гаргаж буй “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном” бүтээл нь жил бүр өөрийн онцлогийг шингээсэн байдаг. Энэхүү жишгийн дагуу “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном – 2023” бүтээлд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг” нэртэй энэ төрлийн гэмт хэргийн статистик мэдээллийг агуулсан тусгай бүлгийг оруулсан нь онцлог болжээ. Энэхүү бүлэг нь “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт

бодистой холбоотой гэмт хэргийн тоон мэдээ”, “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ”, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ” гэсэн 3 дэд бүлгээс бүрдсэн байна. Энэхүү “Гэмт хэргийн цагаан ном 2023”-ын онцлох хэсэг нь Эрүүгийн хуулийн 20.7–20.10-д хамаарах мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн цар хүрээ, бүтэц, газарзүйн тархалт, холбогдогчдын нийгэм-демографийн шинж, эрүүгийн эрх зүйн хуульчлал болон хэрэгжилтийн уялдаа, шүүхийн практикт бүрэлдэж буй чиг хандлага зэргийг “систем-шатлалын” өнцгөөс нэг мөрөөр харах асуудлыг дэвшүүлж, цагдаа-шүүхийн захиргааны статистик, шүүхийн шийдвэрийн агуулга-текстийн шинжилгээ, мөн эмнэлзүйн бүртгэлийн мэдээллийг уялдуулсан хосолмол арга зүйгээр судалсан нь онцлог болжээ; тоон талд 2018–2023 оны цагдаагийн бүртгэлийн мэдээллээр гаралтыг, 2018–2023 оны эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэлтээр таслалыг, 2019–2023 оны 560 шийдвэрт хийсэн кодчилал-агуулгын шинжилгээгээр үйлдлийн нарийвчилсан хэв шинжийг, харин “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль”-ийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлгээний аргачлалын “үнэлгээ” шатанд тулгуурлан эрх зүйн нийцэл-цоорхойг тодруулсан байна. Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2023 онд улсын хэмжээнд 238 гэмт хэрэг бүртгэгдэж, тэдгээрийн 85.7 хувь нь нийслэлд төвлөрсөн нь (204 хэрэг) газарзүйн ялгарал өндөр хэвээр байгааг харуулж, мөн 2023 онд уг төрлийн гэмт хэрэгт 220 хүн холбогдсон нь өмнөх онтой харьцуулахад 7.6 хувиар буурсан үзүүлэлттэй гарсан нь динамикийг товойлгосон юм.

- Шүүхийн шатанд 2023 онд 20.7 дугаар зүйлээр 176 хэрэг хянан шийдвэрлэгдэж, нийт 195 хүн ял шийтгүүлсний 127-д нь хорих ял ногдуулсан

(торгох ял оноохгүй байсан) нь таслал-ялын бодлогын жин 2023 онд ч хорих төрөлд төвлөрч байгааг илтгэнэ.

- 2018–2023 онд нийт 1101 хүнийг ялласан бөгөөд тэдгээрийн 81.1 хувьд хорих ял оногдуулсан гэсэн дунд-уртын чиг хандлага мөн тодорхой байна.

- Шийдвэрийн агуулгын түвшинд 2019–2023 оны 560 хэргийн текстэд хийсэн кодчиллоор холбогдогсод бодисоо ихэвчлэн “өвсийг түүж бэлтгэх” (237 хэрэг) замаар олж авдаг, дараа нь “үнэ төлбөргүй авах”, “худалдаж авах”, “олох”, “хилээр нэвтрүүлэх” зэрэг хэлбэрүүд зонхилдгийг тогтоож, хэрэглэсэн бодисын төрөл 21 янз байснаас Δ9-тетрагидроканнабинолын бүлгийн бодис (өвс) 64.9 хувь, метамфетамин 14.7 хувь, “шавар” 13.1 хувийг эзэлсэн нь зах зээл-хэрэглээний бүтцийг нотолжээ.

- Мөрдөн шалгах ажиллагааны практикт биологийн дээж авах нь зонхилдог бөгөөд 2019–2023 онд 639 тохиолдолд шээсний шинжилгээ, харин цусны шинжилгээ тун ховор хийгдсэн нь сорьцлолтын стандарт-нэгдэл сул байгааг харуулсан дүгнэлт гаргасан байна.

Нийгэм-демографийн огтлолд 2023 онд 18–29 насны бүлэг нийт холбогдогчдын тал илүү хувийг бүрдүүлж (18–24 нас 32.2%, 25–29 нас 27.7%), эмэгтэй холбогдогчдын тоо өмнөх оноос өссөн, бүлэглэн үйлдэх хэлбэр давамгай хэвээр, “мансуурсан” төлөвтэй үйлдэл бүртгэлийн ангилалд шинээр тогтмолжиж буй зэрэг өөрчлөлтүүд тодорч, шүүхээр ял шийтгэгдсэн 195 хүний дотор урьд ял шийтгүүлсэн 59 хүн байгаагаар давтамж-давагдлын шинж тэмдэг ажиглагджээ; хэрэг үйлдэгдсэн байдлын торгон үзүүлэлтээр 2023 онд “мансуурсан үед” 200 тохиолдол, “бүлэглэн” 33, “цахим орчинд” 2 тохиолдол бүртгэгдсэн нь үйлдлийн орчин-сүвгийг ч тодорхойлсон байна.


Шалтгаан-сэдлийн талаарх кодчиллоор “найз санал болгосон” (19.3%) болон “сонирхол” (10.8%) зэрэг нийгэм-сэтгэлзүйн өдөөгч хүчин зүйлс давамгай гарсныг тэмдэглэж, энэ нь эрсдэлийн харилцааны сүлжээ, урьдчилан сэргийллийн зорилтот бүлгийг чиглүүлэх баримжаа болсныг судалгаа онцолсон; нөгөө талаар эмнэлзүйн бүртгэлээр (ICD-10 F ангилал) бодисын хамаарал-хэт хэрэглээтэй холбоотой эмгэгүүдийн идэвхжил 2012–2023 онд залуу насанд төвлөрөх хандлага ажиглагдсан нь эрүүгийн тоон мэдээтэй уялдана.

Хууль тогтоомжийн нийцлийн үнэлгээгээр “өршөөлт бус” бодлогын зорилго, конвенцын чиг баримжаа бий ч объектив талын зарим үйлдлийг Эрүүгийн хуульд тусгалгүй орхисон, мөн хил, гаалийн байгууллагын зүгээс мансууруулах бодисын хууль бус эргэлтийг илрүүлэх чадавх харьцангуй сул, хяналтын нөхцөлийг тойрон гарах боломж өндөр байгаа нь хууль хэрэгжилт зорилгодоо бүрэн хүрээгүй, “эрсдэлийн гарц” үүсгэж буйг тогтоож, хуульчлалын хийдлийг нөхөж, хүндрүүлэх шинжид хамаарах нөхцөлүүдийг тодорхой, нэг мөр болгож, хил-гаалийн эрсдэлийн удирдлагын чадавхыг бодит багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, сургалт-мэргэшлээр дэмжих, Үндэсний хөтөлбөрийн хүрээнд олон байгууллагын уялдаа-нэгтгэлийг тогтолцооны түвшинд сайжруулах зэрэг бодлогын санал-чиглэлийг дэвшүүлжээ.

Үүнтэй хавсран мөрдөн шалгах явц дахь сорьцлолт-шинжилгээний


стандартын нэгдэл, нотлох баримтын чанарын баталгааг сайжруулах шаардлага
практикийн мэдээллээс шууд урган гарч буйг судалгаа тэмдэглэсэн нь хэрэг
бүртгэл-мөрдөн шалгалтын чанарын “хэвшмэл алдаа”-г бууруулах чиглэлд
чадавхжуулах бодлогыг нэн тэргүүнд тавих ёстойг илэрхийлж байна.

2.4. Гарын авлага, сурах бичиг, нэг сэдэвт бүтээл



Ж.Мөнхболд Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэх асуудал. (2024) нэг сэдэвт бүтээлд мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэх бодлого, гадаад орны туршлага бүлэгт Монгол Улс дахь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэж буй бодлого, үйл ажиллагаа, эрүүгийн эрх зүйн орчин, ялын бодлого, тухайн төрлийн гэмт хэрэг зөрчилд хийсэн дүн шинжилгээ, ОХУ дахь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх бодлого, үйл ажиллагааны онцлог бүлэгт ОХУ-ын мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн ерөнхий нөхцөл байдал, эрүүгийн эрх зүйн бодлого, тухайн төрлийн бодисын хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох


чиглэлээр явуулж буй төрийн бодлого, эрх зүйн орчин, үйл ажиллагаа, АНУ дахь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлттэй тэмцэх бодлого, үйл ажиллагааны онцлог бүлэгт АНУ-ын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтийн ерөнхий нөхцөл байдал, хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр явуулж буй төрийн бодлого, эрх зүйн зохицуулалт, тогтолцоо, үйл ажиллагаа, БНХАУ дахь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлттэй тэмцэх бодлого, үйл ажиллагааны онцлогийг судалсан байна.




ХЗДХЯ, ГХУССАЗЗ (2019) “Мансууруулах эм, бодис хэрэглэсэн хүнийг таньж илрүүлэх, шаардлагатай арга хэмжээ авах, мэдлэг олгох сургалтын гарын авлага”-д мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай ерөнхий ойлголт, өнөөгийн нөхцөл байдал болон ахуйн хэрэглээний хорт бодисын хууль бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэх ажиллагаа, ахуйн хэрэглээний хорт бодисын тухай ойлголт, хор уршиг, Мансууруулах ба сэтгэцэд нөлөөт хорт бодис нь хүний генийн болон удамшил, нөхөн үржихүйд нөлөөлөх түүнд донтогчдын шинж, Каннабис, Опиодуудын сэтгэцэд үзүүлэх нөлөө, Кокайн, Нойрсуулах бодисыг (барбитурати) хэрэглэж мансуурсан шинж, мөс, мансууруулах

үйлчилгээтэй, ахуйн хэрэглээний зүйл хэрэглэж мансуурсан байдал, хэрэглэсэн хүнийг таньж илрүүлэх, тухайн хүнд шаардлагатай арга хэмжээ авах талаар дэлгэрэнгүй тусгаж, Монгол Улсын Үндсэн Хууль, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах

тухай хууль, Гэр бүлийн тухай хуулиас анхан шатны мэдлэг олгох талаар тусгасан.



ХЗДХЯ, ГХУССАЗЗ (2019) “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөл” гарын авлагад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын талаарх ерөнхий ойлголт, түүнд донтох эмгэг, тухайн бодисын нийгэм эдийн засаг, эрүүл мэнд, зан үйлд үзүүлэх сөрөг үр дагавар, мансууруулах бодисын хараат байдалд орсон хүмүүст үзүүлэх нийгэм-сэтгэл зүйн тусламж үйлчилгээ Урьдчилан сэргийлэх арга хэмжээ, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлт, түүнд тавих хяналт, тухайн бодисын хор нөлөөнөөс урьдчилан сэргийлэх, хуульд зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагын талаар хууль эрх зүйн анхан шатны мэдлэг олгох талаар тусгасан.



ХЗДХЯ, ГХУССАЗЗ (2019) Мансууруулах эм, бодис хэрэглэсэн хүнийг таних, илрүүлэх, шаардлагатай арга хэмжээ авах, мансууруулах бодис таньж ялгах мэдлэг олгох сургалтын гарын авлага

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бодисын тухай ойлголт, хэрэглэсэн хүнд илрэх шинж тэмдэг, сөрөг нөлөө, түүний эмчилгээний арга зүй, үе шат, тухайн төрлийн бодистой холбоотой харилцааг зохицуулсан дотоодын Мансууруулах бодис, сэтгэц нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, Эрүүгийн хууль, Согтуурах мансуурах донтой этгээдийг албадан эмчлэх тухай хууль, “Мансууруулах эм, сэтгэц нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх” үндэсний хөтөлбөр зэрэг эрх зүйн орчинтой холбогдох онцлог зохицуулалт, сэжигтэй этгээдийг шалгах, эд мөрийн баримт илрүүлэх, бэхжүүлэхэд анхаарах асуудал болон “Согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх, хордуулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгах журам” цагдаагийн байгууллагын код журам, энэ төрлийн бодистой холбогдох нэр томъёоны тайлбар зэргийг багтаасан байна.



МУДШ-ийн ШССМХ, УЕПГ, Азийн зан (2022) Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа (Шүүгч, прокурорт зориулсан гарын авлага) нь 5 бүлэг, 19 дэд сэдэв бүхий Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Гаалийн ерөнхий газрын Гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх газрын Хар тамхины хяналтын алба Гаалийн улсын байцаагч, хэрэг бүртгэгч Г.Ганзориг, Хууль зүйн ухааны доктор, дэд профессор, Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал, цагдаагийн дэд хурандаа С.Гантулга, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Тусгай шинжилгээний газрын дарга, цагдаагийн хурандаа Б.Ламчин,

Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, хамтын ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Б.Мандухай, Улсын Ерөнхий прокурорын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, сургалтын хэлтсийн хяналтын прокурор Г.Оюунбаяр нарын хууль сахиулах байгууллагын салбарын эрдэмтэн судлаач, практик ажилтнууд хамтран боловсруулсан байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын тухай ерөнхий ойлголт нэгдүгээр бүлэгт Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын тухай ойлголт, хор уршиг, тус бодисын төрөл, шинж, хэрэглэсэн хүнийг таних, дээж авах онцлог, донтсон этгээдийг хамгаалах стандарт ба хүний эрхийн асуудлыг авч үзсэн Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын тухай ерөнхий ойлголт, түүний хор уршиг, хүний биед үзүүлэх нөлөө, энэ төрлийн бодис хэрэглэсэн хүнийг таних, дээж авах онцлог, мансуурах донтой хүмүүсийг хамгаалах стандарт, туршлагын талаар мэдлэг эзэмшүүлэхэд чиглэсэн байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал хоёрдугаар бүлэгт Бүс нутаг болон олон улс дахь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн нөхцөл байдал, Монгол Улс дахь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн нөхцөл байдал, чиг хандлага, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх, тээвэрлэх арга, хэлбэрийг авч үзэн Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн гадаад, дотоод нөхцөл байдал, чиг хандлагыг тодорхойлох, энэ төрлийн бодисыг Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх, тээвэрлэх арга, хэлбэр, урьдчилан сэргийлэх арга зүйн талаар мэдлэг, чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх олон улсын болон үндэсний эрх зүйн зохицуулалт гуравдугаар бүлэгт Олон Улсын эрх зүйн зохицуулалт (НҮБ-ын баримт бичгүүд, бүс нутгийн олон улсын конвенц), Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх

үндэсний эрх зүйн зохицуулалт авч үзсэн Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх олон улсын болон үндэсний эрх зүйн зохицуулалтын талаар онолын мэдлэг олгох, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн бүрэлдэхүүний шинжийг тодорхойлох, ялган зүйлчлэх, олон улсын хэм хэмжээг хэрэглэх чадвар эзэмшүүлэх, олон улсын болон үндэсний эрх зүйн хэм хэмжээг судлах, хууль ёсыг дээдлэх хандлага төлөвшүүлэхэд чиглэсэн байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа дөрөвдүгээр бүлэгт Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны онцлог, прокурорын хяналт, энэ төрлийн гэмт хэргийн нотлох баримт, нотолбол зохих байдлууд, анхаарах асуудал, Мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах тактик, арга зүй, Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах журам, прокурорын хяналт, Гэмт хэргийг илрүүлэхэд туслалцаа үзүүлэх, хамтран ажиллах этгээдээр тогтоох, Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт шүүхийн шинжилгээ хийх, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих прокурорын бүрэн эрх, анхаарах асуудал зэргийг авч үзсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны онцлог, нотолбол зохих байдал, мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах тактик, арга зүй, энэ төрлийн гэмт хэрэгт шинжилгээ хийх ажиллагаа болон ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих прокурорын бүрэн эрх, анхаарах асуудлын талаар мэдлэг, чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа тавдугаар бүлэгт Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ерөнхий нөхцөл, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн нотлох баримтыг шинжлэн судлах, үнэлэх, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт Эрүүгийн хуулийг хэрэглэх, эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг авч үзсэн Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх, энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд анхаарах асуудлын талаар мэдлэг, чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн байна.

Тус гарын авлагыг боловсруулахдаа бүлэг бүрийн зорилгыг тодорхойлж, хяналтын асуулт, дасгал ажил, тест, тестийн хариулт зэргийг боловсруулсан иж бүрэн сургалтын материал болсон байна.

2.5. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл

“Хар тамхины гэмт явдал, шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл (2018)



Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн захирал, Хууль зүйн доктор, профессор, цагдаагийн хурандаа **Б.Болдбаатар** “Хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэж буй хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал” илтгэлдээ хар тамхи, мансууруулах бодисын ойлголт, 2018 оны нөхцөл байдал, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгсдийн судалгааг хийж, Монгол Улс дахь хууль тогтоомжийн хэрэглээг судалж, Эрүүгийн эрх зүй дэх олон улсын гэрээ конвенцын зөрчлийг тодорхойлж, мөрдөн шалгахад анхаарах зүйлсийг дурджээ.

Уг судалгааг үндэслэн Монгол Улсад мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ өсөн нэмэгдэж, суурин газруудад илүү түгээмэл болж, өсвөр үеийн хүүхэд, залуучууд хэрэглэгч болж байгаа нь нийгмийн аюулын түвшнийг нэмэгдүүлж байна. Хууль тогтоомжийн хэрэгжилт, хууль сахиулах байгууллагуудын уялдаа холбоо хангалтгүй, хөрөнгө санхүү, мэргэжлийн боловсон хүчний дутагдал зэрэг шалтгаанаар гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаа дэлхийн чиг хандлагаас хоцорч байна. Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож, олон улсын туршлагыг судлан, өөрийн орны онцлогт нийцүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн дүгнэлт хийжээ. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд урьдчилан сэргийлэх ажлыг боловсролын байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зохистой хэлбэрээр явуулах, сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх мэргэжилтэн бэлтгэж, “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг бодитоор хэрэгжүүлж, хууль сахиулах байгууллагын алба хаагчдыг мэргэшүүлэх сургалт зохион байгуулах, хил орчмын хяналтыг сайжруулах, байгууллагуудын уялдаа холбоог шинэчлэх шаардлагатай. Мөн Эрүүгийн хуульд бодисын найрлага, тунгийн хэмжээг нарийвчлан тогтоож, ялын бодлогыг ялгамжтай болгох, бие даасан байгууллага байгуулан төрийн бодлогыг хэрэгжүүлэх нь зайлшгүй гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын дарга, цагдаагийн хурандаа Х.Доржсүрэн “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, цаашдын хандлага” илтгэлдээ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх эрх зүйн орчин, БНХАУ, ОХУ, Европын зарим улс болон Монгол улсын нөхцөл байдал, мансууруулах зорилгоор хэрэглэж байгаа НҮБ-ын жагсаалтад ороогүй эм, бодисын эргэлт, энэ төрлийн гэмт хэргээс

урьдчилан сэргийлэх, мансууруулах үйлчлээтэй ургамлын тархац, устгалын талаар судалж, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж байгаа шалтгаан нөхцөлийг тодорхойлсон байна.

Уг судалгааг үндэслэн хар тамхи, мансууруулах бодисыг улсын хилээр нэвтрүүлэх арга нарийсаж, олон улсын шуудан, цахилгаан бараа, өргөн хэрэглээний бүтээгдэхүүнд нуун далдлах, мөн тээвэрлэгч этгээдийг ашиглах зэрэг зохион байгуулалттай шинжтэй болж байна. Энэ төрлийн бодис хэрэглэсэн этгээдүүд бусад ноцтой гэмт хэрэг (хүнийг алах, хулгайлах, хүчиндэх, дээрэмдэх гэх мэт) үйлдэх эрсдэл өндөр бөгөөд цаашид илүү аюултай гэмт бүлэглэл бий болох магадлалтай гэсэн дүгнэлт хийжээ. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэхийн тулд их, дээд сургуулиудыг түшиглэн мэргэжлийн байгууллагуудтай хамтран судалгаа хийх шаардлагатай. Хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан хүүхэд, залуучуудад зориулсан хор хөнөөлийн талаарх мэдээллийг стандартчилж, цогц хэлбэрээр хүргэх, ерөнхий боловсролын ахлах ангиудад тогтмол сургалт зохион байгуулах, төрийн болон төрийн бус байгууллагуудыг урьдчилан сэргийлэх ажилд өргөнөөр оролцуулах хэрэгтэй. Мөн хар тамхийг сурталчилсан кино, бичлэгт Монгол Улсаас хандах хандалтыг хязгаарлах зохион байгуулалтын арга хэмжээг Харилцаа холбооны зохицуулах байгууллагатай хамтран хэрэгжүүлэх шаардлагатай. Мансууруулах үйлчилгээтэй ургамал, тухайлбал каннабисын тархцын судалгааг шинэчилж, мэргэжлийн байгууллагаар устгах аргачлал боловсруулан, устгалын ажлыг тогтмол зохион явуулах нь чухал гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Үндэсний статистикийн хорооны Үндэсний тооцоо, шинжилгээ, судалгааны газрын дарга, доктор (Ph.D), профессор А.Дэмбэрэл, Үндэсний статистикийн хорооны Үндэсний тооцоо, шинжилгээ, судалгааны газрын статистикч, эдийн засгийн ухааны магистр Ц.Тэгшжаргал “Хууль бус үйл ажиллагааны үр дүнг эдийн засагт тооцож оруулах нь (хар тамхины жишээн дээр)” илтгэлдээ “Евростат”-ын 2008 оны “Далд эдийн засгийн хэмжээг тооцох” гарын авлага, НҮБ-ын Европын эдийн засаг, нийгмийн комиссоос гаргасан 2010 онд гаргасан “Үндэсний тооцооны хүрээнд далд эдийн засгийг тооцох нь” гарын авлагын дагуу хар тамхи, мансууруулах бодисын далд эдийн засгийн ангилал, тооцооллыг хийх аргачлалыг судалж, 2008-2011 онд бүртгэгдсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, энэ төрлийн гэмт хэргийн далд эдийн засгийг тодорхойлоход учирч байгаа хүндрэл, бэрхшээлийг тодорхойлжээ.

Уг судалгааг үндэслэн хар тамхи мансууруулах бодисын тооцооллыг хийх мэдээллийн эх үүсвэрийг сайжруулах, хууль бус үйл ажиллагааны тооцооллыг үнэн зөв бодитой тооцоход байгууллага хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх, тогтворжуулах, мэдээллийг түргэн шуурхай гаргах, гарсан үр дүнг бодлого боловсруулах, шийдвэр гаргахад ашиглах шаардлагатай гэж дүгнэжээ.

Гаалийн ерөнхий газрын Хар тамхины хяналтын албаны дарга Б.Сүхбаатар “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэргийн нөхцөл байдал, чиг хандлага, тулгамдсан асуудлууд” илтгэлдээ гаалийн байгууллагаас 2010-2018 онд илрүүлсэн бодис, түүний төрөл, улсын хилээр нэвтрүүлж байгаа онцлог зэрэг нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, Монгол Улсын хууль тогтоомжид улсын хилээр нэвтрүүлэхийг

хориглоогүй тодорхой төрлийн бодистой тэмцэж байгаа арга зүйг судалсан байна.

Уг судалгааг үндэслэн Монгол Улсын хилээр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хууль бусаар нэвтрүүлэх арга хэлбэр улам нарийсан, зохион байгуулалттай болж, гэмт хэргийн тоо, давтамж өсөн нэмэгдэж, нэвтрүүлж буй бодисын хүний эрүүл мэндэд учруулах эрсдэл өсөж, хоруу чанар ихсэж байна гэж дүгнэжээ. Мөн гаалийн байгууллагын хяналтыг сайжруулахын тулд нөөцийг зөв хуваарилах, хүний нөөцийг тогтмол сургаж мэргэшүүлэх, эрэлч нохойн сургалт, багаж төхөөрөмжийн хангалтыг сайжруулах, хяналт шалгалтын үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор теле хяналт, удирдлагын нэгдсэн төв байгуулж, зорчигчийн мэдээллийг урьдчилан боловсруулах APIS, CAIS системийг холбох, шуудан болон тээвэр зуучлалын байгууллагуудын хяналт, мэдээллийн цахим системийг нэвтрүүлж, мэдээлэл солилцоог шуурхай болгох нь зүйтэй гэсэн санал дэвшүүлжээ.

Шинжлэх ухааны академийн Ургамлын аймаг, ангилал зүйн лабораторийн эрхлэгч, доктор М.Ургамал “Монгол орны мансууруулах үйлчилгээтэй ургамлын төрөл зүйл, тархцын өнөөгийн нөхцөл байдал” илтгэлдээ ШУА-ын Ботаникийн хүрээлэн, ТЕГ, ЦЕГ-ын ЭЦГ-тай 2014 онд хамтран явуулсан “Мансууруулах, донтуулах төрлийн ургамлын тархац-нөөц тогтоох” сэдэвт судалгааны ажлыг 9 овог, 11 төрөл, 18 зүйл хэсгийн ургамалд явуулж, тус ургамлын тархсан байдал, морфологийн шинж, цэцэглэх, үрлэх хугацаа, хэрэглэгдэх эрхтэн зэргийг, мөн 2018 онд Барселоны Их сургуулийн эрдэмтэдтэй хамтран явуулсан мансууруулах үйлчилгээтэй ургамлын ургах орчин, экологийн судалгааг Хэнтий, Дорнод говь зэрэг 11 аймгийн нутгуудад 10-15 мянган га газарт явуулж, үржил хурдан явагддаг, өрсөлдөх чадвар өндөртэйг тогтоосон байна.

Уг судалгааны үр дүнд дээрх аймгуудад ургасан байдал нь өтгөн, өндөр бүрхэвч үүсгэж тархаж байна гэсэн дүгнэлт хийжээ. Таримал олс ургамлыг устгахдаа ШУА, ХААИС болон мэргэжлийн хүрээлэнгийн мэргэжилтнүүдтэй хамтран биологийн болон механик аргыг хэрэглэж, цэцэглэхээс өмнө буюу хавар 5 дугаар сард гүйцэтгэж, залуу бүлгэмдлийг эхний 3 жилд тасралтгүй устгах, хот суурин газар, тариалангийн талбайд ургаж буй ургамлыг нарийн хянаж, устгах, устгал явуулсан газрыг хэвийн ногоон ургамлаар нөхөн сэргээх шаардлагатай гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Хууль сахиулахын их сургуулийн Цагдаа судлалын төвийн эрхлэгч, доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа Ч.Нямсүрэн, Хууль сахиулахуйн инновацын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр О.Уулзахжаргал “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн ялын бодлого” илтгэлдээ Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодистой холбогдсон 2010-2017 онд шүүхээр шийдэгдсэн эрүүгийн хэргийн нөхцөл байдал, Англи, Голланд, Герман, Уругвай, Канад, Чех, Португали, АНУ, Испани, Израйл, БНАСУ, БНХАУ, Казакстан улсын энэ төрлийн бодистой хийж байгаа урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар, Австри, Франц, Швейцари, Швед, Унгар, Польш, Грек Энэтхэг, Бангладеш, Малайз, БНӨСУ, Тайланд, Турк, БНХАУ, Саудын Араб улсын энэ төрлийн бодистой холбогдсон гэмт хэрэгт оногдуулж байгаа ялын бодлогод дүн шинжилгээ хийсэн байна.

Уг судалгааны үр дүнд “Наркотерроризм” даяаршлын үзэгдэл болон хувирч, гадаадын орнуудад эдийн засаг, улс төрийн зорилгод мансууруулах бодис ашиглах явдал хэмээн тодорхойлж, хэрэглэгчдийг салгах замаар наркобизнесийн санхүүгийн эх үүсвэрийг таслахыг хамгийн үр нөлөөтэй арга гэж үздэг байна. Монгол Улсад энэ төрлийн хэрэг жилээс жилд нэмэгдэж, Зүүн өмнөд Азийн мафийн сүлжээний нөлөөнд орон, нийгмийн тулгамдсан асуудал болон хувирсан байна гэж дүгнэжээ. Энэ төрлийн гэмт хэрэгтэй зөвхөн эрүүгийн хатуу бодлогоор бус, эрүүгийн хуулиар мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хэмжээг гадаадын жишгээр тодорхой хуульчилж, түүнд тохирсон ял, хариуцлага тогтоох; холбогдох байгууллагын ажилтнуудыг мэргэшүүлэх, тус бодисыг илрүүлэх техник, лабораторийн чадавхыг нэмэгдүүлж, хил гаалийн хяналтыг чангатгах, хүүхэд, залуучуудад хор уршгийг таниулах сургалт, ухуулга явуулах, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, хэрэглэгчдийг эмчлэх зэрэг урьдчилан сэргийлэх замаар хар тамхины хэрэгцээг бууруулж, бизнесийн орон зайг үгүй хийх зэрэг цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Хууль сахиулахын их сургуулийн Шинжлэн магадлахуй судлалын төвийн эрхлэгч, доктор Б.Даваа “Мансууруулах үйлчилгээтэй ургамлын гадаад шинж тэмдгээр шүүх-ургамлын шинжилгээ хийх боломж” илтгэлдээ Шүүх шинжилгээний байгууллагад энэ төрлийн гэмт хэрэгт 2013-2017 онд хийгдсэн хими, физик, биологийн шинжилгээ, түүнийг хийж байгаа техник хэрэгсэл, Монгол Улсад тархсан мансууруулах, донтуулах үйлчилгээтэй ургамлын тархац, нэр, төрөл, морфологийн шинж, түүнд хийгддэг шүүх-ургамал судлалын шинжилгээний талаар судалсан байна.

Уг судалгааны үр дүнд Монгол Улсад хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар олж авах, хэрэглэх, боловсруулах, борлуулах, хил дамнуулан тээвэрлэх гэмт хэрэг эрчимтэй нэмэгдэж, хүн амын эрүүл мэнд, хэвийн амьдралд сөргөөр нөлөөлөх болзошгүй байна. Эдгээр гэмт хэргийн ихэнх хэсгийг (50-60 хувь) мансууруулах үйлчилгээтэй каннабисын төрлийн ургамалтай холбоотой үйлддэг бөгөөд энэ ургамал 14 аймгийн 49 сумын 5230 га, улсын хэмжээнд 15000 га талбайд ургаж байна. Хэргийн газарт ургамлыг биологийн аргаар тодорхойлох нь гэмт хэргийг түргэн шуурхай таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ач холбогдолтой гэсэн дүгнэлт хийжээ. Хар тамхи, мансууруулах төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх алба хаагчид, суралдагчдад хэргийн газарт ургамлыг таних биологийн мэдлэг олгох сургалт зохион байгуулах, гарын авлага болон зөвлөмж боловсруулах нь мэргэжлийн мэдлэгийг дээшлүүлэх, гэмт хэргийг урьдчилан илрүүлэх, таслан зогсоох үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэнэ гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Доктор, дэд профессор Ж.Мөнхболд, докторант Б.Мөнхзаяа нар “Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус хэрэглээ далд эдийн засагт нөлөөлөх нь” илтгэлдээ далд эдийн засгийн ойлголт, төрөл, хэлбэр, гэмт хэргээс олох ашиг, орлого, түүнд эзлэх хар тамхины хууль бус эргэлт, түүний схем, олон улс дахь сүлжээ, тодорхой улс дахь сүлжээний зураглалыг судалсан байна.

Уг судалгааны үр дүнд дэлхийн эдийн засгийн глобалчлал, улс хоорондын эдийн засгийн томоохон өөрчлөлттэй уялдуулан Монгол Улсад эдийн засгийн

аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг үйлдэхийг ашиггүй болгох эрх зүй, зохион байгуулалт, арга зүйн арга хэмжээг хөгжүүлэх шаардлага бий болж байна. Мөн далд эдийн засгийн нэг хэлбэр болох мансууруулах бодис, хар тамхины хууль бус эргэлт, хэрэглэгчдийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг Монгол орны газар зүй, хүн ам, соёл, нийгмийн бүтцэд тохируулан зохион байгуулах нь чухал гэсэн дүгнэлт хийжээ. Эрүүгийн хууль тогтоомжид эдийн засгийн шинжилгээ хийх, хар тамхи болон бусад зохион байгуулалттай гэмт хэргийн ялын бодлого, урьдчилан сэргийлэх арга замыг орчин үеийн шинжлэх ухааны арга зүйгээр тооцох. Мансууруулах бодисын хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх, хэрэглэгч бүлэг үүсгэхгүй байх хяналт, эрх зүйн бодлогыг боловсронгуй болгох. Мөн нийгэмд үүсэж болох сөрөг үзэгдлээс урьдчилан сэргийлэх санхүүгийн механизм, далд эдийн засгийн судалгаа, мониторингийг идэвхжүүлэх шаардлагатай гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн ШСЭСК-ийн эрхлэгч С.Байгальмаа, СЭМҮТ-ийн ерөнхий захирал, анагаах ухааны доктор, дэд профессор Л.Насанцэнгэл “Мансууруулах, сэтгэц идэвхт эм бодис хэрэглэхэд нөлөөлсөн зарим эрсдэлт хүчин зүйлс, уг төрлийн гэмт хэрэгт холбогдогсдын сэтгэцийн шинж, темпераментын онцлогийг судалсан нь” илтгэлдээ Монгол Улсад мансууруулах, сэтгэц идэвхт эм бодисын хэрэглээ жилээс жилд нэмэгдэж байна. Мансууруулах, сэтгэц идэвхт эм бодисыг хэрэглэхэд нөлөөлж буй зарим эрсдэлт хүчин зүйлс болон энэ төрлийн гэмт хэрэгт холбогдогсдын сэтгэцийн шинж, темпераментын онцлогийг төв мэдрэлийн системийн үйл ажиллагааг цочроох үйлчлэлийн үндсэн дээр судалсан байна.

Дээрх судлааг үндэслэн оролцогчдын 88,7% нь эрэгтэй, 67% нь огт гэрлээгүй хүмүүс байгаа нь гэрлээгүй эрэгтэйчүүд мансууруулах, сэтгэц идэвхт илүү түлхүү хэрэглэх хандлагатай, 34,9% нь их, дээд сургуулийн оюутан залуучууд, нийт 88 оролцогчийн 65%-д нь шээсний шинжилгээгээр ТНС (тетрагидроканнабинол) илэрсэн нь каннабиноидын хэрэглээ давамгайлсан гэсэн дүгнэлт хийжээ.

Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа Н.Ганбадрал, Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, цагдаагийн хошууч Б.Баянмөнх “Хар тамхитай тэмцэхэд хэв журмын алба хаагчдын үүрэг оролцоог нэмэгдүүлэх зарим асуудал” илтгэлдээ хар тамхи, мансууруулах бодисын Монгол Улсад нийлүүлэлт хийгддэг нөхцөл байдал, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ялын бодлогод баримталж байгаа 2 хандлагыг судалж, цагдаагийн байгууллагад ажилладаг 95 алба хаагчаас түүврийн байдлаар энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх судалгаа авч, дүн шинжилгээ хийсэн байна.

Уг судалгааны үр дүнд хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хэрэглэгчдийн бүлэг сүлжээ Монгол Улсад жил бүр өсөн нэмэгдэж байна. Мөн зөвхөн хар тамхитай тэмцэх тусгай алба хаагчдыг сургаж бэлтгэх нь хангалтгүй бөгөөд цагдаагийн нийт алба хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх замаар энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт,

таслан зогсоох үр нөлөөг дээшлүүлэх боломжтой гэсэн дүгнэлт хийжээ. Цагдаагийн бүх алба хаагчдад хар тамхи, мансууруулах бодисын танин мэдэхүйн мэдлэг, илрүүлэх ур чадварыг багтаасан цогц сургалт явуулах, нутаг дэвсгэрийн цагдаагийн газар, хэлтэс бүрд урьдчилан сэргийлэх ажлыг хариуцсан дагнасан албан тушаалыг бий болгож хэрэгжилтэд хяналт тавих, хил, гааль, тагнуул, мэргэжлийн хяналт зэрэг байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулан мэдээллийн нэгдсэн төв байгуулах, гэмт хэрэгт холбогдсон этгээдэд эрүүгийн хариуцлагыг чангатгах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн Гүйцэтгэх ажлын тэнхимийн дэд профессор, цагдаагийн хошууч Р.Баярмагнай “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хүний биед үйлчлэх хор хөнөөл” илтгэлдээ Монгол Улсад хар тамхи, мансууруулах төрлийн бодистой холбоотой гэмт хэргийн холбогдогчдын төрлийг тодорхойлж, энэ төрлийн бодисын хууль бус эргэлт, хэрэглээтэй тэмцэх НҮБ-ын 1961 оны Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц, НҮБ-ын 1971 оны Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенцод дүн шинжилгээ хийсэн байна.

Уг судалгааны үр дүнд Монгол Улсад мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ хүүхэд, залуучуудын дунд зонхилж, хэрэглэгчдийн дундаж нас 33.9, түүнээс хэрэглэгчдийн 56% нь 16-25 насандаа анх хэрэглэж эхэлсэн бөгөөд донтсон хүний эрүүл болох магадлал ердөө 5% байгаа нь аюултай түвшнийг харуулж байна. Хууль эрх зүйн орчны хувьд Эрүүгийн хуулийн зарим заалт, 2002 оны холбогдох хуулиудын нэр томьёо, эд хөрөнгө хураах ялын зохицуулалт НҮБ-ын конвенцын үзэл баримтлалтай зөрчилдөж байна гэсэн дүгнэлт хийжээ. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн талаарх мэдээллийг урьдчилан хянаж нягтлах, хууль тогтоомжийн хүрээнд шинээр батлагдсан Эрүүгийн хуулийн давхардлыг арилгаж, тайлбар гаргах. Мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн оролцогчдод мэргэжлийн зөвлөгөө өгөх сэтгэл зүйч бэлтгэх, төрийн болон төрийн бус байгууллагын алба хаагчдыг сургалтад хамруулах замаар мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх гэсэн санал дэвшүүлжээ.

Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн тэнхимийн дэд профессор, цагдаагийн хошууч Н.Манлайбаатар “Хар тамхины гэмт хэргийг мөрдөн шалгахад тулгамдаж буй асуудал” илтгэлдээ 2016-2018 онд үйлдэгдсэн энэ төрлийн гэмт хэргийн Монгол Улсын нөхцөл байдал, холбогдогч нарын онцлогийг судалж, мөрдөн шалгах ажиллагаанд анхаарах асуудлыг судалж, хар тамхи, мансууруулах бодис нь овор хэмжээ багатай, нуух боломж ихтэй учраас үзлэг, нэгжлэг хийхэд албаны нохой ашиглан нуугдмал бодисыг илрүүлэх талаар судалжээ.

Уг судалгааны үр дүнд энэ төрлийн гэмт хэрэг нь эд мөрийн баримтгүйгээр бүрэлдэхүүний шинжээ алддаг тул хойшлуулшгүй ажиллагааг шуурхай явуулж, хэрэгт ач холбогдолтой эд мөрийн баримтыг бэхжүүлэх шаардлагатай. Мөн шинжээчийн дүгнэлт гол нотлох баримт болдог тул мөрдөгч, прокурор түүнийг бусад эх сурвалжтай хамтатган нарийвчлан шалгах нь чухал гэж дүгнэсэн байна. Энэ төрлийн гэмт хэрэг нь далд, зохион байгуулалттай аргаар

үйлдэгддэг тул ил мөрдөн шалгах ажиллагаагаар илрүүлэхэд хүндрэлтэй, харин нууц ажиллагаа үр дүнтэй байгааг практик харуулж байна. Сүүлийн жилүүдэд хар тамхины гэмт хэрэгт холбогдон шийтгэгдсэн этгээдүүд дахин хэрэг үйлдэхдээ илүү нарийн зохион байгуулалттай, нуугдмал хэлбэрээр үйлдэж байгаа тул мөрдөн шалгах ажиллагаанд мэргэжилтний хамтын ажиллагаа, техник хэрэгслийн дэвшилтэт аргыг өргөн ашиглах шаардлагатай гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн ахлах багш, цагдаагийн хошууч Л.Бат-Очир “Хар тамхи ба өсвөр үе, урьдчилан сэргийлэх арга зам” илтгэлдээ Монгол Улсын засгийн газраас баталсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, хэрэгжүүлж байгаа зарим арга хэмжээ, энэ төрлийн гэмт хэрэг холбогдогчдын нөхцөл байдал, Цагдаагийн байгууллага, Монголын сурагчдын холбоотой хамтран 1000 хүүхдээс авсан судалгааны үр дүн, тухайн төрлийн бодисын үйлчлэл, нөлөөлөл зэргийг судалсан байна.

Уг судалгааны үр дүнд хүүхэд, залуучууд мансууруулах бодисын гол өртөгч болж байгаа нь амьжиргааны түвшин доогуур, мэдээлэл дутмаг, эцэг эхийн хяналт сул, амар хялбар аргаар ашиг олох сонирхол, бүлэглэлийн нөлөө, хил орчмын эрсдэл, эмийн сангийн хяналт муу зэрэг хүчин зүйлтэй холбоотой бөгөөд каннабис, мөс, кашиш, “Ми Ми” зэрэг бодисын хэрэглээ өсөж, байнгын хэрэглэгчдийн давхарга бий болж байна. Энэ нь гэмт хэргийн сүлжээ, бүлэглэл үүсэх нөхцөлийг бүрдүүлж, илүү зохион байгуулалттай, далд шинжтэй болж байгаа тул хууль сахиулах байгууллагын уялдаа холбоог сайжруулах, хил гаалийн шалгалтыг чангатгах, эмийн сангийн хяналтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хүүхэд, залуучуудын сэтгэл зүйд тохирсон урьдчилан сэргийлэх, эмчилгээ, сэргээх ажлыг шинжлэх ухаанд суурилан хэрэгжүүлэх шаардлагатай байна гэж дүгнэжээ. Хар тамхины хэрэглээг бууруулахад урьдчилан сэргийлэх, албадан эмчлэх, нийгэмшүүлэхэд дагнасан эмнэлэг байгуулах, эрүүгийн хуульд “хэрэглэх”, “биедээ авч явах” үйлдлийг гэмт хэрэгт тооцох, хил гааль болон хууль сахиулах байгууллагын уялдаа холбоо, алба хаагчдын мэргэшлийг сайжруулахад анхаарах шаардлагатай. Мөн өсвөр насныхны хяналт, боловсролыг дээшлүүлэх зорилгоор сургуулийн хөтөлбөрт хар тамхины хор хөнөөлийн сэдвийг тусган сургагч багш бэлтгэх, тасралтгүй сургалт сурталчилгаа явуулах, өндөр эрсдэлтэй бүлэг, эмийн сан, баар, клуб, цахим орчинд тавих хяналтыг чангатгаж, олон улсын туршлагаас суралцан хамтын ажиллагааг бэхжүүлэх нь зүйтэй гэж дүгнэжээ.

Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, цагдаагийн хошууч Г.Бямбадорж “Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт хийх биечилсэн судалгаа, түүнийг хэрэглэсэн эсэхийг шалгах арга” илтгэлдээ Монгол Улсад 2016-2018 оны 8 дугаарын байдлаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдогсдын байдал, 2016, 2017 онд СЭМҮТ-д хэвтэн эмчлүүлэгсдийн байдалд дүн шинжилгээ хийж, энэ төрлийн тэмцэхэд цагдаагийн алба хаагчаас биечилсэн сурвалжилга явуулах, мансууруулах бодис мөн эсэх, тухайн бодисыг хэрэглэсэн эсэхийг таних арга, ажиллагааны талаар судалсан байна.

Уг судалгааны үр дүнд хар тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлтэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэж байгаа ажиллагаа үр дүн муутай байна. Алба хаагчид уг төрлийн гэмт хэргийн шалгалт, тактик арга ажиллагаанд мэргэшээгүй, тэмцэх идэвх сул, давтамж багатай, байгууллагуудын хоорондын уялдаа холбоо сул, мэдлэг, ур чадвар дутмаг байна гэсэн дүгнэлт хийжээ. Эдгээр байгууллагуудыг бодлогын төвлөрсөн удирдлагад нэгтгэх, байнгын ажиллагаатай нэгж байгуулах, донтох эмгэгийг судлах, эмч нарыг мэргэшүүлэх сургалт явуулах, тус бодисын дээжийн санг бий болгож харьцуулан судлах, тусгай зориулалт бүхий техник хэрэгсэл, криминалистикийн багажийг жижүүрийн албанд байршуулж, нутаг дэвсгэрийн хяналтыг сайжруулах, хяналт шалгалт, мэдээлэл цуглуулах ажлыг шинэ шатанд гаргах шаардлагатай гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн тэнхимийн ахлах багш, цагдаагийн хошууч Б.Эрдэнэбат “Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хамтын ажиллагаа” илтгэлдээ Монгол Улсын хэмжээнд 2018 онд үйлдэгдсэн гэмт хэрэг, түүнээс хар тамхи мансууруулах бодистой холбогдсон гэмт хэргийн нөхцөл байдал, статистик мэдээ, ТББ-аас хийсэн судалгаа, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын хамтын ажиллагаа, эрх зүйн зохицуулалтын онцлогийг судалсан байна.

Уг судалгааны үр дүнд Монгол Улс гадаадтай Эрүүгийн эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулаагүй ч, нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцыг ашиглан гадаад улсад мөрдөн шалгах ажиллагааг бүрэн хэмжээнд явуулах боломжтой. Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь олон улсын эрх зүйн хүрээнд үр дүнтэй байж болох ч хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай байна. гэсэн дүгнэлт хийжээ. Хөрш орнуудтай 2 талт гэрээ байгуулж мөрдөн шалгах ажиллагаа, урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах; гадаад орны туршлага солилцох, мэргэшсэн алба хаагчдыг бэлтгэх, орчин үеийн тоног төхөөрөмж, лаборатори, сургалтын төвийг хөгжүүлэх, цахим орчин дахь мансууруулах бодисын худалдааг урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх, Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх үйл ажиллагааны судалгааг тасралтгүй явуулах шаардлагатай гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Хууль сахиулахын их сургуулийн багш, докторант, цагдаагийн ахлах дэслэгч Б.Алтансүх “Хар тамхины гэмт явдалтай тэмцэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт” илтгэлдээ хар тамхины гэмт явдалтай тэмцэх олон улсын эрх зүйн зохицуулалт, Монгол Улсын Үндэсийн хууль тогтоомж, тэр дундаа эрүүгийн эрх зүйн зохицуулалт, 2002, 2015 оны эрүүгийн хуулийн харьцуулалт, БНХАУ-ын эрүүгийн эрх зүйн бодлогыг харьцуулсан судалсан байна.

Уг судалгааны үр дүнд Монгол Улсад хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар олж авах, хэрэглэх, боловсруулах, зарж борлуулах, хил дамнуулан тээвэрлэх явдал эрс нэмэгдэж, гадаадын иргэд оролцох нь өссөн нь хүн амын эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдалд эрсдэл учруулж байна. Судалгаагаар хар тамхитай холбоотой гэмт хэргийн шалтгаан нь хил, гаалийн хяналт хангалтгүй,

хууль эрх зүйн орчин сул, хариуцлагын тогтолцоо сул, мэргэшсэн хүний нөөц дутмаг, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүн хангалтгүй байгаатай холбоотой бөгөөд мансууруулах бодисын хууль бус эргэлт улам зохион байгуулалттай болж, үйлдлийн арга хэлбэр нь жил ирэх бүр нарийсаж, далд хэлбэрт шилжиж байна гэсэн дүгнэлт хийжээ. Монгол Улс 1961, 1971, 1988, 2008 оны НҮБ-ын холбогдох конвенцуудыг батлан нэгдэн орсон бөгөөд мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэх олон улсын өмнө хариуцлага хүлээдэг. Тиймээс энэ чиглэлээр олон улсын стандартыг баримтлан, хууль эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, хил, гаалийн хяналтыг бэхжүүлэх, мэргэшсэн хүний нөөцийг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар, докторант Э.Идэрцог “Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн хэргийн газрын үзлэг хийхэд анхаарах асуудал” илтгэлдээ хэргийн газрын үзлэг явуулж ирсэн түүхэн хөгжил, , түүний мөн чанар, зорилго мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгт үзлэг хийх онцлог, оролцогчдын хамтын ажиллагаа, анхаарах асуудлыг судалсан байна.

Уг судалгааны үр дүнд Монгол Улсад "Хар тамхитай тэмцэх газар" 2018 оноос Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд даргын шууд удирдлагад шилжиж, 30 гаруй алба хаагчтайгаар мэргэшиж, хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийг мөрдөн шалгах чиглэлээр ажиллаж байна. Сүүлийн 5 жилд хийсэн статистик судалгаагаар тус байгууллагын үйл ажиллагааны үр дүн тодорхой харагдаж байгаа ч анхан шатны дуудлага, мэдээлэлд хариу үзүүлэх, хэргийн газрын үзлэгийн чадавхыг сайжруулах шаардлага байсаар байна гэсэн дүгнэлт хийжээ. Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн газрын үзлэгийг тасралтгүй сургалт, арга зүйн мэргэшлийг сайжруулах; TARGET ID, HBI-120, SABRE™500⁸⁹ зэрэг тоног төхөөрөмж, илрүүлэх тестүүдийг хэрэглэх чадварыг нэмэгдүүлэх, Төрийн албаны тухай хуулийн дагуу алба хаагчдыг түр хугацаагаар Хар тамхитай тэмцэх газарт ажиллуулж практик туршлага эзэмшүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь чухал юм гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Хууль сахиулахын их сургуулийн докторант, цагдаагийн дэд хурандаа Б.Аадарсүх “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлага, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлж, таслан зогсооход зарим аргыг түлхүү ашиглах нь” илтгэлдээ НҮБ-ын үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн конвенц, түүний дагуу Монгол Улсад авч хэрэгжүүлсэн эрх зүйн зохицуулалт, хар тамхи, мансууруулах бодистой холбогдсон гэмт хэргийн дэлхий нийтийн нөхцөл байдал, 2014-2018 онд Монгол Улсад үйлдэгдсэн энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдал, тэмцэх эрх зүйн орчны талаар судалсан байна.

Уг судалгааны үр дүнд дэлхийн хар тамхи, мансууруулах бодисын зах зээлийн чиг хандлагаар экстази, каннабис түгээмэл болж, амфетамин зонхилох байр суурь эзэлж байна. Монгол Улсын нутаг дэвсгэр Азиас гаралтай героины урсгал, худалдааны гол замд оршиж, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт

бодистой холбоотой гэмт хэрэг, хууль бус хэрэглээ, зах зээл өсөж, донтогч, хэрэглэгчдийн хүрээ тэлж, гэмт бүлэглэлүүд дамжин өнгөрүүлэх, зах зээлд нэвтрэх оролдлого хийсээр байна. Энэ төрлийн гэмт хэрэг улс дамнасан, зохион байгуулалттай, олон улсын шинж чанартай, мөнгө угаах, терроризмын санхүүгийн эх үүсвэр болж байгаагаар онцлогтой гэсэн дүгнэлт хийжээ. Гэмт хэрэгтэй тэмцэх явцад олж авсан мэдээ, баримтыг нотлох баримт болгон үнэлэх эрх зүйн зохицуулалт тодорхой бус, үндэсний хууль, тогтоомж НҮБ-ын конвенцуудад бүрэн нийцээгүй байна. Иймээс Эрүүгийн болон холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах, хэрэгжилтийн журам боловсруулж, холбогдох байгууллагууд хооронд хамтын ажиллагааг хангах гэрээ байгуулах шаардлагатай байна гэсэн саналыг дэвшүүлсэн байна. Хууль сахиулахын их сургуулийн докторант Ц.Нямгэрэл “Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал” илтгэлдээ энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөл, НҮБ-ын Мансууруулах бодисын тухай конвенц, Сэтгэцэд нөлөөт эмийн тухай конвенц, Мансууруулах болон сэтгэцэд эм, бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, Монгол Улсаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тухайн төрлийн бодисыг 2016-2018 онд улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн байдлыг БНХАУ, ОХУ, Бусад орноор харьцуулсан судалж, энэ төрлийн гэмт хэргээ урьдчилан сэргийлэх асуудлыг судалсан байна.

Уг судалгааны үр дүнд Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэх гэмт хэрэгтэй тэмцэхэд урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх тогтолцоог боловсронгуй болгох, хууль эрх зүйн орчныг сайжруулах, хил орчмын хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай байна. Иймд төрийн болон олон улсын байгууллагуудын уялдаа холбоог бэхжүүлж, мэдээлэл солилцоог сайжруулан, урьдчилан сэргийлэх ажлыг бүх түвшинд эрчимжүүлэх нь зүйтэй гэж дүгнэжээ. Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд салбар хоорондын хамтын ажиллагааг стратегийн түвшинд бэхжүүлэх, хяналт-шалгалтын эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох, мэдээлэл солилцох нэгдсэн сан бүрдүүлэх, техник технологийн дэвшлийг нэвтрүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах, мөн сургалт, соён гэгээрлийн ажлыг тогтмол зохион байгуулах шаардлагатай. Үүнтэй зэрэгцэн төрийн түвшинд нэгдсэн бодлого хэрэгжүүлэх бие даасан байгууллага байгуулах нь уг гэмт хэрэгтэй цогцоор тэмцэхэд үр дүнтэй гэсэн санал дэвшүүлжээ.

Хууль сахиулахын их сургуулийн багш, докторант, цагдаагийн ахлах дэслэгч Б.Алтансүх, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын чиглэлийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч М.Отгонбаатар, Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, Б.Мөнхсэргэлэн нар “Хар тамхины гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар мэргэжилтнүүдийн дунд явуулсан санал асуулгын үр дүн” илтгэлдээ хар тамхитай холбоотой гэмт хэргийн Монгол Улс, БНХАУ-ын нөхцөл байдал, чиг хандлагын талаар харьцуулан судалж, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үүрэг бүхий 100 албан хаагчаас чанарын судалгаа авсан байна.

Уг судалгааны үр дүнд Монгол Улсад хар тамхитай холбоотой гэмт хэрэг тодорхой хяналтад байгаа ч бүрэн гүйцэд тэмцэж чадахгүй байна. Энэ нь хүүхэд, залуусын дунд хэрэглээ нэмэгдсэн, мэдээллийн давтамж ихэссэн, хууль эрх зүйн орчин сул, алба хаагчдын ур чадвар, мэргэшил дутмаг, хяналт шалгалт хангалтгүй, төрийн бус байгууллагуудын оролцоо бага зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж байна. Мөн интернэт, цахим орчин дахь зохих хяналтгүй мэдээлэл өсвөр насны хүүхэд, залуучуудыг сөргөөр нөлөөлж, даган дуурайх эрсдэлийг нэмэгдүүлж байна гэсэн дүгнэлт хийжээ. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль эрх зүйн орчныг сайжруулах, хариуцлагыг чангаруулах, Хар тамхитай тэмцэх газрыг бие даасан бүтэц, мэргэшсэн алба хаагчтай болгох, донтох эмгэгтэй хүнийг албадан эмчлэх, сэтгэл зүйн зөвлөгөө, эмчилгээний төв байгуулах, алба хаагчдын мэргэшлийг дээшлүүлэх, мэргэжлийн ТББ-уудыг идэвхжүүлэх, сургалт, судалгаа, мэдээлэл, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Хууль сахиулахын их сургуулийн Хууль сахиулахын удирдлагын академийн захирал, цагдаагийн хурандаа, докторант П.Батбаатар “Хар тамхитай тэмцэхэд хамтран ажиллаж байгаа гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах талаар америкийн нэгдсэн улсын туршлага, анхаарах асуудал” илтгэлдээ хар тамхитай тэмцэхэд хамтран ажиллаж байгаа гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах хэрэгцээ, шаардлага, энэ чиглэлээр тодорхой амжилтад хүрсэн АНУ-ын Зохион байгуулалттай гэмт хэрэгт хяналт тавих тухай, Гэрчийн аюулгүй байдлын хууль тогтоомжийн онцлог, шинэчлэлийн туршлагыг 1970 оноос хойших статистик үндэслэлтэй судалж, манай улсын хууль тогтоомжид нэвтрүүлэх судалсан байна.

Судалгааг үндэслэн хар тамхины зохион байгуулалттай гэмт хэргийг илрүүлэх, түүнтэй тэмцэх, гэм бурууг нотлоход хамтран ажиллах санамж бичгийн дагуу гэрч, хохирогчийг хамгаалах хөтөлбөрт хамрагдсан этгээдүүд шийдвэрлэх ач холбогдолтой бөгөөд гэрч, хохирогчийг хамгаалах хөтөлбөртэй холбоотой журам, удирдамж, зааврыг Ерөнхий прокурор баталж, Хууль зүйн яам үйл ажиллагааг зохион байгуулан Маршалын алба шууд хэрэгжүүлдэг онцлогтой байна. Тухайн хөтөлбөрт хамрагдахын давуу тал нь үнэн зөв мэдүүлэг өгсний шан харамж биш, харин зөвхөн сайн дурын үндсэн дээр хамтран ажилласны төлөө түүнийг гэмт этгээдүүдийн нөлөөлөл, аюул заналхийллээс хамгаалах арга хэмжээ гэж үздэг байна гэж дүгнэжээ.

Хууль сахиулахын их сургуулийн багш, докторант, цагдаагийн ахлах дэслэгч Б.Алтансүх, Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Хууль сахиулахуйн инновацын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, цагдаагийн ахлах дэслэгч О.Уулзахжаргал, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын чиглэлийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч М.Отгонбаатар “Хар тамхитай холбоотой гэмт хэрэгтэй хэрхэн үр дүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх вэ цахим судалгааны үр дүн” илтгэлдээ цахим асуулгын аргаар нийт 484 иргэнээс хар тамхи, мансууруулах бодисын ерөнхий мэдээлэл, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж байгаа нөхцөл байдал, тухайн төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөл, хүчин зүйлс, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаарх асуулгыг авч, нэгтгэн боловсруулж, дүн шинжилгээ хийсэн байна.

Уг судалгааны үр дүнд иргэдийн 74% нь хар тамхи, мансууруулах бодисын талаар мэдээлэлтэй, энэ төрлийн гэмт хэрэгтэй Монгол Улс үр дүнтэй тэмцэж чадахгүй байгаа гэж үзэж, гэмт хэргийн шалтгааныг гадаадын борлуулагчдаас худалдан авах, хил, гаалиар нэвтрүүлэх арга, хяналт сул, хууль эрх зүйн орчин боловсронгуй бус, хариуцлага сул зэрэгтэй холбон тайлбарлажээ гэсэн дүгнэлт хийжээ. Хар тамхи, мансууруулах бодисын гэмт хэрэгтэй тэмцэхэд хяналт шалгалтыг сайжруулах, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хариуцлагыг чангаруулах шаардлагатай. Мөн иргэд, залуучуудын мэдлэгийг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийн кампанит ажил, орон нутгийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх замаар гэмт хэргийн тархалтыг бууруулах боломжтой гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн Албаны нохой сургалтын хэлтсийн ахлах дасгалжуулагч, цагдаагийн ахмад Г.Энхжаргал “Мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийг илрүүлэхэд албаны нохойг ашиглах нь” илтгэлдээ Монгол Улсын цагдаагийн байгууллагад албаны нохой ашиглаж ирсэн түүхэн уламжлал, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд албаны нохойг сонгох, сургах онцлог, албаны нохойг ашиглаж байгаа өнөөгийн байдал, сургалтын тогтолцоог боловсронгуй болгох арга зам, АНУ, БНХАУ-ын албаны нохойн сургалтын онцлог зэргийг судалсан байна.


Судалгааны дүнгээс үзвэл албаны нохойг мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийг илрүүлэхэд ашиглах боломж бүрэн байгаа бөгөөд үүнд үнэр ба үнэрийн мөрийн онол, нохойн мэдрэлийн үйл ажиллагаа, нөхцөлт рефлексийн механизм, олон жилийн практик туршлага зэрэг нь чухал ач холбогдолтой гэж тогтоогдсон. Албаны нохойг тусгайлсан сургалтаар бэлтгэснээр гэмт хэргийг шуурхай илрүүлэх, эд мөрийн баримтыг нотолгоотой тогтоох, зардал хэмнэх зэрэг давуу талтай гэсэн дүгнэлт хийжээ. Албаны нохойг сургах сургалтыг онол, практикийн холимог аргаар боловсронгуй болгож, бусад чиглэлээр сургаж буй нохойноос өвөрмөц онцлогийг хангах шаардлагатай. Мөн нохой сургагч нь нохойг зөв удирдах, хайрлан ойлголцох, сургах чадвартай мэргэжилтэн байх ёстой бөгөөд энэ нь мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийг илрүүлэх ажлын үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэсэн чухал арга хэмжээ болно гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Хууль сахиулахын их сургуулийн Хууль сахиулахын удирдлагын академийн магистрант Л.Ганшагай “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн шалтгаан ба мөрдөн шалгах ажиллагаанд тулгамдаж буй асуудал” илтгэлдээ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг НҮБ-ын Мансууруулах эмийн тухай, Сэтгэцэд нөлөөт бодисуудын тухай конвенцод заасан хууль зүйн тодорхойлолтын үүднээс болон анагаах ухаан, нийгмийн ухаан, хууль эрх зүйн зүгээс тайлбарлан тодорхойлж, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж байгаа шалтгаан нөхцөл, мөрдөн шалгах ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг тодорхойлсон байна.

Уг судалгааны үндсэн дээр ажилгүйдэл, ядуурал нэмэгдсэнтэй холбоотойгоор иргэд богино хугацаанд их ашиг олох зорилгоор хар тамхи,

мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт татагдах хандлага өсөж байна. Улсын хилээр хууль бус бодис нэвтрүүлэх арга, хэлбэр нарийсаж, олон улсын шуудан, цахилгаан бараа, хүнсний бүтээгдэхүүнд нуух, тээвэрлэгч этгээд ашиглах зэрэг зохион байгуулалттай бүлэглэлийн шинж илрэх болсон. Нийгэм, эдийн засгийн хямрал, иргэдийн сэтгэлзүйн тогтворгүй байдал, стресс, гутрал зэрэг хүчин зүйл нь бодис хэрэглэх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Иймээс мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг, эрсдэлийн түвшнийг тогтоох, нөхцөл байдлын судалгаа, дүн шинжилгээ хийх чиг үүрэг бүхий бие даасан төрийн байгууллага байгуулах шаардлагатай байна.

“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэхэд байгууллагуудын хамтын ажиллагаа” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл (2025)



Нийслэлийн прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих II дугаар хэлтсийн хяналтын прокурор, хууль цаазын дэд зөвлөх Б.Ариунтөр “Нэгдэн орсон олон улсын гэрээнүүдийн хэрэгжилтийн асуудал: монгол улс дахь мансууруулах бодистой холбогдох эрх зүйн зохицуулалтын мэдээллийн хоцрогдол” илтгэлдээ "Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц", "Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц", "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц"-д дүн шинжилгээ хийж, гишүүн орнуудын хүлээсэн үүрэг, шинэ төрлийн бодис, конвенцын зохицуулалтыг судалж, Монгол Улсын шүүхийн практикт тулгамдсан асуудлыг тодорхойлсон байна.

Уг судалгааны үр дүнд Монгол Улс мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой тэмцэх олон улсын гэрээнд нэгдэн орж, эрх зүйн зохицуулалт уялдуулан хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн ч шинэ төрлийн бодисыг хяналтад оруулах хугацааны зөрүүгээс шүүхийн шийдвэрт ялгаатай дүгнэлт гарч байгаа нь эрх зүйн хэрэглээний уялдаа сул байгааг харуулж байна. Олон улсын гэрээ хүчин төгөлдөр болох хугацаа, хэрэглээний журмыг нэг мөр ойлгож, бодисын жагсаалтыг шуурхай шинэчлэх нь хүний эрхийг хамгаалах чухал нөхцөл гэсэн дүгнэлт хийжээ. Олон улсын эрх зүйн мэдээллийг шуурхай, нэгдсэн журмаар шүүх, прокурорт хүргэх механизмыг сайжруулж, цахим мэдээллийн чадамж, сургалт, уялдаа холбоог нэмэгдүүлэх, мөн олон улсын гэрээний хэрэглээг шүүхийн практикт нэг мөр ойлгуулах тайлбар, зөвлөмжийн тогтолцоо бий болгох шаардлагатай гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын дарга, цагдаагийн хурандаа П.Сандагсүрэн, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын Тандалт судалгаа, дүн шинжилгээний тасгийн дарга, цагдаагийн хошууч Б.Зоригтбаатар “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал, тулгамдсан асуудал” илтгэлдээ мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн гэмт хэргийн 2016-2024 оны өсөлт, хил дамнаан үйлдэгдэж байгаа энэ төрлийн гэмт хэрэг, урсгалын чиглэлүүд, хураан авсан бодисын хэмжээ, төрөл, олсны ургамлын тархац, нийгэмд учруулж буй хор уршиг, хэрэглэгчдийн насны бүтэц, далд хэрэглэгчдийн тооцоо, гадаадын иргэдийн оролцоо, Монгол иргэдийн гадаадад ял эдэлж буй байдал зэрэг дотоод нөхцөл байдал, дэлхийн хэмжээнд гэмт хэргийн статистик, Алтан хавирган сар, Алтан гурвалжин зэрэг томоохон үйлдвэрлэгч орнуудын мэдээлэл, Фентанил, синтетик каннабиноид зэрэг шинэ төрлийн бодисын дэлгэрэлт зэрэг гадаад нөхцөл

байдлыг судалж олон улсын ялын бодлогын харьцуулалт зэргийг судалж, энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдал, чиг хандлага, учирч буй хүндрэл, бэрхшээлийг тодорхойлсон байна.

Уг судалгааны үр дүнд сүүлийн 7 жилд Монгол Улсад бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 0.7 хувийг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг эзэлж, үндэсний аюулгүй байдалд ноцтой сөрөг нөлөө үзүүлж байна. Манай улсын ялын бодлого харьцангуй хөнгөн, хил хаагдсанаас хойш Туркулсаас нийлүүлэгдэж буй синтетик бодисын урсгал нэмэгдсэн, цахим орчин, криптовалюта ашигласан хууль бус аргууд түгээмэл болсон нь илрүүлэхэд хүндрэл учруулж байна. Цаашид хэрэглэгчдийн тоо эрс өсөх эрсдэлтэй байгаа тул илүү үр дүнтэй бодлого шаардлагатай гэсэн дүгнэлт хийжээ. Хэрэглэгч, донтогчдын нарийвчилсан тандалт судалгаа хийх, каннабис устгах хуулийн зохицуулалт нэмэх, албадан эмчилгээний төв байгуулах, Зөрчлийн тухай хуулийн хариуцлагыг чангатгах, давтан хэрэглэсэн этгээдэд эрхийн хязгаарлалт тогтоох, мөн хэрэг бүртгэлтийн шатанд таслан сэргийлэх арга хэмжээ авах эрх зүйн зохицуулалтыг нэмэх нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чухал гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D), цагдаагийн хошууч Н.Сайнбаяр “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний тогтолцоонд хийсэн дүн шинжилгээ” илтгэлдээ Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэх олон улсын тогтолцооны эрх зүйн үндэс, түүхэн хөгжил, дэлхийн болон Монгол Улс дахь мансууруулах бодисын нөхцөл байдал, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үүрэг бүхий ҮАБЗ, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хороо, ГХУСАЗЗ, ЦЕГ, ТЕГ, ГЕГ, ХХЕГ, ХТТГ, СЭМҮТ зэрэг байгууллагуудын уялдаа холбоо, эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийж, тулгамдсан асуудлыг тодорхойлсон байна.

Уг судалгааны үр дүнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх асуудал нь зөвхөн Монгол Улсад бус дэлхий нийтийн хэмжээнд тулгамдсан чухал асуудал хэвээр байна. Монгол Улсад энэ чиглэлээр эрх зүйн зохицуулалт, чиг үүргийн байгууллагуудын бүтэц бий болсон ч, үйл ажиллагааны уялдаа холбоо сул, нэгдсэн тогтолцоо бүрдээгүйгээс үр дүн хангалтгүй байгаа нь анхаарал татаж байна. Одоогийн байдлаар байгууллагууд өөр өөрийн хүрээнд тус тусдаа ажиллаж, үр дүнг зөвхөн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр хэмжих хандлага давамгайлж байгаа нь системийн үр ашигт сөргөөр нөлөөлж байна. Мөн энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх зонхилох үүргийг зөвхөн Хууль зүй, дотоод хэргийн яаманд төвлөрүүлэх нь оновчтой биш бөгөөд урьдчилан сэргийлэх, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, донтогчдыг эмчлэх зэрэг бусад салбарыг хамарсан өргөн хүрээний асуудлуудын зохицуулалт шаардлагатай хэвээр байна гэсэн дүгнэлт хийжээ. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэхийн тулд үндэсний хэмжээнд нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай бөгөөд энэ нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжих боломжтой юм. Ийм тогтолцоог бий болгохын тулд зөвхөн хууль хяналтын байгууллагууд бус, эрүүл мэнд, боловсрол, хил гааль, олон улсын хамтын ажиллагаа зэрэг салбаруудын оролцоог хангаж, салбар хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх шаардлагатай. Мөн хууль, дүрэм, журмыг

шинэчлэхдээ салбарын эрдэмтэн судлаачдыг оролцуулан судалгаанд суурилсан шийдэл гаргах, бодлогын түвшинд хамтарсан зохицуулалт хийх нь илүү үр дүнтэй бөгөөд энэ нь мансууруулах бодистой тэмцэх ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлж, нийгмийн эрсдэлийг бууруулах чухал алхам болно гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эм шинжлэх лабораторийн чанар хариуцсан ахлах мэргэжилтэн Ш.Сонинхүү, Баянгол дүүргийн 30 дугаар хорооны “Арвин хурд” өрхийн эрүүл мэндийн төвийн нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн Б.Мөнхчимэг “Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн бүртгэгдсэн байдал, илрүүлэх шинжилгээний аргачлал болон өсвөр насны хүүхдүүдийн мансууралтын байдалд хийсэн дүн шинжилгээ, тулгамдаж буй асуудал” илтгэлдээ Өсвөр насны хүүхдүүдийн дунд хэрэглэгддэг “тебантин” эмийн үйлчилгээ, хор хөнөөл, мансууралтын түвшин, түүнд нөлөөлж буй хүчин зүйл, шалтгаан нөхцөлийг судалж, Чингэлтэй, Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт 2020-2024 онд мансууруулах бодис хэрэглэсэн нийт 127 тохиолдолд дүн шинжилгээ хийж, ахуйн хэрэглээний мансууруулах бодис, “тебантин” эмийн хамаарлыг тогтоосон байна.

Уг судалгааны үр дүнд Монгол Улс сүүлийн жилүүдэд мансууруулах бодисын тээвэрлэгч улсаас хэрэглэгч орон болж, хэрэглээний хүрээ хурдацтай тэлж байна. Энэ нь урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэмцэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна. Өндөр мэдрэг илрүүлэх багаж төхөөрөмжийн хангалт муу байгаа нь илрүүлэлтийн үр дүнд сөргөөр нөлөөлж байгаа тул The Agilent Resolve Raman зэрэг дэвшилтэт төхөөрөмж нэвтрүүлэх хэрэгцээ тулгамдаж байна. Эмийн зохистой хэрэглээний хяналт сул байгаагаас Тебантин буюу Габапентин эмийг өсвөр насныхан хэрэглэж артери, венийн судас бөглөрөх, гараа тайруулах, амь насаа алдах зэрэг эрсдэл гарах болсон талаар дүгнэлт хийжээ. Мансууруулах бодис хэрэглэх өндөр эрсдэлтэй бүсэд хяналтын камер байршуулах, цагдаагийн байгууллагын хяналтад авах, сургуулийн хөтөлбөрт мансуурах бодисын хор хөнөөлийн талаар зөвхөн онолын бус, мэргэжлийн байгууллагын оролцоотой бодит сургалт оруулах, шуудан илгээмж, зорчигч тээврээр бодис нэвтрүүлэх оролдлогыг илрүүлэх хяналтыг чангатгах, энэ төрлийн гэмт хэргийн ялын бодлогыг чангатгах; лабораторийн чадавхыг олон улсын түвшинд хүргэж сайжруулах, хуурамч эм болон мансууруулах бодисын жинхэнэ шинж чанарыг нарийвчлан тогтоох баталгаатай шинжилгээ хийх нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээг төрийн байгууллага, мэргэжлийн салбаруудын уялдаа холбоотойгоор хэрэгжүүлснээр үндэсний аюулгүй байдалд заналхийлж буй мансууруулах бодисын эрсдэлийг бууруулах боломжтой гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Шүүх шинжилгээний ерөнхий газрын Байгалийн ухааны шинжилгээний хэлтсийн Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын шинжилгээний лабораторийн эрхлэгч, цагдаагийн дэд хурандаа Д.Золзаяа, Шүүх шинжилгээний ерөнхий газрын Байгалийн ухааны шинжилгээний хэлтсийн Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын шинжилгээний лабораторийн шинжээч, цагдаагийн ахлах дэслэгч Г.Золжаргал “Монгол Улсад бүртгэгдсэн шинэ төрлийн мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын нөхцөл байдал, чиг хандлага” илтгэлдээ Монгол Улсад 2022 оноос

хойш бүртгэгдэж байгаа шинэ төрлийн сэтгэцэд нөлөөлөх бодис, түүнд шинжилгээ хийх арга зүй, үр дүн, илэрсэн бодисын төрөл, эзлэх хувьд дүн шинжилгээ хийж, НҮБ-ын конвенцын жагсаалтад багтаагүй Монгол улсад хяналтад ороогүй бодисын нөхцөл байдлыг тодорхойлсон байна.

Уг судалгааны үр дүнд Монгол Улсад сүүлийн гурван жилд шинэ төрлийн мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын тоо эрчимтэй нэмэгдэж, 2022-2025 онд нийт 15 төрлийн бодис илэрснээс найман төрөл нь НҮБ-ын конвенцын жагсаалтад багтаж, долоон төрөл нь хяналтад ороогүй байна. Шүүх шинжилгээний дүнгээс харахад ургамлын гаралтай сэтгэцэд нөлөөлөх бодисын эзлэх хувь буурч байгаа бол шинэ төрлийн бодисын эзлэх хувь 2022 онд 1% байсан бол 2025 онд 20% болж хурдацтай өссөн нь ноцтой хандлага юм. Эдгээр шинэ төрлийн бодис дангаараа болон холимог байдлаар илэрч байгаа нь илрүүлэлтийн болон хяналтын тогтолцоонд шинэ сорилт үүсгэж байна гэсэн дүгнэлт хийжээ. Шинэ төрлийн бодисын өсөлтөд үр дүнтэй хариу арга хэмжээ авахын тулд олон улсын туршлагад тулгуурлан хяналтын дотоодын жагсаалтыг яаралтай шинэчилж, конвенцод ороогүй бодисыг хяналтад авах шаардлагатай. Мөн олон улсад илэрч буй шинэ бодисын талаарх мэдээллийг тогтмол авах, алба хаагчдыг мэргэжлийн сургалт, олон улсын чуулганд хамруулж мэдлэгийг нь дээшлүүлэх нь зүйтэй. Шүүх шинжилгээний байгууллагын чадавхыг сайжруулах үүднээс тоног төхөөрөмжийг 5 жил тутам шинэчилж, шинэ төрлийн бодисын стандартыг богино хугацаанд худалдан авах боломжийг бүрдүүлэх, түүнчлэн илэрсэн бодисын мэдээллийг НҮБ-ын холбогдох байгууллагад шуурхай хүргүүлж, мэдээллийн шинэчлэлийг тогтмол хийх шаардлагатай гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Гаалийн ерөнхий газрын Зөрчилтэй тэмцэх газрын Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтсийн дарга Г.Ганзориг “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал, чиг хандлага, байгууллагуудын хамтын ажиллагаа” илтгэлдээ Гаалийн байгууллагын улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалт, тус байгууллагын 2018-2024 онд илрүүлсэн гэмт хэргийн нөхцөл байдал, тухайн төрлийн бодисыг илгээсэн улс, давтамж, улсын хилээр нэвтрүүлсэн үйлдлийн арга зэрэгт дүн шинжилгээ хийж, Цагдаа, Тагнуулын байгууллагатай үр дүнтэй хамтран ажиллах талаар судалсан байна.

Уг судалгааны үр дүнд Монгол Улсад мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэргийн арга хэлбэр нь 2019 оны Ковид-19 цар тахлын өмнө болон дараа эрс өөрчлөгдсөн байна. Цар тахлаас өмнө иргэд гадаадад зорчих үедээ бие болон ачаанд нууж тээвэрлэх арга давамгайлж байсан бол хил хаагдаж, зорчих боломж хязгаарлагдсанаар олон улсын шуудан илгээмжийг ашиглах хэлбэр эрчимтэй нэмэгдсэн байна. Цахим худалдаа болон шуудангийн үйлчилгээний хурдацтай хөгжил нь иргэдэд бараа бүтээгдэхүүн авах боломжийг өргөжүүлж байгаа ч гэмт хэрэгтнүүд энэ сувгийг ашиглан хууль бус бодис нэвтрүүлэх, улмаар хууль хяналтын байгууллагад илрүүлэхэд хүндрэл үүсгэж байна гэсэн дүгнэлт хийжээ. Мансууруулах бодисын хууль бус эргэлтэд олон улсын шуудан илгээмж, цахим худалдааг ашиглах эрсдэл нэмэгдэж байгаа тул иргэдийг энэ төрлийн гэмт хэргийн хохирогчоос урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээллийг тогтмол түгээх шаардлагатай. Тухайлбал,

дайвар ачаа дамжуулах, бусдын бичиг баримт ашиглан захиалга хийх гэмт хэрэгт татагдах эрсдэлийг тайлбарлаж, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт, сурталчилгааг үр дүнтэй зохион байгуулах нь зүйтэй. Мөн хууль хяналтын байгууллагууд олон улсын байгууллага болон шуудангийн үйлчилгээний байгууллагуудтай уялдаа холбоогоо сайжруулж, илрүүлэлтийн арга, технологийг шинэчлэх шаардлагатай гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Зорчигчийн мэдээллийн төвийн Шуурхай удирдлага, дүн шинжилгээний хэлтсийн дүн шинжилгээний ахлах ажилтан, ахмад Д.Бямбасүрэн “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа, боловсронгуй болгох арга зам” илтгэлдээ мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэхэд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн өнөөгийн байдал, Агаарын тээврийн хэрэгслээр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис тээвэрлэх дэлхийн чиг хандлагыг тодорхойлж, Зорчигчийн урьдчилсан мэдээлэл /API/ болон Зорчигчийн нэрийн бүртгэл /PNR/-ийн мэдээллийг ашиглан, дүн шинжилгээ хийж, олон улсын туршлагыг судалж, хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах замаар олон улсын түвшинд мэдээлэл солилцох механизмыг боловсронгуй болгох, нэгдмэл шийдвэр гаргах нөхцөлийг судалсан байна.

Уг судалгааны үр дүнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, нийгмийн тогтвортой байдал, эдийн засагт ноцтой эрсдэл учруулж байгаа тул хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, хилийн хяналтыг сайжруулах, олон улсын мэдээлэл солилцоог идэвхжүүлэх шаардлагатай байна. Зорчигч мэдээллийн төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, технологийн дэвшлийг ашиглан илрүүлэлтийн үр дүнг нэмэгдүүлэх нь хар тамхины хууль бус наймаатай тэмцэхэд онцгой ач холбогдолтой гэсэн дүгнэлт хийжээ. Мансууруулах бодисын хууль бус эргэлтийг бууруулахын тулд хууль тогтоомжийг олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэх, хил хамгаалалтад дэвшилтэт тоног төхөөрөмж, мэдээллийн систем нэвтрүүлэх, НҮБ болон бусад олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, хууль сахиулах байгууллагын ажилтнуудад зориулсан мэргэжлийн сургалтыг тогтмол зохион байгуулах, олон нийтэд зориулсан мэдээлэл, сурталчилгааны ажлыг өргөн хүрээнд хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Согтуурах, мансуурах донтой өвчтөнийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын харуул хамгаалалт эрхэлсэн дэд дарга, хошууч Д.Хатанзориг “Согтуурах, мансуурах донтой хүнийг албадан эмчлэх ажиллагаанд тулгамдсан асуудал” илтгэлдээ согтууруулах ундаа, мансууруулах бодист донтох эмгэг, түүний түүхэн хөгжил, тухайн эмгэгтэй тэмцэх талаар Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын түүхэн уламжлал, “Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмлэх тухай хууль”-д дүн шинжилгээ хийж, донтох эмгэгийн нийгмийн аюулыг судалж, тулгамдсан асуудлыг тодорхойлж шийдвэрлэх талаар авч үзсэн байна.

Уг судалгааны үр дүнд согтуурах дон нь Өвчний Олон Улсын 10 дугаар ангилалд сэтгэцийн болон зан үйлийн эмгэг өвчинд хамаарагддаг тул зөвхөн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхээс гадна тухайн хүний сэтгэл зүй, зан үйлийг засах цогц эмчилгээ зайлшгүй шаардлагатай. Монгол Улсад архинд донтох эмгэгтэй хүмүүст үзүүлж буй сэтгэл зүйн тусламж үйлчилгээг зохицуулах тусгай заавар, эрх зүйн зохицуулалт хангалтгүй, эмчилгээний арга барил нь хуучин социалист тогтолцооны хорих маягийн арга зүйгээс бүрэн салж чадаагүй байгаа нь эмчилгээний үр дүнд сөргөөр нөлөөлж байна. Харин олон улсын туршлагаас харахад донтогчийг хорихоос илүүтэйгээр хүний эрхийг дээдэлсэн, гэр бүл, орон нутаг, хамт олны оролцоонд суурилсан нийгэмшүүлэх, дэмжих хөтөлбөрүүд илүү үр дүнтэй болох нь батлагдсан. Иймд Монгол Улсад донтогчдын эмчилгээ, нийгэмшүүлэх бодлогыг хүний эрхэд суурилсан, олон улсын тэргүүн туршлагад нийцүүлэн шинэчлэх шаардлагатай гэсэн дүгнэлт хийжээ.

Архинд донтох эмгэгтэй тэмцэхийн тулд нийгэм, хамт олонд суурилсан урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухаанд суурилсан хөтөлбөрөөр хэрэгжүүлэх, архи, согтууруулах ундааны талаарх буруу ойлголтыг арилгаж, олон нийтэд зөв мэдээлэл түгээх соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх нь чухал. Мөн архинд донтох эмгэгийн албадан болон сайн дурын эмчилгээний байгууллагуудыг нэгдсэн бодлогоор зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, эмчилгээний чанарыг жигд түвшинд хүргэх шаардлагатай. Үүнээс гадна санхүүжилтийг эдийн засгийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх, архинд донтогчдын эдгэрэлтийг дэмжихийн тулд гэр бүл, хамт олны оролцоог нэмэгдүүлэх, ажлын байрны хөтөлбөр хэрэгжүүлж нийгэм, эдийн засгийн баталгааг хангах бодлогыг хэрэгжүүлэх нь зүйтэй. Ийм цогц арга хэмжээ нь архинд донтогчдыг эдгэрүүлээд зогсохгүй нийгэмд эерэг хандлага бий болгож, урьдчилан сэргийлэх ажлыг өргөн хүрээнд хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх арга зүйн тэнхимийн профессор, доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн хурандаа Б.Эрдэнэбат, Шүүх шинжилгээний ерөнхий газрын Шүүх анагаах ухааны шинжилгээний хэлтсийн шинжээч Э.Мөнхнаран, Б.Отгонжаргал, Н.Туяа, Ч.Моломжамц, З.Хишигсүрэн “Мансууруулах, сэтгэц нөлөөт бодистой тэмцэхэд тулгамдсан асуудал” илтгэлдээ СЭМҮТ-д хэвтэн эмчлүүлж байгаа 336 донтогчийн байдалд дүн шинжилгээ хийх, МҮИС, ИЗ, ШУТИС, КУДС, МУБИС зэрэг 5 их сургуулийн 300 гаруй оюутнаас мансууруулах, сэтгэц нөлөөт бодисын талаарх мэдлэгийг үнэлэх судалгаа авч, мансууруулах, сэтгэц нөлөөт бодисын хэрэглээ, өртөлтийн байдлыг тодорхойлж, дүгнэлт хийн, урьдчилан сэргийлэх талаар судалсан байна.

Уг судалгааны үр дүнд Монгол Улсад мансууруулах болон сэтгэц нөлөөт бодисын хууль бус хэрэглээ, эргэлт эрчимтэй нэмэгдэж, үүнээс шалтгаалсан донтолт, нас баралт өндөр түвшинд хүрч байна. Судалгаагаар их дээд сургуулийн оюутнуудын 39.6% нь ийм төрлийн бодис хэрэглэж үзсэн бөгөөд ихэнх нь нийгмийн дунджаас дээш орлоготой өрхөд харьяалагдаж байна. Мөн донтолттой иргэдийн олонх нь өвчний олон улсын ангиллаар F19 буюу олон төрлийн бодис хослуулсан донтолтын оноштой байгаа нь асуудлын цар хүрээ, эрсдэлийг

харуулж байна. Энэ төрлийн гэмт хэрэгт МЕТ (метамфетамин) болон ТНС (тетрагидроканнабинол) түгээмэл хэрэглэгдэж байгаа нь тэдгээрийн хурдан хугацаанд донтуулдаг, хамаарал үүсгэдэг онцлогтой холбоотой бөгөөд нийгмийн эрүүл мэндэд ноцтой аюул учруулж байна гэсэн дүгнэлт хийжээ.

Мансууруулах бодисын хэрэглээ, донтолттой тэмцэхийн тулд шинжилгээний арга, ангиллыг боловсронгуй болгож, МЕТ болон ТНС төрлийн бодисын хэрэглээний онцлогт тохирсон эмчилгээний арга зүйг нэвтрүүлэх шаардлагатай. Их, дээд сургуулиудын оюутан, залуусын дунд урьдчилан сэргийлэх арга хэмжээ, сургалт сурталчилгааг идэвхжүүлж, хууль зүйн зохицуулалт, эмнэл зүйн эмчилгээ болон нийгмийн арга хэмжээг уялдуулсан цогц бодлого хэрэгжүүлэх нь чухал. Үүний тулд хууль зүй, анагаах ухаан, нийгмийн шинжлэх ухааны судлаачдын хамтарсан баг байгуулж, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого, аргачлалыг боловсруулан хэрэгжүүлэхийг санал болгосон байна.

Цагдаагийн ерөнхий газрын Стратеги, бодлого, инновац, хөгжлийн албаны Цагдаа, дотоодын цэргийн судалгааны төвийн дарга, доктор (Ph.D), цагдаагийн хошууч А.Манлай “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн нөхцөл байдал, нөлөөлж буй хүчин зүйлс” илтгэлдээ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын Хойд Америк, БНХАУ, ОХУ, ИБНВУ-ын нөхцөл байдал, тухайн төрлийн бодисын хэрэглээ, Зүүн өмнөд Ази, Европын холбооны орнуудаас Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж байгаа нөхцөл байдал, энэ төрлийн гэмт хэрэгт холбогдогсод, тухайн төрлийн бодисын гадаадын болон Монгол Улсын зах зээл дэх үнэлгээ, Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын эрүүгийн эрх зүйн зохицуулалт, 2001-2023 онд ял шийтгүүлсэн этгээдүүдийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, тулгамдсан асуудлыг тодорхойлсон байна.

Уг судалгааны үр дүнд хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эрүүл мэнд, нийгмийн идэвхийг дэмжих спортын арга хэмжээ нь мансуурах, согтуурах явдлыг урьдчилан сэргийлэхэд хувь нэмэр оруулдаг ч дангаараа хангалтгүй бөгөөд цугларалт, шоу арга хэмжээний үеэр архи, тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус хэрэглээ үргэлж оршсоор байна. Сүүлийн жилүүдэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг жил бүр 25.8–51.5 хувиар өсөж, холбогдогчдын тоо нэмэгдэж, нас залуужиж байгаа нь нийгэм, үндэсний аюулгүй байдалд ноцтой эрсдэл учруулж байна. Түүнчлэн хөрш орнуудад энэ төрлийн гэмт хэрэг үндэстэн дамнасан зохион байгуулалттай болж, хууль сахиулах байгууллагаас тооны арван тонн мансууруулах бодис хурааж байгаа нь Монгол Улсын иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөөлөх эрсдэлийг нэмэгдүүлж байна гэсэн дүгнэлт хийжээ.

Монгол Улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхийн тулд дэлхийн улс орнуудын сайн туршлага, хууль бус эргэлттэй тэмцэх арга барил, дэвшилтэт техник, хэрэгслийг судалж, нэвтрүүлэх шаардлагатай. Мөн спорт, урлаг, нийгмийн арга хэмжээ, чөлөөт цагийн цогц хөтөлбөрийг хүүхэд, залуучуудын дунд өргөн хүрээнд зохион байгуулж, хууль сахиулах байгууллагуудтай хамтран хяналт, мэдээллийн

механизмыг сайжруулан гэмт хэргийн гаралтыг бууруулах бодлого хэрэгжүүлэх нь чухал гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн профессор, доктор (Ph.D), цагдаагийн хурандаа Н.Бадраа “Өсвөр насныхныг хар тамхи, мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх нь: эрсдэлт хүчин зүйл ба үр нөлөөтэй арга, хэлбэрүүд” илтгэлдээ мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Олон улсын гэрээ, баримт бичгүүд, эрх зүйн зохицуулалтын байдал, 2022-2025 онд үйлдэгдсэн энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдлыг судалж, өсвөр насныхны дунд хэрэглээг тодорхойлж, урьдчилан сэргийлэх талаар боловсрол, гэр бүл, хамтын ажиллагааны хүрээнд, хэрэгжүүлэх бодлогын чиглэл, үр дүнтэй арга замуудыг судалсан байна.

Уг судалгааны үр дүнд өсвөр насныхныг хар тамхи, мансууруулах бодисын аюулд өртөхөөс урьдчилан сэргийлэх нь зөвхөн нэг байгууллагын үүрэг бус, гэр бүл, сургууль, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг шаардсан цогц асуудал юм. Орчин үеийн нийгэмд мансууруулах бодисын хэрэглээ нэмэгдэж байгаа нь залуучуудын эрүүл мэнд, амьдралын чанарт сөргөөр нөлөөлж, улс орны ирээдүйд гүн гүнзгий сөрөг үр дагаврыг авчирч буй тул урт хугацааны тогтвортой бодлого, боловсрол, олон нийтийн оролцоог хослуулсан нэгдмэл арга барил хэрэгжүүлэх нь чухал гэсэн дүгнэлт хийжээ.

Өсвөр насныхныг мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэхийн тулд сургуулийн боловсролыг чангатгаж, хор уршиг, эрсдэлийн талаар тогтмол хичээл, сургалт явуулах; гэр бүлийн оролцоог нэмэгдүүлж эцэг эхийн хяналт, сэтгэлзүйн дэмжлэгийг сайжруулах; олон нийтийн мэдлэг, ойлголтыг сурталчилгаагаар нэмэгдүүлэх; төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, үүрэг хариуцлагыг тодорхой болгох; психологийн дэмжлэг, зөвлөгөө, эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх; мөн Исланд болон бусад орны туршлагыг судлан хэрэгжүүлэх зэрэг цогц арга хэмжээг авах шаардлагатай. Энэ нь зөвхөн урьдчилан сэргийлэх ажил төдийгүй, мансууруулах бодисын хэрэглээтэй тэмцэх стратегийн нэг хэсэг болно гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор Г.Янжиндулам “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэхэд хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудал” илтгэлдээ мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Олон улсын гэрээ, үндэсний эрх зүйн зохицуулалт, Монгол Улсад 2023-2024 онд үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал, бодит хэргийн үйл баримтыг судалж, Нидерландын Хаант Улс, Сингапур Улс, Малайз Улсын ялын бодлогод дүн шинжилгээ хийж, ялгамж, зааг ялгааг тодорхойлсон байна.

Уг судалгааны үр дүнд Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.7-20.10 дугаар зүйлүүдэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийг хуульчилсан ч, “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис” гэх ерөнхий тодорхойлолт нь гэмт хэргийн шинжийг ялгаж үнэлэхэд хүндрэл үүсгэж, шүүгдэгчдийн эрх зүйн байдлыг дордуулах эрсдэлтэй байна. НҮБ-ын конвенцын жагсаалтад багтсан бодисууд нь эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, донтох

чадвар, нийгэмд учруулах хор уршгийн хувьд ялгаатай тул одоогийн хууль нь тухайн үйлдсэн гэмт хэргийн аюул, хор уршигт тохирсон ял шийтгэлийг оногдуулах боломжийг бүрэн хангахгүй байна гэсэн дүгнэлт хийжээ.

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргүүдийг НҮБ-ын 1961 болон 1971 оны конвенцын жагсаалтын зарчимд нийцүүлэн, бодисын шинж чанар, хор уршиг, донтолт үүсгэх чадвар зэргээр ангилан ялгамжтай эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалт хийх нь шударга ёсны зарчимд нийцсэн, илүү үр дүнтэй арга болно гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D), цагдаагийн хошууч О.Отгонтуяа “Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжид мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийг тодорхойлж байсан түүхэн уламжлал” илтгэлдээ энэ төрлийн бодистой холбоотой эрх зүйн зохицуулалт, тэр дундаа эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг Манж Чин Улсын эрхшээлд байсан үе, шинэ үе (1926-1992), 1992 оноос одоог хүртэл үе гэсэн 3 үечлэлээр Богд хаант Улсын засгийн газрын зарлигаар тогтоосон бичиг, Шүүх цаазын бичиг, Эрүүгийн хууль, судалж, оногдуулж байсан ял шийтгэлийг харьцуулсан байна.

Уг судалгааны үр дүнд Монгол Улсад мансууруулах бодисын эсрэг эрх зүйн зохицуулалт нь Манж Чин Улсын үед анх хэрэгжиж эхэлснээс хойш үе шаттайгаар боловсорч, 1929 оны Шүүх цаазын бичгээс эхлэн хилээр хууль бусаар хар тамхи нэвтрүүлэх, бэлтгэх, худалдах гэмт хэргийг нарийвчлан зааж ирсэн түүхтэй бөгөөд 1961 онд хилээр хорт бодис нэвтрүүлэхтэй холбоотой гэмт хэргийг бие даасан зүйл анги болгон хуульчилсан ч 1986 онд уг зохицуулалтыг өөрчилж, бие даасан зүйл анги болгосонгүй. 1993, 2002 оны Эрүүгийн хуулиудаар энэ төрлийн гэмт хэргийг бие даасан бүрэлдэхүүнтэйгээр, онцлог шинжийг харгалзан хуульчилсан нь эрх зүйн зохицуулалтын хөгжлийн үр дүн гэсэн дүгнэлт хийжээ.

Мансууруулах бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хүүхэд, насанд хүрэгчдийн сэтгэл зүйн онцлог, хүний эрх, иргэний эрх, улс орны болон хувь хүний үнэт зүйлсэд тулгуурласан шинэлэг аргыг нэвтрүүлж, нийгмийн аюулыг зөв ойлгуулах, хүүхэлдэй кино зэрэг сургалтын болон урьдчилан сэргийлэх бүтээлээр олон нийтэд таниулах арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Нийслэлийн прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих II хэлтсийн хяналтын прокурор Г.Билгүүн “Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.3 дахь заалтад заасан “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийг монгол улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн практик” илтгэлдээ Мансууруулах бодисыг хилээр нэвтрүүлсэн гэмт хэрэгт шүүхийн шийдвэрлэх практик, нотлох баримтын үнэлгээ, мөрдөн шалгах ажиллагааны чанарыг анхан шатны шүүхээс Э2020-2024 онд үйлдэгдсэн 38 хүнд холбогдох Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.3 дахь заалтад зааснаар зүйлчлэн яллах дүгнэлт үйлдсэн 22 хэргийг судалж, нэвтрүүлсэн мансууруулах бодис, хил нэвтрүүлсэн үйлдлийн

арга, оногдуулсан ял шийтгэл, хөнгөрүүлсэн зүйлчилсэн болон цагаатгасан байдалд дүн шинжилгээ хийж, тухайн төрлийн гэмт хэргийг шийдвэрлэх шүүхийн практик, нотлох баримтын үнэлгээ, мөрдөн шалгах ажиллагааны чанарыг судалж, АНУ, БНТУ, ХБНГУ, Сингапур, Малайз, БНХАУ-ын эрүүгийн хуулийн ял шийтгэлийн байдалтай харьцуулан судалжээ.

Уг судалгааны үр дүнд Монгол Улсын шүүх практикт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэргийг шийдвэрлэхэд мөрдөн шалгах ажиллагаа болон нотлох баримтын цуглуулалт, бодисын төрөл, агууламж, хэрэглээний нөхцөл байдлыг тодорхой тогтоох асуудал хангалтгүй байснаас шалтгаалан хэргийн зүйлчлэл хөнгөрч, зарим тохиолдолд шүүгдэгчийг цагаатгах, ялын хэмжээ бага тогтоогдох зэрэг зөрчил гарч байна. Мөн олон улсын шуудан, хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бодисын эх сурвалж, хил дамнасан хэрэгцээ, хор хөнөөл, сэтгэцэд үзүүлэх нөлөөллийг нарийвчлан тогтоох шаардлага бий бөгөөд энэ нь гэмт хэргийн нийгмийн аюулын үнэлгээ, эрүүгийн хариуцлагын зорилтыг хангах гол нөхцөл болдог гэсэн дүгнэлт хийжээ.

Мөрдөн шалгах ажиллагааг явуулахдаа сэжигтний эрх, мэдүүлэг авах журмыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хангаж, дуудсний бичлэгээр баталгаажуулах; мансууруулах бодисын агууламж, нэгж тун, хэрэглээний давтамж, “хар зах зээл дээрх” үнийг тогтоох; хилээр нэвтрүүлсэн бодисын эх сурвалжтай орнуудтай эрх зүйн харилцан туслалцааны гэрээ байгуулж хамтын ажиллагааг өргөжүүлэх; олон улсын шуудангийн эрсдэлийг үнэлэх хяналт, орчин үеийн технологийг ашиглах замаар нотлох баримтыг бүрэн цуглуулж, шүүхэд тэнцвэртэй, шударга ёсны зарчимд нийцсэн эрүүгийн хариуцлагын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн дэд профессор, доктор (Ph.D), цагдаагийн ахмад И.Ургамал “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээнээс урьдчилан сэргийлэх хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагааны swot-tows шинжилгээ” илтгэлдээ мансууруулах бодистой тэмцэх чиглэлээр ажилладаг хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал, давуу болон сул талуудыг тодорхойлон, чанарын SWOT-TOWS шинжилгээ хийж, байгууллагуудын дотоод нөөц бололцоо болон гадаад орчны хүчин зүйлсийг тодорхойлж, урьдчилан сэргийлэхэд төвлөрсөн, олон нийтийн оролцоонд суурилсан стратегийг боловсруулах талаар судалжээ.

Уг судалгааны үр дүнд Мансууруулах бодисын хэрэглээ болон хууль бус эргэлт нь зөвхөн хувь хүний эрүүл мэндэд төдийгүй нийгмийн тогтвортой байдал, үндэсний аюулгүй байдалд заналхийлж буй тул дэлхий нийтээр анхаарал хандуулж, хамтын хүчээр тэмцэх шаардлагатай асуудал болсоор байна. Монгол Улсын хувьд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд хууль сахиулах байгууллагууд болох Цагдаагийн Ерөнхий газар, Гаалийн Ерөнхий газар, Тагнуулын Ерөнхий газар зэрэг олон байгууллага хамтран ажиллаж байгаа нь эерэг жишээ боловч уялдаа холбоо, мэдээлэл солилцоо, мэргэшсэн хүний нөөцийн асуудал байсаар байна гэсэн дүгнэлт хийжээ.

Хамтын ажиллагааг улам бүр сайжруулахын тулд технологийн шинэчлэл, гадаадын туршлагаас суралцах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх боловсролын ажлыг тогтвортой зохион байгуулах шаардлагатай байна. Мөн байгууллагуудын чиг үүргийн давхардлыг арилгаж, мэдээлэл солилцооны нэгдсэн платформ бий болгох, хамтарсан сургалт, чадавхыг нэмэгдүүлэх нь хамтын ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх үндэс болно гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D), хошууч Т.Азжаргал, багш, цагдаагийн ахлах дэслэгч Б.Батбаяр “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх арга, аргачлал: бодлогод нөлөөлөх хүчин зүйл” илтгэлдээ Монгол Улс нэгдэн орсон НҮБ-аас Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц (1961), Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц (1988), Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц (2001), түүний хэм хэмжээ, түүгээр тусгасан бодис манай улсад орж ирээд эргэлтэд ороход хариуцлага оногдуулах, эрүүгийн хууль хэрэглээний нэгдмэл тогтолцоог Үндсэн хуулийн хүрээнд (АНУ, Франц, Португали, Герман, Англи, Норвег, Дани, Польш, Швейцар, Бельги улстай харьцуулан, үнэлгээ хийж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлогыг "Нийгэм-Эрүүл мэнд-Хууль сахиулах" гэсэн гурвалзсан системийн цогцолбор байдлаар судалжээ.

Уг судалгааны үр дүнд мансууруулах эмийн хууль бус эргэлттэй тэмцэхэд олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаа, технологийн дэвшил, бодлогын уялдаа чухал үүрэгтэй бөгөөд Монгол Улс энэ чиглэлд олон улсын түншлэлээ бэхжүүлж, илүү үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, “AI” болон “big data” технологийг ашиглан наркотик наймааны урсгалыг шинжлэх, хил орчмын бүсэд дрон, AI дэмжлэгтэй хяналтын систем нэвтрүүлэх, криптовалютын гүйлгээг хянах зэрэг арга замыг хэрэгжүүлэх боломжтой гэсэн дүгнэлт хийжээ.

Монгол Улс UNODC-тай хамтран тогтмол сургалт, мэдээллийн солилцоо явуулах, гадаад улсын хууль сахиулах байгууллагуудтай хамтран туршлага солилцох, практик алба хаагчдыг тогтмол мэдээллээр хангах; хилийн бүс, шуудангийн тээвэрт хяналтыг сайжруулах, байгууллага бүрд эрсдэлийн удирдлагын системийг хэрэгжүүлэх замаар мансууруулах бодисын хууль бус эргэлтийг илрүүлэх, таслан зогсоох үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Нийслэлийн прокурорын газрын Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор, хууль цаазын ахлах зөвлөх Н.Алтантүлхүүр “Тебантин (габапентин) эмийн хууль бус эргэлттэй холбоотой зөрчлийг шалган шийдвэрлэхэд тулгамдсан асуудал” илтгэлдээ уналт, таталтын эмчилгээ болон мэдрэлийн гаралтай өвдөлт намдаах зорилгоор хэрэглэгддэг Табентин (габапентин) эмийн Герман Франц, Итали, Испани, Япон, Энэтхэг, АНУ, Их Британи, Канад, Австрали, Сингапур, Малайз, Хонгконг зэрэг гадаад орны эрх зүйн зохицуулалт, Монгол Улсад үйлдэгдсэн эмийн хууль бус

эргэлттэй холбоотой зөрчлийн гаралт, шийдвэрлэлт, шалтгаан нөхцөл, зөрчил шалган шийдвэрлэхэд тулгарч буй асуудлыг судалсан байна.

Уг судалгааны үр дүнд өсвөр насны хүүхэд, залуучуудыг эмийн хууль бус хэрэглээ, тэр дундаа табентин (габапентин) зэрэг сэтгэцэд нөлөөт эмээс хамгаалах нь нийгмийн эрүүл мэнд, боловсрол, гэр бүл, эдийн засагт эерэг нөлөөтэй бөгөөд хүний амьдралын буруу хэвшил, зан үйлийн 55-60%-ийг үүнтэй холбон тайлбарлаж болно. Энэ хүрээнд хүний эрх, эрх чөлөөг хангах хууль эрх зүйн баталгааг боловсронгуй болгох, дижитал нотолгоо, цахим систем, технологийн дэвшлийг ашиглан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг үр дүнтэй явуулах, табентин эмийн хууль бус эргэлтэд тавих хяналт, төрийн байгууллагуудын хяналт шалгалт, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, эмийн хууль бус хэрэглээ, эргэлтээс үүдэн гарах үр дагаврыг үнэн зөв тодорхойлох нь чухал гэсэн дүгнэлт хийжээ.

Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль тогтоомжийн нэр томъёоллыг ойлгомжтой болгох, эмийн жагсаалтыг шинэчлэн батлах; зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд цахим систем, хиймэл оюун ухааныг нэвтрүүлэх, хавтаст хэргийг цахимжуулах, нотлох баримтыг цуглуулж үнэлэх журмыг боловсронгуй болгох; дахин давтан зөрчил үйлдэгчдийг эрүүл мэнд, шүүхийн хяналтын дор албадан эмчлэх, өсвөр насны хүүхэд, залуучуудыг сошиал орчинд хяналттай болгох, эцэг эхчүүдийн мэдлэгийг дээшлүүлэх, салбар хоорондын уялдаа холбоог нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Аюулгүй байдал судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан-багш, цагдаагийн хошууч В.Номинчулуун “Монгол Улсын нутаг дэвсгэрт сүүлийн 3 жилд бүртгэгдсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ” илтгэлдээ 2022–2024 оны хооронд Монгол Улсад бүртгэгдсэн мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргүүдийн нөхцөл байдал, гэмт хэрэгт холбогдогсдын байдалд дэлгэрэнгүй судалгаа хийж, хууль бус эргэлтийн зураглал, шалтгаан нөхцөлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэхэд тулгамдсан асуудлыг судалжээ.

Уг судалгааны үр дүнд монгол Улсад мансууруулах сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэхэд хууль эрх зүйн орчин, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, мэргэжлийн бэлтгэл, эмчилгээний стандарт дутагдалтай байна. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн ихэнх нь каннабисын төрлийн ургамалтай холбоотой бөгөөд тархац, устгалын тогтмол арга хэмжээ шаардлагатай. Мөн гэмт хэрэгт холбогдож буй иргэдийг урьдчилан сэргийлэх, донтох эрсдэлийг бууруулах ухуулга, сургалт хангалтгүй, алба хаагчдын мэдлэг, аргачлал дутмаг, эмчилгээний стандарт, мэргэшсэн эмч, төв дутагдалтай байна. Үүний улмаас мансууруулах бодисын хэрэглэгчид, донтогчид гэмт бүлэглэлийн гишүүн болох эрсдэл нэмэгдэж, нөхцөл байдлыг бүрэн хяналтдаа оруулах боломж хязгаарлагдмал байна гэсэн дүгнэлт хийжээ.

Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хүрээнд: эм, бэлдмэл худалдах, үйлчлэх зөвшөөрөлтэй газруудын эргэлт, худалдан авалтад мэргэжлийн хяналтыг чангатгах; ургамлын тархац, төрөл, газрын зураглал гаргаж, байнгын устгалын ажлыг тогтмолжуулах; донтой хүнд олон талт эмчилгээний боломжийг бүрдүүлэх; 15-35 насны залуучуудад хяналт, эрх зүйн боловсрол олгох; зохион байгуулалттай, улс дамнасан гэмт хэргийн мөрдөн шалгах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, мэргэжилтэн бэлтгэх, олон улсын жишиг, туршлагыг нэвтрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын Эрүүгийн цагдаагийн хэлтсийн гуравдугаар тасгийн эрүүгийн мөрдөгч, цагдаагийн дэслэгч Б.Батцэцэг “Мансуурах зорилгоор урвуулан хэрэглэж байгаа эмийн нөхцөл байдал, чиг хандлага” илтгэлдээ эпилепси өвчинд хэрэглэгддэг Тебантин эм, түүний эмнэл зүйн заавар, эргэлт, 2022-2024 онд мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмтэй холбоотой зөрчил, тус эмийн хууль бус эргэлт, түүнээс учирсан хохирлыг Морфин, Кодеин, Фентанил, Трамадол, Диазепам, Алпрозолам, , Вүүдс, Лидокайн эмтэй харьцуулан, энэ төрлийн эмийн хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх талаар судалсан байна.

Уг судалгааны үр дүнд Монгол Улсад эмийн бүртгэлд ороогүй Тебантин эмийг хууль бусаар олж авах, худалдан борлуулах гэмт хэрэг нэмэгдэж, үүний улмаас залуус эрүүл мэнд, амь насаараа хохирох, донтох, мансуурсан үедээ бусад гэмт хэрэг үйлдэх эрсдэл нэмэгдэж байна. Эмийг ашиг олох зорилгоор худалдаалах гэмт хэрэг боомттой аймгуудын гаалийн болон цагдаагийн байгууллагын хяналтад орж байгаа ч судалгааны хязгаарлагдмал байдлаас болж эмийн шалтгаант нас баралтыг бодитоор бүртгэх боломж хязгаарлагдмал байна. Мөн эрүүл мэндийн байгууллагад гарсан гэмтэл, хөл, мөчөө тайруулсан иргэдийн мэдээллийг бүртгэн, ямар эмнэлэг, эмийн сангаас эмийг худалдан авсан болохыг тодруулах шаардлага байгааг судалгааны үр дүн харуулж байна гэсэн дүгнэлт хийжээ.

Боомттой аймгуудын гаалийн болон цагдаагийн алба хаагчдад Тебантин эмийн хууль бус эргэлттэй холбоотой зөвлөмжийг хүргэх; эмийн худалдан борлуулах гэмт хэрэг, залуусын урвуулан хэрэглээг хянах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулах; эмийн шалтгаант нас баралтын бодит мэдээллийг цуглуулах, эрүүл мэндийн байгууллага, эмийн сангийн мэдээлэлд үндэслэн хяналт тавих; донтох, мансуурах, бусад гэмт хэрэгт өртөх эрсдэлийг бууруулах чиглэлд арга хэмжээ авах гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн тэнхимийн дэд профессор, дэд хурандаа Г.Хосбаяр “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис - эрх зүйн орчин, чиг хандлага” илтгэлдээ НҮБ-ын “Мансууруулах эмийн тухай 1961 оны конвенц”, “Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай 1971 оны конвенц”, “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг 1988 оны конвенц”, “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг 2000 оны конвенц”, түүнтэй уядуулсан үндэсний хууль тогтоомжид, тэр дундаа эрүүгийн хуульд заасан ял шийтгэлийн байдлыг судалж, 2023, 2024 онд энэ төрлийн гэмт

хэрэгт ял шийтгүүлэгчийн байдалд дүн шинжилгээ хийж, энэ төрлийн гэмт хэрэгт л шийтгүүлэгчид ял эдлүүлэхэд тулгамдсан асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх талаар судлаачийн байр суурийг илэрхийлсэн байна.

Уг судалгааны үр дүнд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх нь шинжлэх ухааны судалгаа, мэргэжлийн байгууллагуудын чадавх, олон нийтийн идэвхтэй оролцоо, хууль эрх зүйн тогтолцоонд суурилдаг. Олон улсад ахиц гарч байгаа хэдий ч хар тамхи, сэтгэцэд нөлөөт бодисын хууль эрх зүйн орчин нарийн төвөгтэй хэвээр байгааг судалгааны үндсэн дээр тогтоосон бөгөөд цаашид шинээр үүсэж буй бодисууд, эмчилгээний чадавх, донтолттой тэмцэх нотолгоонд суурилсан арга барилыг нэвтрүүлэх шаардлагатай байна. Энэ нь мансууруулах бодисын хэрэглээ болон сэтгэцийн эмгэгээс үүдэлтэй сорилтуудыг шийдвэрлэхэд оролцогч талуудын хамтын ажиллагаа, нийгмийн эрүүл мэнд, хүний эрхийн зарчмыг эрэмбэлсэн цогц арга барилыг чухал болохыг харуулж байна гэсэн дүгнэлт хийжээ.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, хэрэглээнээс урьдчилан сэргийлэхэд зориулан дараах зохицуулалт, практикийг бий болгохыг санал болгож байна: шинэ сэтгэцэд нөлөөт бодис (NPS) болон синтетик мансууруулах бодисын тархалтыг хязгаарлах, тэдгээрийн эргэлт, хэрэглээнд үндэсний хяналт тогтоох; “Darknet” хууль бус зах зээл, онлайн эмийн борлуулалтын платформ болон криптовалютын гүйлгээнд хяналт тавих олон улсын хамтын ажиллагаа, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх; мөн нийгмийн эрүүл мэнд, хор хөнөөлийг бууруулах нотолгоонд суурилсан эмчилгээний стратегийг хэрэгжүүлснээр хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодистой тэмцэх илүү үр дүнтэй, тогтвортой цогц арга барилыг бий болгох боломжтой гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Хууль сахиулахуйн боловсрол судлалын төвийн эрхлэгч, цагдаагийн хурандаа Б.Ариунзаяа “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой тэмцэх эрх зүйн орчин, анхаарах асуудал” илтгэлдээ НҮБ-ын Мансууруулах эмийн тухай 1961 оны нэгдсэн конвенц, Сэтгэцэд нөлөөт бодисын тухай 1971 оны конвенцуудад дүн шинжилгээ хийж, энэ төрлийн гэмт хэргийн эрх зүйн орчныг түүхэн хөгжил талаас нь судалж, энэ төрлийн гэмт хэргийн гадаад нөхцөл байдал манай улсад нэвтрүүлж буй зам, маршрут шалтгаан нөхцөл судалсан байна.

Уг судалгааны үр дүнд хар тамхи нь хувь хүний эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн тогтвортой байдал, эдийн засаг, эрүүгийн эрх зүйг хамарсан цогц асуудал бөгөөд хууль ёсны болон хууль бус бодисыг буруугаар ашиглах нь гэр бүл, санхүү, эрүүл мэнд, нийгмийн харилцаанд гүн гүнзгий сөрөг үр дагавар авчирдаг. Хүмүүсийн хэрэглээний шалтгаан олон янз байдаг ч урт хугацааны хараат байдал, хор хөнөөлийн эрсдэл бодитой бөгөөд энэ нь гэмт хэрэг, хөдөлмөрийн бүтээмж буурах, нийгмийн тусгаарлалт үүсэх зэрэг үр дагаварт хүргэдэг. Мансууруулах бодисын асуудлыг шийдвэрлэхэд олон талт арга барил шаардлагатай ба боловсрол, урьдчилан сэргийлэлтийн мэдээлэл, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, донтолтоос ангижрах эмчилгээ, олон нийтийн дэмжлэгийг хослуулах нь хар тамхины сөрөг нөлөөллийг бууруулах, иргэдийг

эрүүл, мэдээлэлтэй болгож, нийгмийн дэмжлэгтэй, үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэх үндэс болдог гэсэн дүгнэлт хийжээ.

Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн Зөрчлийн хэрэг бүртгэх тасгийн байцаагч, цагдаагийн дэслэгч Ц.Гантулга “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн хууль бус эргэлттэй холбоотой зөрчлийн өнөөгийн нөхцөл байдал, чиг хандлага” илтгэлдээ Табентин” эм, “Ахуйн хэрэглээний газ”, "Растровитель" зэргийг хэрэглэж мансуурах, мансуурсан зөрчил, түүний үйлдлийн арга, тухайн зөрчлийн шалтгаан, нөхцөл, энэ төрлийн зөрчлийг шалган шийдвэрлэхэд тулгамдсан асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг судалсан байна.

Уг судалгааны үр дүнд “Тебантин” болон ахуйн зарим бодисуудыг буруу ашигласнаас үүдэж бага насны болон өсвөр насны хүүхдүүд эрүүл мэнд, сэтгэл санааны эрсдэлд өртөж, дахин зөрчилд холбогдох нөхцөл бүрдэж байгаа нь судалгаагаар нотлогдож байна. Эдгээр бодисууд нь НҮБ-ын 1961, 1971, 1988 оны конвенцод багтдаггүй тул холбогдох хүмүүст хариуцлага хүлээлгэх хууль эрх зүйн боломж хязгаарлагдмал байна. Мөн одоогийн Зөрчлийн тухай хуулийн шийтгэл хөнгөн тул дахин зөрчил гарах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Ахуйн хэрэглээний бодисын худалдаа, хэрэглээг зохицуулах журам дутмаг, насанд хүрээгүй хүүхдүүдэд олгож байгаа нөхцөл нь энэ төрлийн зөрчлийг давтан үйлдэх шалтгаан болж байгаа тул ил тод хяналт, зөвшөөрөлтэй худалдан борлуулах стандартыг баталж, хилээр оруулах, борлуулах хязгаарлалт тогтоох зэрэг арга хэмжээг авах шаардлагатай гэсэн дүгнэлт хийжээ.

Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчилд 2 болон түүнээс дээш удаа холбогдсон тохиолдлыг гэмт хэрэгт тооцож, холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах; “Тебантин”-ийн хилээр оруулж ирсэн түүх, хэрэглэгч, аж ахуйн нэгж, зориулалтын мэдээллийг бүртгэх, хувь хүн зориулалтын бусаар оруулж ирэхийг хориглох; ахуйн хэрэглээний бодисын худалдаа, үйлчилгээний стандартыг баталж, зөвшөөрөлтэйгөөр 18 наснаас дээш хүнд худалдах зохицуулалт бий болгож, насанд хүрээгүй хүүхдийн зөрчилд холбогдох эрсдэлийг бууруулна гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, цагдаагийн хошууч Д.Энх-амгалан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг шалган шийдвэрлэхэд хамтран ажиллах этгээдийг ашиглах нь” илтгэлдээ Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Олон улсын эрх зүйн зохицуулалт, ЭХХШТХ-ийн 13.3-13.7 дугаар зүйлд заасан “Хамтран ажиллах этгээд”-ийн зохицуулалтын эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийсэн байна.

Уг судалгааны үр дүнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээнд холбогдсон этгээдийг илрүүлэх, нотлох баримтыг цуглуулан бэхжүүлэх, шударгаар ял оногдуулах үйл ажиллагаанд мөрдөн шалгах ажиллагааны дэмжлэг, хамтран ажиллах этгээдийн тогтоох эрх зүйн зохицуулалт хэрэгжиж, энэ төрлийн гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх боломж бүрдсэн гэсэн дүгнэлт хийжээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.3–13.7 дугаар зүйлийн агуулга, хэрэглээний талаар шүүгч, прокурор, мөрдөгчдийг сургах; Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах” гэмт хэргийг шалгах явцад хамтран ажиллах этгээдээр оролцуулах хэрэглээг нэмэгдүүлэх; цагдаагийн мөрдөгчдийн мэдүүлэг авах маягт, бичиг баримтад дээрх хуулийн зүйл, заалтыг тайлбарласан бичвэрийг нэмэн мөрдлөг, нотолгооны ажиллагааг сайжруулахыг санал болгосон байна.

Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, цагдаагийн дэслэгч М.Баярцэцэг “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал, тулгамдсан асуудал” илтгэлдээ 2017 оноос хойш үйлдэгдсэн энэ төрлийн гэмт хэргийн гаралт, улсын хилээр нэвтрүүлж, худалдан борлуулах аргууд, илэрсэн гэмт хэргийн нөхцөл байдал, хураан авсан бодис, гэмт хэргийг үйлдэгсдийн байдалд дүн шинжилгээ хийсэн байна.

Уг судалгааны үр дүнд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэхийн тулд дээрх судалгаанаас дүгнэвэл гэмт хэрэг, зөрчлийн гаралт буурахгүй, жил ирэх тутам өсөж байгаа тул энэ төрлийн гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах шаардлагатай гэж дүгнэжээ. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.7- 20.10-т заасан гэмт хэрэгт оногдуулж буй ялын хэмжээг хөрш зэргэлдээ Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын ижил төрлийн гэмт хэрэгтэй харьцуулан судалж, манай орны эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал дэвшүүлжээ.

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх арга зүйн тэнхимийн багш, дэслэгч С.Чингүүн “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа, тулгамдсан асуудал” илтгэлдээ мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн 2023 онд үйлдэгдсэн энэ төрлийн гэмт хэргийн статистикт дүн шинжилгээ хийж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хууль тогтоомж, хууль сахиулах байгууллагуудын дотоод болон гадаад хамтын ажиллагааны үүрэг, ач холбогдол, түүнд тулгамдсан асуудлыг тодорхойлсон байна.

Уг судалгааны үр дүнд Монгол Улс мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэхэд үндсэн хууль эрх зүйн суурь, мэргэжлийн байгууллагын бүтэц, олон улсын гэрээ, хэлэлцээрт нэгдэн орох боломжийг бүрдүүлсэн ч хэрэгжилтэд мэдээллийн солилцоо сул, байгууллагын уялдаа холбоо дутмаг, мэргэшсэн хүний нөөц, тасралтгүй сургалт хязгаарлагдмал байгаагаас бодит хүндрэл, саад бэрхшээлүүд бий болж байна. Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх нь зөвхөн нэг байгууллагын хүрээнд хязгаарлагдахгүй, олон байгууллагын хамтын ажиллагаа, мэдээлэл, технологи, хүний нөөцийн чадавх, цогц арга хэмжээ шаардсан үйл явц юм гэсэн дүгнэлт хийжээ.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үр дүнтэй арга нь олон талт хамтын ажиллагаанд суурилсан цогц арга хэмжээг шаардаж байна. Үүнд: хууль эрх зүйн зохицуулалтыг олон улсын стандарттай нийцүүлэх, хууль сахиулах байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, цахим

платформ, мэдээллийн нэгдсэн санг бий болгох; шинэ технологи, тоног төхөөрөмж, ухаалаг хилийн хяналтын систем нэвтрүүлэх, мэдээллийн дүн шинжилгээ хийх; урьдчилан сэргийлэх ажлыг боловсрол, соён гэгээрүүлэх үйл ажиллагаатай хослуулах; хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж тусгайлсан мэргэжлийн баг бэлтгэх; олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлж, INTERPOL, UNODC зэрэг байгууллагуудтай хамтарсан сургалт, ажиллагааг идэвхжүүлэх шаардлагатай гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

ХӨСҮТ-ийн Талбарын тархвар судлалын албаны сургагч багш Д.Ариунгэрэл, анагаах ухааны доктор Б.Азжаргал, ХӨСҮТ-ийн Талбарын тархвар судлалын 15 дугаар ээлжийн суралцагч Н.Хулан, Н. Саранчулуун, Б.Биндэрьяа, Э.Лхагвадулам “Улаанбаатар хотын 18-24 насны залуучуудын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын талаарх мэдлэг, хандлага, хэрэглээг судлах нь” илтгэлдээ МУИС, АШУУИС, ШУТИС, МУБИС, ХААИС, МГХАМТИС, СЭЗИС, ОТИС, ЭЗШУИС, СУИС зэрэг сургуулийн 402 оюутнаас “Мансууруулах бодисын талаарх өсвөр үе, залуучуудын мэдлэг, хандлага, хэрэглээ”, Мансууруулах бодисын хэрэглээг илрүүлэх сорил (DAST), Эцэг эцэг эхийн хүүхдэд тавих хараа хяналтын байдлын талаарх хүүхдийн ойлголтыг үнэлэх 86 асуумж бүхий асуумжаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын талаарх мэдлэг, хандлага, хэрэглээний нөхцөл байдлыг судалж, Rstudio, SPSS программуудыг ашиглан статистик боловсруулалтыг хийсэн байна.

Уг судалгааны үр дүнд эцэг эхийн хараа хяналт сайтай оюутнуудын ихэнх нь (74.2%) мансууруулах бодис хэрэглэх саналд ямар ч тохиолдолд татгалзах хандлагатай байсан бол хараа хяналт сул оюутнуудын 21.74% нь сонирхож үзэх магадлалтай байсан. Судалгаанд оролцогчдын 4.5% нь мансууруулах бодис хэрэглэж үзсэн бөгөөд эдгээрийн дийлэнх нь (83%) хэн нэгнээс санал авч хэрэглэж байсан бол хэрэглэгчдийн гол нөлөөлөгч нь найз нөхөд, үе тэнгийнхэн, танихгүй хүмүүс байжээ. Корреляци, регрессийн дүн шинжилгээгээр мансууруулах бодисын хэрэглээ нь мэдлэгийн түвшин ($r=-0.17$, $p<0.001$) болон эцэг эхийн хараа хяналттай ($r=-0.14$, $p<0.001$) урвуу хамааралтай бөгөөд мэдлэг болон хараа хяналт сайн байх тусам хэрэглээ бага байгааг харуулж байна. Орлогын түвшин, хандлагын байдал нь хэрэглээтэй статистик ач холбогдолтой ялгаа үзүүлээгүй гэсэн дүгнэлт хийжээ.

Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын Тандалт судалгаа, дүн шинжилгээний тасгийн эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч А.Содмэргэн “Монгол Улс руу чиглэсэн гадаад улсын зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн үйл ажиллагаа ба шинэ урсгал” илтгэлдээ мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн дотоод болон гадаад нөхцөл байдал, тэр дундаа шинэ төрлийн бодис, гарал угсаа, гадаад улсад үйл ажиллагаа явуулдаг зохион байгуулалттай гэмт бүлэглэл, тэдний чиг хандлага, Монгол Улсыг чиглэсэн гадаадын зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн үйл ажиллагааны хэлбэр, эдийн засаг, нийгэм, аюулгүй байдалд хэрхэн сөргөөр нөлөөлж буйг нээлттэй болон хаалттай эх сурвалжийн мэдээлэлд тулгуурлан дүн шинжилгээ хийсэн байна.

Уг судалгааны үр дүнд гадаадын зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд Монгол Улсыг дамжин өнгөрөх болон эцсийн хэрэглээний зах зээл болгон

ашиглах эрмэлзэлтэй байгааг тодорхойлсон бөгөөд цахим сүлжээ, криптовалют, хил дамнасан синтетик бодисын үйлдвэрлэл, борлуулалтын шинэ арга замууд гэмт хэргийн шинж чанар, цар хүрээг улам боловсронгуй болгож байна. Энэ нь Монгол Улсын хууль сахиулах байгууллагын чадавх, эрх зүйн орчин, хил хяналтын тогтолцоо шинэ нөхцөл байдалд дасан зохицох шаардлагатайг харуулж, олон улсын зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүдийн үйл ажиллагаа Монгол Улсад чиглэх чиг хандлагатай байна гэсэн дүгнэлт хийжээ. Энэ нөхцөл байдлыг цогцоор шийдвэрлэхийн тулд цагдаагийн байгууллагын гүйцэтгэх ажиллагааг хил орчмын бүсэд эрчимжүүлж, тусгай программ хангамж ашиглан автоматжуулсан хяналт бий болгох; Dark Web, Telegram зэрэг платформ дахь бүлэглэлүүдийг илрүүлэх дижитал мөрдлөгийн систем нэвтрүүлэх; INTERPOL, UNODC, DEA зэрэг олон улсын байгууллагатай хамтран сургалт, хамтарсан ажиллагаа, мэдээлэл солилцоог идэвхжүүлэх; сургуулийн орчинд чиглэсэн ухуулга сурталчилгаа, онлайн платформ ашиглан эерэг контент түгээх; мөн шинэ төрлийн бодисын ангиллыг хуульчилж, шүүх, прокурорын байгууллагуудын ойлголт, мөрдлөгийг нэг мөр болгох арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Гэмт явдал, цагдаа, дотоодын цэрэг судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан-багш, цагдаагийн дэслэгч Э.Хандармаа “Монгол Улсын мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлийн олон улсын хамтын ажиллагаа” илтгэлдээ мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын болон үндэсний хууль тогтоомжийг судалж, хар тамхи бэлтгэн нийлүүлэгч (source countries), дамжуулан өнгөрүүлэгч (transit countries), хэрэглэгч (consumer countries) гэсэн улс орнуудын ангилал тулгуулан энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын байгууллага, энэ төрлийн гэмт тэмцэх олон улсын байгууллага, түүний эрх зүйн үндсийг судалсан байна.

Судалгааны үр дүнд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт нь Монгол Улс төдийгүй олон улсын хэмжээнд тулгамдсан асуудал хэвээр байгааг тодорхойлсон бөгөөд, харин энэ төрлийн гэмт явдалтай тэмцэхэд үндэсний болон олон улсын эрх зүйн зохицуулалт бүрэн хангалттай боловч практик, хамтын ажиллагааны нарийн зохицуулалт тодорхой бус, хамтын ажиллагааны уялдаа сул байгаагаас зорилтот үр дүнд хүрч чадахгүй нөхцөл байдал үүссэн гэсэн дүгнэлт хийжээ. Энэ нөхцөл байдлыг цогцоор шийдвэрлэхийн тулд мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг сайжруулах, дугуй ширээний уулзалт зохион байгуулах, улс хоорондын засгийн газрын түвшний хэлэлцээр боловсруулж батлах зэрэг үйл ажиллагааг тогтмол, шуурхай хэрэгжүүлж хэвших гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Гэмт явдал, цагдаа, дотоодын цэрэг судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан-багш, цагдаагийн дэд ахлагч Г.Хулан “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэхэд байгууллагуудын хамтын ажиллагаа” илтгэлдээ энэ төрлийн бодисын хууль бус эргэлттэй тэмцэх

байгууллагуудын эрх зүйн орчин, тогтолцоо, хамтын ажиллагаа, эрсдэлийн менежмент, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хүний нөөц, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо зэргийг судалсан байна.

Уг судалгааны үр дүнд мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлт нь нийгэм, эдийн засаг, аюулгүй байдалд ноцтой аюул учруулж буй асуудал хэвээр байна. Үүнийг шийдвэрлэхийн тулд төр, хууль сахиулах байгууллагууд, гаалийн ерөнхий газар болон эрүүл мэндийн байгууллагууд, иргэний нийгэм зэрэг олон байгууллагуудын хамтын ажиллагаа чухал бөгөөд энэ нь үр дүнтэй, тогтвортой арга хэмжээ авахад чиглэгдсэн байх ёстой. Байгууллагуудын хамтын ажиллагаа, хууль эрх зүйн орчныг сайжруулах, олон улсын хамтын ажиллагааны боломжууд, эрсдэлийн менежмент болон урьдчилан сэргийлэх арга хэмжээний ач холбогдлыг онцолсон. Монгол Улсын хувьд энэ асуудлыг шийдвэрлэхэд олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх, үндэсний хуулийн орчин сайжруулах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх нь чухал гэсэн дүгнэлт хийжээ.

ОХУ-ын ДХЯ-ны харьяа Уралын хуулийн институтийн мөрдөгчийн факультетын 4 дүгээр дамжааны суралцагч, цагдаагийн дэд ахлагч Д.Болдсайхан “Монгол Улс болон оросын холбооны улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг мөрдөн шалгах практикийн харьцуулсан судалгаа” илтгэлдээ Монгол Улс болон ОХУ-д мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа, тодорхой төрлийн ажиллагаа явуулах онцлог, шүүхэд нотлох баримтын хэмжээнд хэрхэн үнэлсэн талаар талаар судалж, энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах арга зүйд тулгамдсан асуудлыг тодорхойлсон байна.

Уг судалгааны үр дүнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг илрүүлэхэд сэжигт этгээдийн орон байр, зөвшөөрөгдсөн газарт нэгжлэг хийх, гар утас, компьютер, цахим мэдээллийн шинжилгээ хийх нь чухал үүрэгтэй болох нь тодорхой болсон бөгөөд эдгээр арга нь гэмт этгээдийн үйл ажиллагааг бүрэн шалгах, хамтран оролцогчдыг тогтоох, цахим болон олон нийтийн мэдээллийн сувгуудыг ашиглан үйлдэгдэж буй гэмт хэргийг илрүүлэх боломжийг нэмэгдүүлдэг гэсэн дүгнэлт хийжээ. Энэ нөхцөл байдлыг цогцоор шийдвэрлэхийн тулд Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг шалгах, нэгжлэг хийх эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх; мөрдөгчдийг компьютерын шинжилгээ, цахим болон кибер хяналтын технологи ашиглахад сургах; орон байр, хэрэгсэл нэгжих болон цахим мэдээллийг шалгах ажиллагааг хуулийн дагуу уламжлалт аргаас илүү үр дүнтэй болгох; Монгол, ОХУ-ын хууль эрх зүйн харьцуулалт судалгаа, практик үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх замаар хуулийн шинэчлэлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Хуулийн сэтгэл судлалын “Асхан холбоо” төрийн бус байгууллагын сэтгэл зүйч, магистрант Ц.Даваадорж, Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх арга зүйн тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D), цагдаагийн хошууч Ш.Номин-Эрдэнэ “Хар тамхи хэрэглэх зан үйлийн

сэтгэл зүйн мөн чанар: донтох хэв шинж ба эмгэг хамаарал” илтгэлдээ хар тамхи хэрэглэх зан үйлийн шалтгаан, сэтгэл зүйн онцлог, донтолтын хэв шинж, эмгэг хамаарал, хувь хүний сэтгэл зүйн эмзэг байдал, нийгмийн орчны нөлөөлөл зэргийг сэтгэл судлалын шинжлэх ухааны онол, сургаалд үндэслэн зан үйлийн тогтолцооны талаас судалж, дүн шинжилгээ хийсэн байна.

Уг судалгааны үр дүнд хар тамхи хэрэглэх зан үйлийн сэтгэл зүйн үндэс, донтолтын эмгэг хамаарлыг онолын түвшинд авч үзэх нь зан үйлийн давталт, шагналын тогтолцоо, импульсийн хяналт, нийгмийн дуурайлт зэрэг олон хүчин зүйлсийг ойлгож, хувь хүнийг донтох зан үйлд өртөмтгий болгодог болохыг харуулж байна. Монгол Улсад хар тамхины хэрэглээний эрсдэлт хүчин зүйлс нэмэгдэж байгаа нь асуудлыг зөвхөн хууль эрх зүйн болон хяналтын түвшинд бус, сэтгэл зүй, боловсрол, нийгмийн хамгааллын цогц арга замаар шийдвэрлэх шаардлагатай гэсэн дүгнэлт хийжээ.

Өсвөр үе, залуучуудын дунд хар тамхины хор уршгийн талаарх сэтгэл зүйн боловсролыг тогтмолжуулах, эмзэг бүлгийг сэтгэл зүйн оношилгоогоор тодорхойлж урьдчилан сэргийлэх, гэр бүл, хамт олны орчны нөлөөллийг бууруулах, хар тамхи хэрэглэгчдэд чиглэсэн сэтгэл зүйн мэргэшил, зөвлөгөө, бүлгийн дэмжлэгт суурилсан сэргээн засах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, мөн бодлого боловсруулахад онолын суурь судалгааг тогтмол явуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн саналыг дэвшүүлсэн байна.


Цагдаагийн сургуулийн 3322 дугаар дамжааны суралцагч, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч У.Сумъяа, Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн 3211 дүгээр дамжааны сонсогч Г.Уянга, Ө.Хонгорзул, Д.Хулан, Дотоод хэргийн их сургуулийн цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, цагдаагийн хошууч Н.Нямдорж “өсвөр насны хүүхэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэхээс урьдчилан сэргийлэх эрх зүйн болон нийгмийн тогтолцооны уялдаа, шийдвэрлэх арга зам” илтгэлдээ Монгол Улсад 2021-2025 онд үйлдэгдсэн мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдогсод, тэр дундаа өсвөр насны хүүхдийн дундах хэрэглээнд судалгаа хийж, БНСУ, ХБНГУ-ын эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны хязгаартай харьцуулан, энэ төрлийн бодисын талаарх мэдлэг, мэдээллийг тодорхойлох асуулгыг анкет, SPSS, өсвөр насны хүүхдүүдийн үйлдэж буй гэмт хэргийн шинжтэй үйлдэлд олон нийтийн хандлагыг контент анализын аргаар судалж, дүн шинжилгээ хийсэн байна.

Уг судалгааны үр дүнд хүүхэд, өсвөр насныхны мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ нь нас, орчин, мэдээлэл, хандлага зэрэг олон хүчин зүйлсээс шууд хамааралтай болохыг тодорхойлсон. Олон улсын туршлагаас харахад нийгмийн харилцаа, сэтгэл зүй, амьдралын ур чадварыг хөгжүүлэх өргөн хүрээний сургалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлснээр мансуурах эрсдэл, гэмт хэрэгт холбогдохыг бууруулж чаддаг. Мөн цахим орчин дахь хяналт сул байгаагаас өсвөр насныхан хорт зуршилд өртөх, ёс зүйн доголдолтой, гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдэл хийх эрсдэл нэмэгдэж байгаа нь насны онцлогт нийцсэн урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээ шаардлагатай гэсэн дүгнэлт хийжээ.

Насны онцлогт тохирсон мэдээллийн хүртээмж, боловсролын агуулгыг сайжруулж, сургуулийн орчныг сэтгэл зүйд ээлтэй, итгэлцэлд суурилсан болгох, хүүхдүүдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлийг бодлогын түвшинд хангах, боловсролын байгууллагын оролцоог хуульчилж урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх, цахим орчин дахь хяналт, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мөн Эрүүгийн хуульд насанд хүрээгүй хүүхдэд зориулсан хүмүүжлийн шинжтэй арга хэмжээг өргөжүүлэн оруулах зэрэг цогц арга хэмжээг төр, хувийн хэвшил, эцэг эх, багш, сэтгэл зүйч зэрэг нийгмийн бүх талын оролцоотойгоор хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

2.6. Эрдэм шинжилгээний өгүүлэл

“ХУУЛЬ САХИУЛАХУЙ” сэтгүүл



“Хууль сахиулахуй” сэтгүүлийн 2018 (№04) дугаарт Б.Алтансүх, М.Отгонбаатар, Б.Мөнхсэргэлэн нар “Хар тамхины гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар мэргэжилтнүүдийн дунд явуулсан санал асуулгын үр дүн” өгүүлэлдээ хар тамхитай холбоотой гэмт хэргийн Монгол Улс, БНХАУ-ын нөхцөл байдал, чиг хандлагын талаар харьцуулан судалж, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үүрэг бүхий 100 албан хаагчаас чанарын судалгаа авсан байна.

Уг судалгааг үндэслэн Монгол Улсад хар тамхитай холбоотой гэмт хэрэг тодорхой хяналтад байгаа ч бүрэн гүйцэд тэмцэж чадахгүй байна. Энэ

нь хүүхэд, залуусын дунд хэрэглээ нэмэгдсэн, мэдээллийн давтамж ихэссэн, хууль эрх зүйн орчин сул, алба хаагчдын ур чадвар, мэргэшил дутмаг, хяналт шалгалт хангалтгүй, төрийн бус байгууллагуудын оролцоо бага зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж байна. Мөн интернэт, цахим орчин дахь зохих хяналтгүй мэдээлэл өсвөр насны хүүхэд, залуучуудыг сөргөөр нөлөөлж, даган дуурайх эрсдэлийг нэмэгдүүлж байна гэсэн дүгнэлт хийжээ. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль эрх зүйн орчныг сайжруулах, хариуцлагыг чангаруулах, Хар тамхитай тэмцэх газрыг бие даасан бүтэц, мэргэшсэн алба хаагчтай болгох, донтох эмгэгтэй хүнийг албадан эмчлэх, сэтгэл зүйн зөвлөгөө, эмчилгээний төв байгуулах, алба хаагчдын мэргэшлийг дээшлүүлэх, мэргэжлийн ТББ-уудыг идэвхжүүлэх, сургалт, судалгаа, мэдээлэл, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

“Хууль сахиулахуй” сэтгүүлийн 2019 (№02) дугаарт М.Отгонбаатар “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх эрх зүйн орчин” өгүүлэлдээ хар тамхи, мансууруулах бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх арга, хэлбэрийг судалж, олон улсын шуудан илгээмж, цахилгаан бараа, ахуйн болон хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүнд нуух, тээвэрлэгч этгээд ашиглах зэрэг нарийн арга хэрэглэж байгаа үйлдэл, тус бодисыг илрүүлэхэд тулгамдсан асуудлыг тодорхойлсон байна.

Судалгааны үр дүнд цаашид мансууруулах бодисын хууль бус эргэлт зохион байгуулалттай бүлэглэлийн шинжтэй болох нөхцөлийг бүрдүүлж байна. Мансууруулах бодис хэрэглэсэн этгээдүүд хүний амь нас хохироох, хүчиндэх, хулгайлах, дээрэмдэх, залилан мэхлэх зэрэг олон төрлийн гэмт хэрэг үйлдэх эрсдэлтэй болж байгаа нь ноцтой асуудал юм. Цаашид хэрэглэгчид өөрийн

хэрэгцээг хангах зорилгоор бусдыг далайлган сүрдүүлэх, захиалгат аллага, хүн худалдаалах, биеэ үнэлэхийг зохион байгуулах зэрэг хүнд гэмт хэрэгт холбогдох магадлал өндөр байна. Нийгэмд ажилгүйдэл, ядуурал нэмэгдэхийн хэрээр иргэд энэ төрлийн гэмт хэрэг үйлдэх хандлага өсөх аюултай бөгөөд улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх явдал ч өсөн нэмэгдэх төлөвтэй байна гэсэн дүгнэлт хийжээ. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор их, дээд сургуулийг түшиглэсэн эрдэм шинжилгээний байгууллагуудаар суурь болон хавсарга судалгаа хийлгэж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах шаардлагатай. Үр дүнтэй судалгааны дүнд тулгуурласан арга зам, бодлогыг тодорхойлох нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үндсэн арга хэмжээ болно. Мөн хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан олон нийтэд, тэр дундаа хүүхэд, залуучуудын дунд хар тамхи, мансууруулах бодисын хор хөнөөлийн талаарх мэдээллийг стандартчилсан, нэгдсэн байдлаар хүргэх хэрэгтэй. Ерөнхий боловсролын ахлах ангид тогтмол сургалт зохион байгуулах, төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, сөрөг контент руу хандалтыг хязгаарлах, каннабисын тархцыг илрүүлж устгах ажлыг тогтмолжуулах зэрэг цогц арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

“Хууль сахиулахуй” сэтгүүлийн 2019 (№03) дугаарт С.Байгальмаа, Д.Дэжидмаа, Д.Лянхуа, Л.Насанцэнгэл нар “Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдогсдын шүүх сэтгэц, эмгэг судлалын шинжилгээ хийлгэх үеийн сэтгэцийн байдал” өгүүлэлдээ судалгаагаар оролцогчдын ихэнх нь мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдсон, 46.2% нь хэрэглэсэн, 17.9% нь хадгалсан, хэрэглэсэн, 15.1% нь бэлтгэсэн, хадгалсан зэрэг хэргүүд үйлджээ. Мөн нийт оролцогчдын 18.9% нь өмнө нь гэмт хэрэгт холбогдож байсан бөгөөд тэдний 60% нь өмнөх хэрэг нь мансууруулах бодистой холбоотой байв. Энэ нь бодисын хэрэглээ давтан гэмт хэрэг үйлдэх шалтгаан болж байна. Шүүхийн сэтгэцийн шинжилгээгээр мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн 73.6%-д айдас, сэтгэл түгшилт, бухимдал зэрэг сэтгэлзүйн хариу урвал илэрсэн бол зөвхөн 26.4% нь сэтгэл санаа хэвийн байсан. Энэ нь бодисын хэрэглээ нь зөвхөн гэмт хэрэгт хүргээд зогсохгүй, сэтгэлзүйн хувьд тогтворгүй байдалд оруулж буйг харуулж байна гэсэн дүгнэлт хийжээ.

Мансууруулах бодисын 1-2 удаагийн хэрэглээ ч хүчтэй донтох эрсдэлтэй байдаг тул давтан гэмт хэрэгт холбогдохоос сэргийлэх зорилгоор Эрүүл мэнд, Хууль, Боловсролын байгууллагууд хамтран ажиллах шаардлагатай. Үүнд зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, эмчилгээ, хууль эрх зүйн болон сэтгэл заслын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгтэй. Мөн төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран сургууль, их дээд сургууль, байгууллагуудад урьдчилан сэргийлэх сургалт явуулах, үндэсний хэмжээнд хэрэглэгчдийн судалгааг ЦЕГ, ТЕГ, ДХИС, СЭМҮТ зэрэг байгууллагууд хамтран зохион байгуулах шаардлагатай гэсэн санал дэвшүүлжээ.

“Хууль сахиулахуй” сэтгүүлийн 2020 (№01) дугаарт доктор В.Амарсанаа “Монгол Улсын нутаг дэвсгэрт 2017-2019 онд бүртгэгдсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой

гэмт хэргийн судалгааны дүн шинжилгээ” өгүүлэлдээ судалгаагаар хар тамхи хар тамхи мансууруулах бодисын хууль бус эргэлтийн нөхцөл байдал, шүүхээс оногдуулсан ял шийтгэл зэргийг судалж, тулгамдсан асуудлыг тодорхойлсон байна. Хар тамхи хэрэглэдэггүй хүмүүсийн 90% гаруй нь хэрэглэгчидтэй огт харилцахгүй байхад хэрэглэгчдийн 78.3%-ийн ойрын хүрээлэлд өөр хэрэглэгч байдаг нь нөлөөллийн сүлжээ өргөн тархсан болохыг харуулж байна гэж үзжээ.

Уг судалгааны хүрээнд анх удаа гэмт хэрэг үйлдэгчид ихэвчлэн сонирхол эсвэл найз нөхдийн хүрээнд хэрэглэж эхэлдэг бол давтан гэмт хэрэг үйлдэгчид мансууруулах бодисыг худалдаалах, хэрэглэх зорилготой, донтолтод шилжсэн байдал ажиглагдаж байна. Мөн мансууруулах бодисыг хэрэглэх явц нь хууль бус эргэлтийн бүх шатанд үндсэн асуудал хэвээр байна. Хэрэглээний түвшин 2019 онд огцом өссөн бөгөөд энэ нь эрүүгийн хуулиар хэрэглэсэн үйлдэлд хариуцлага тогтоогоогүйтэй холбоотой. Одоогоор зөвхөн Зөрчлийн тухай хуулиар торгууль, баривчилгааны хязгаарлагдмал арга хэмжээ авч байгаа нь үр нөлөө багатай байна. Хэрэв хэрэглэсэн үйлдлийг хадгалсан үйлдэлтэй адил түвшинд үзэж, хариуцлагын тогтолцоог чангатгавал энэ төрлийн гэмт хэргийг бууруулах боломжтой. Хэдий нөлөөлөл нь архи, тамхины хор уршигтай харьцуулахад бага боловч геополитикийн нөхцөл байдал, ирээдүйн эрсдэлийг тооцоолбол энэ асуудал үндэсний аюулгүй байдалд ноцтой заналхийлэл болж болзошгүй байна гэж дүгнэжээ.

Эрүүгийн хуулийн тусгай анги болон холбогдох хууль тогтоомжид мансууруулах бодис хэрэглэсэн үйлдлийг тусгаж, хариуцлагын тогтолцоог чангатгах шаардлагатай. Энэ нь хэрэглээний өсөлтийг бууруулах, давтан гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг багасгах чухал алхам болно. Зөрчил, гэмт хэргийн хариуцлагыг шатлалтайгаар тодорхой болгож, хууль хэрэгжүүлэх байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах нь үр дүнтэй. Мөн урьдчилан сэргийлэх чиглэлээр боловсролын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран үе шаттай, өргөн хүрээтэй сургалт, мэдээллийн ажлыг зохион байгуулах хэрэгтэй. Цаашид ЦЕГ, ТЕГ, СЭМҮТ зэрэг байгууллагууд хамтран үндэсний хэмжээнд хэрэглэгчдийн бодит судалгааг тогтмол явуулж, бодлогын шийдвэрт ашиглах нь чухал.

“Хууль сахиулахуй” сэтгүүлийн 2020 (№02) дугаарт доктор Б.Алтансүх “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн олон улсын нөхцөл байдал, Ковид 2019 цар тахлын нөлөөлөл” өгүүлэлдээ НҮБ-ын Хар тамхитай тэмцэх албаны 2020 оны судалгааны тайлан, БНХАУ-ын 2020 оны хар тамхины нөхцөл байдлын тайланг харьцуулан, энэ төрлийн бодисын олон улсын нөхцөл байдлыг судалжээ. Ковид-19 цар тахлын нөлөөгөөр Төв Азид каннабисын хэрэглээ өндөр түвшинд хадгалагдаж, синтетик болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус үйлдвэрлэл нэмэгдэх хандлагатай байна. Химийн аргаар бүтээгдсэн, хуульд тусгагдаагүй шинэ төрлийн бодисууд, тухайлбал “маркны хэлбэртэй цаас”, “ухаалаг эм” зэрэг бүтээгдэхүүн зах зээлд гарч, залуусын дунд тархаж байгаа нь ноцтой аюул дагуулж байна. Мансууруулах бодисын хууль бус эргэлт зохион байгуулалттай болж, гэмт этгээдийн сүлжээ өргөжиж, цахим сүлжээг ашиглан далд хэлбэрт шилжиж байна. Энэ нь илрүүлэх, таслан зогсоох үйл ажиллагаанд хүндрэл учруулж, хил дамнасан гэмт хэргийн

эрсдэлийг улам нэмэгдүүлж буй тул хяналтын тогтолцоог шинэ шатанд хүргэх шаардлагатай болжээ гэж дүгнэжээ.

Мансууруулах бодис илрүүлэх орчин үеийн лаборатори, техник хэрэгсэл нэвтрүүлж, хил, гаалийн хяналт шалгалтыг чангатгах нь чухал. Ингэснээр шинэ төрлийн синтетик бодисыг илрүүлэх чадавх нэмэгдэж, хууль бус үйлдвэрлэл, тээвэрлэлтийг эрт таслан зогсоох боломж бүрдэнэ. Хөрш орнууд болох ОХУ, БНХАУ-тай хамтран хоёр талт гэрээ байгуулах, мэдээлэл солилцох, мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулах, цахим сүлжээнд суурилсан гэмт хэргийн эсрэг хамтарсан ажиллагаа зохион байгуулах шаардлагатай. Үүний зэрэгцээ урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлж, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх нь үндэсний аюулгүй байдлыг хамгаалахад чухал ач холбогдолтой.

“Хууль сахиулахуй” сэтгүүлийн 2022 (№01) дугаарт Р.Гэрэлбат “Монгол Улс дахь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн өнөөгийн нөхцөл байдал, чиг хандлага” өгүүлэлдээ энэ төрлийн гэмт хэргийн олон улсын болон Монгол Улс дахь нөхцөл байдал, энэ төрлийн гэмт явалтай тэмцэх зорилгоор хэрэгжүүлж буй үр дүн, тулгамдсан асуудлыг судалсан байна.

Судалгааны үр дүнд COVID-19 цар тахал нь мансууруулах бодисын хууль бус эргэлтэд шинэ хэлбэр бий болгож, даркнет болон цахим орчин ашиглах үйлдэл нэмэгдсэн. Монгол Улсад хил хаагдаж, хөл хорио тогтоосон үед нийлүүлэлт багассан ч хууль бус тээвэрлэлтийн арга хэлбэр илүү нарийсаж, зохион байгуулалттай бүлэглэлүүдийн оролцоо нэмэгдсэн нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд хүндрэл үүсгэж байна гэж дүгнэжээ. Олон улсын туршлагаас харахад хэрэглэгчийг шийтгэхээс илүүтэй эрт илрүүлэх, эмчлэх, нийгэмшүүлэх арга үр дүнтэй байна. Иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлснээр хэрэглэгчдийн тоог бууруулах боломжтойг судалгаа харуулж байгаа тул Монгол Улсад энэ жишгийг хэрэгжүүлэх шаардлагатай. Цахим орчин дахь хяналтыг сайжруулж, бусад улстай мэдээлэл солилцох хамтын ажиллагааг өргөжүүлэх нь даркнет болон цахим сувгаар явагдаж буй хууль бус худалдааг хязгаарлахад чухал ач холбогдолтой. Мөн гэмт хэргийг индекс болон индекс бус гэж ангилж бүртгэх замаар стратеги, төсвөө зөв тодорхойлох хэрэгтэй. Энэ арга нь түгээмэл үйлдэгддэг гэмт хэргийн гаралтыг бууруулж, урьдчилан сэргийлэх ажлыг илүү үр дүнтэй зохион байгуулах нөхцөл бүрдүүлнэ.

“Хууль сахиулахуй” сэтгүүлийн 2022 (№02) дугаарт Ц.Энхманлай “Хар тамхины нийгмийн хор аюулын өнөөгийн нөхцөл байдал” өгүүлэлдээ хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлтийн ойлголт, Монгол Улс дахь нөхцөл байдал, тухайн гэмт хэрэгт холбогдогсдын онцлог зэргийг судалж, энэ төрлийн бодисын хууль бус эргэлт нь зохион байгуулалттай, нуугдмал хэлбэрээр үйлдэгддэг тул хууль сахиулах байгууллагын мэргэжлийн ур чадвар, байгууллага хоорондын болон бүс нутгийн хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай, бусад улс орнуудын туршлагаас харахад ухуулга сурталчилгаа, урьдчилан сэргийлэх төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх нь үр дүнтэй бөгөөд Монгол Улсад ийм бодлогыг хэрэгжүүлэх зайлшгүй хэрэгцээ бий болжээ гэж дүгнэжээ.

Мөн энэ төрлийн гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд нууц аргыг үр дүнтэй ашиглах, олон улсын хамтарсан ажиллагааны жишгийг нутагшуулах

шаардлагатай. Учир нь хууль бус эргэлтэд оролцогчид төлбөр тооцоог нууц хэлбэрээр зохион байгуулж, гараас гарт дамжуулахгүйгээр хүргэдэг тул ил аргаар илрүүлэх боломж хязгаарлагдмал байна. Иймд мөрдөн шалгах ажиллагааны явцад цугларсан баримт, мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийх аргачлалыг нэвтрүүлж, гэмт хэрэгтнүүдийн сэтгэл зүй, зан байдал, үйлдлийн онцлогийг тогтоох тогтолцоог бий болгох, хар тамхины гэмт хэргийг сүлжээгээр нь илрүүлэхийн тулд нууц ажиллагаа болох шалгалтын худалдан авалт, хяналттай хүргэлт зэрэг аргыг идэвхжүүлэх шаардлагатай, хар тамхины гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогыг боловсруулж, хууль хяналтын байгууллагуудын уялдаа холбоог бэхжүүлэх, хяналт тавьж үнэлгээ хийдэг бие даасан бүтцийг УИХ, Засгийн газрын дэргэд байгуулах нь үр дүнтэй алхам болно гэсэн санал дэвшүүлжээ.

“Хууль сахиулахуй” сэтгүүлийн 2022 (№04) дугаарт Г.Өлзийбуян “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн олон улсын нөхцөл байдал, Ковид 2019 цар тахлын нөлөөлөл” өгүүлэлдээ даяаршил, мэдээллийн чөлөөт урсгалын нөлөөгөөр Монгол Улсад гэмт хэргийн шинж, үйлдлийн арга хэлбэр өөрчлөгдөж, цагдаагийн байгууллагаас техник, технологид суурилсан илрүүлэх аргыг нэвтрүүлэх шаардлага үүсэж байна. Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг нь “хохирогч” нь өөрөө “холбогдогч” болох, дуудлага мэдээлэл өгөхөөс зайлсхийдэг онцлогтой тул нууц ажиллагаагаар илрэх тохиолдол давамгайлж байна. Гэмт хэргийг илрүүлж, хариуцлага тооцож байгаа ч хэрэглэгчдийн тоо нэмэгдэж, нас залуужиж байгаа нь анхаарал татаж байна. Цагдаагийн байгууллагад хураагдаж буй бодисын хэмжээ жил бүр өсөж байгаа нь нийлүүлэлтийг таслан зогсоох, “хар зах”-ын үнийг өндөр байлгах бодлого олон улсын жишиг болохыг харуулж байна. Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг иргэдийн нас, хүйс, сэтгэхүйн онцлогт тохируулан уламжлалт болон шинэлэг аргаар хэрэгжүүлэх шаардлагатай.

Хар тамхитай холбоотой гэмт хэрэгт холбогдсон этгээдүүдэд нийгэмд нөлөөлөх, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа явуулах эрхийг хязгаарлах зохицуулалт боловсруулах шаардлагатай. Ингэснээр олон нийтийн сэтгэл зүйд сөрөг нөлөө үзүүлэх боломжийг багасгах юм. Мөн хэрэглэгчдэд тавих хяналтыг хуульчлан, тэднийг эмчлэх, нийгэмшүүлэх төвийг эрүүл мэндийн байгууллагатай хамтран байгуулах, сайн дурын эмчилгээний эрх зүйн боломжийг бүрдүүлэх хэрэгтэй. Энэ нь хэрэглэгчдийг гэмт хэргийн сүлжээнээс тасалж, дахин хэрэглээнд орохоос урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ гэсэн санал дэвшүүлжээ.



“Тусгаар тогтнол” сэтгүүлийн 2020 №1 (49) дугаарт Ц.Нямгэрэл “Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын үндэсний эрх зүйн зохицуулалтын зарим түүхэн эх сурвалж баримт” өгүүлэлдээ энэ төрлийн гэмт хэргийн Үндэсний эрх зүйн зохицуулалтын түүхэн эх сурвалж, Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодистой тэмцэх хэрэгцээ, шаардлага зэргийн хөрш орнуудын нөхцөл байдалтай уялдуулан судалжээ.

Судалгааны үр дүнд манай улсад хар тамхины төрлийн ургамал зэрлэгээр ургадаг талаар мэдээлэл олон нийтэд хүрэх нь хүүхэд, залуусын сонирхлыг өдөөж, гэмт хэрэгт холбогдох тохиолдол нэмэгдэж байна. Мөн гадаадын иргэдийн оролцоотойгоор мансууруулах бодис

улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх, тээвэрлэх, худалдах гэмт хэрэг нэмэгдэж, хэрэглэгчдийн тоо 2010 оноос 2018 онд 10 дахин өссөн нь нөхцөл байдлыг ноцтой болгож байна. Гэвч урьдчилан сэргийлэх ажил, эмчилгээний тогтолцоо, мэргэжлийн эмч, тоног төхөөрөмж хангалтгүй, харин Монгол Улс дамжин өнгөрөгч орноос хэрэглэгч орон болж хувирсан нь бодлогын түвшинд анхаарал шаардлагатайг харуулж байна гэж дүгнэжээ.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлт, хэрэглээг таслан зогсоохын тулд төрийн бодлогын хэмжээнд уялдаа холбоотой арга хэмжээ авах, мэргэжлийн боловсон хүчнийг тогтвортой бэлтгэх, хил хяналтын байгууллагуудыг шинэ техник хэрэгслээр хангах, эрүүл мэндийн байгууллагад эмчилгээ, сэргийлэлт тогтмолжуулах шаардлагатай. Мөн олон нийтийн мэдээллийн кампанит ажлыг сонирхол өдөөхгүйгээр, зөв хандлага төлөвшүүлэх чиглэлд зохион байгуулах нь чухал гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

“Тусгаар тогтнол” сэтгүүлийн 2024 №1 (64) дугаарт Ц.Нямгэрэл “Хар тамхи татах ба хязгаараар оруулж худалдахыг хориглосон үндэсний эрх зүйн зохицуулалтын зарим түүхэн эх сурвалж (1921-1996 он)” өгүүлэлдээ энэ төрлийн бодисыг хууль бусаар хилээр нэвтрүүлж байсан эрх зүйн зохицуулалтыг Ардын засгийн газрын шүүх цаазын бичиг, 1924 оны Шүүх цаазын бичиг, 1942, 191 оны Эрүүгийн хууль, 1987, 1992 оны эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлтийн эрх зүйн зохицуулалтыг түүхэн хөгжил талаас нь судалсан байна. Монгол Улсын хууль цаазын хөгжлийн түүхэнд хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэхэд чиглэсэн хууль тогтоомжийг тухайн үеийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалд нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлж ирсэн. Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулахдаа нийгмийн шинэ нөхцөл, зохион байгуулалттай болон шинээр гарч буй гэмт хэрэг, олон улсын конвенц, Үндсэн хуулийн үзэл санаатай уялдуулж, хар тамхины гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагыг чангатгах бодлого баримталсан нь урьдчилан сэргийлэх, илрүүлэхэд үр нөлөөтэй гэж дүгнэжээ.

Цаашид хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн хууль тогтоомжийг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, хариуцлагын тогтолцоог

илүү үр нөлөөтэй болгох, хэрэгжилтийг хангах механизмыг боловсронгуй болгох шаардлагатай. Мөн гэмт хэрэгтэй тэмцэх бодлогыг зөвхөн ял шийтгэлийн түвшинд бус, урьдчилан сэргийлэх, боловсрол олгох, олон талын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр боловсронгуй болгох нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

“ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС” сэтгүүл



“Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн 2018 (№69) дугаарт Б.Алтансүх “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэхэд бүс нутгийн хэмжээнд хамтран ажиллах нь” өгүүлэлдээ хар тамхины гэмт явдалтай тэмцэх олон улсын эрх зүйн зохицуулалт, Монгол Улсын Үндэсийн хууль тогтоомж, тэр дундаа эрүүгийн эрх зүйн зохицуулалт, 2002, 2015 оны эрүүгийн хуулийн харьцуулалт, БНХАУ-ын эрүүгийн эрх зүйн бодлогыг харьцуулсан, бүс нутгийн хэмжээнд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх асуудлыг судалсан байна.

Судалгааны үр дүнд шинэ төрлийн гэмт хэрэг, тэр дундаа мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэхэд зөвхөн дотоодын арга хэмжээ хангалтгүй болж, бүс нутгийн хэмжээнд хамтын ажиллагаа нэн чухал болж байна. Энэ хүрээнд хууль сахиулагчдыг харилцан сургах, мэргэжлийн чадавхыг нэмэгдүүлэх, хамтарсан сургалт, дадлага зохион байгуулах нь чухал. Мөн мэдээлэл солилцох системийг сайжруулж, гэмт бүлэглэлүүдийн талаар мэдээллийн сан бүрдүүлэх, түүнчлэн хүч хэрэглэх, урьдчилан сэргийлэх нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнтэй зэрэгцэн Эрүүгийн эрх зүйн харилцан туслалцааны гэрээ байгуулж, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх нь мөрдөн шалгах ажиллагааны үр дүнг дээшлүүлэх гол нөхцөл болж байна гэж дүгнэжээ.

Нэгдүгээрт, хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг бүс нутгийн хэмжээнд өргөжүүлж, шинэ арга зүй, олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх сургалт, чадавхжуулах хөтөлбөрийг тогтмол зохион байгуулах. Хоёрдугаарт, хар тамхины хууль бус эргэлттэй холбоотой мэдээллийг хурдан солилцох мэдээллийн нэгдсэн санг байгуулах, гэмт бүлэглэлүүдийн талаарх мэдээллийг хамтран ашиглах. Гуравдугаарт, хүч хэрэглэх болон урьдчилан сэргийлэх нэгдсэн төлөвлөгөө боловсруулах, төрийн болон иргэний байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах. Дөрөвдүгээрт, Эрүүгийн эрх зүйн харилцан туслалцааны гэрээг олон улсын хэмжээнд өргөн хүрээнд байгуулах, хамтарсан мөрдөн шалгах ажиллагааны эрх зүйн үндсийг баталгаажуулахыг санал болгосон байна.

“Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн 2019 (№74) дугаарт С.Байгальмаа “Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдогсдын шүүхийн

сэтгэц, эмгэг судлалын шинжилгээ хийлгэх үеийн сэтгэцийн байдал” өгүүлэлдээ энэ төрлийн бодисын Олон улсын өвчний 10 дугаар ангилалд авч үзсэн байдал, Европын хяналтын төвийн тайлан, БНХАУ, Тайван зэргийг судалж, энэ төрлийн бодис хэрэглэсэн 106 тохиолдлыг сэтгэц, эмгэг судлалын байдлыг судалжээ.

Мансууруулах бодисын 1-2 удаагийн хэрэглээ ч хүчтэй донтох эрсдэлтэй байдаг тул давтан гэмт хэрэгт холбогдохоос сэргийлэх зорилгоор Эрүүл мэнд, Хууль, Боловсролын байгууллагууд хамтран ажиллах шаардлагатай. Үүнд зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, эмчилгээ, хууль эрх зүйн болон сэтгэл заслын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгтэй. Мөн төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран сургууль, их дээд сургууль, байгууллагуудад урьдчилан сэргийлэх сургалт явуулах, үндэсний хэмжээнд хэрэглэгчдийн судалгааг ЦЕГ, ТЕГ, ДХИС, СЭМҮТ зэрэг байгууллагууд хамтран зохион байгуулах шаардлагатай гэсэн санал дэвшүүлжээ.

“Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн 2021 (№82) дугаарт Д.Болорчимэг “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр Монгол Улсын хууль тогтоомжийг олон улсын гэрээтэй харьцуулан дүн шинжилгээ хийх нь” өгүүлэлдээ Монгол Улс НҮБ-аас баталсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай конвенц, энэ төрлийн бодисын хууль бус эргэлт, үндэсний эрх зүйд тусгагдсан байдал зэргийг судалж, харьцуулан дүн шинжилгээ хийсэн байна.

Монгол Улс энэ олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн дагуу 11 хуулийн хүрээнд зохицуулалт тусгасан байдаг. Судалгаагаар олон улсын 14 хэм хэмжээний зохицуулалтаас 12 нь үндэсний хууль тогтоомжид бүрэн туссан боловч 2 зохицуулалт нь зөвхөн үндэсний хөтөлбөрт тусгагдаж, хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал, хууль бус эргэлтээс олсон хөрөнгөөр санхүүждэг зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах зэрэг чиглэлүүд биелээгүй хэвээр байна. Мөн мансууруулах үйлчилгээтэй ургамлын тархцыг хязгаарлах, устгах зохицуулалт эрх зүйн хувьд тусгагдсан ч төсөв санхүү, мэргэжлийн боловсон хүчний дутагдал зэрэг шалтгаанаас хэрэгжилт сул байгаа нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боломжийг хязгаарлаж байна гэж дүгнэжээ.


Монгол Улсын Эрүүгийн хуульд “энэ төрлийн гэмт хэргийг санхүүжүүлэх”, “өгүүлэн хатгах, уриалах, турхирах, хууран мэхлэх замаар бусдад хэрэглэхийг өдөөх” зэрэг үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцож, ялын хүндрүүлэх бүрэлдэхүүнд тусгах шаардлагатай. Мөн мансууруулах ургамлын устгал болон хууль бус эргэлттэй тэмцэх зохицуулалтын хэрэгжилтийг хангахын тулд эрх зүйн орчныг боловсронгуй болгож, гадаад орнуудын сайн туршлагыг судлан нэвтрүүлэх нь зүйтэй. Үүнтэй зэрэгцэн төсөв, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх, нэгдсэн удирдлагын тогтолцоог сайжруулах замаар үндэсний хөтөлбөрийг бодит үр дүнд хүргэх бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэхийг санал болгосон байна.

“Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн 2021 (№85) “Хууль зүйн салбарын одоо ба ирээдүй: асуудал, шийдэл тусгай дугаарт Б.Азжаргал “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэгт хорих ялаар

шийтгүүлсэн хоригдолд тавих хяналт, анхаарах асуудал” өгүүлэлдээ хорих байгууллагад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис нэвтрэх асуудал нь жилээс жилд нэмэгдэж байгаа тул энэ нь хорих байгууллагын тулгамдсан гол асуудлын нэг болж байна. Иймд хорих ангиудад хууль дэг журмыг сахиулах, харуул хамгаалалт, хяналт шалгалтыг чангатгах, илрүүлэх арга хэрэгслийг сайжруулах, алба хаагчдыг тогтмол сургалтад хамруулах шаардлагатай. Мөн хорих байгууллагын алба хаагчид болон сэтгэл зүйчдийг мэргэшүүлэх, энэ төрлийн бодис нэвтрэхээс урьдчилан сэргийлэх эрх зүйн баримт бичиг боловсруулж хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна гэж дүгнэжээ.

Хорих байгууллагад мансууруулах бодис нэвтрэхээс сэргийлэхийн тулд Албаны нохой, илрүүлэгч тоног төхөөрөмжийг ашиглах, алба хаагчдыг тусгай сургалтад хамруулж мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, Сэтгэл зүйчийн орон тоог бий болгох, ажиллаж буй сэтгэл зүйчдийг мэргэшүүлэх, Иргэдэд чиглэсэн гарын авлага, сургалт, мэдээллийн ажлыг өргөн хүрээнд зохион байгуулах, Гадаадын дэвшилтэт туршлага, зохицуулалтыг судалж нутагшуулах, Хар тамхитай холбоотой гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийг чангатгах, ялын бодлогыг сайжруулах саналыг дэвшүүлжээ.

“МОНГОЛЫН ТӨР, ЭРХ ЗҮЙ” сэтгүүл



“Монголын төр, эрх зүй” сэтгүүлийн 2018 (№1) дугаарт Өмнөговь аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүгч П.Долгормаа “Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн практик, хэрэглээ анхаарах зарим асуудалд” өгүүлэлдээ уг хуулийн хэрэгжилт, 15 жилийн судалгааны үр дүн, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн уялдаа холбоо, тус хуулийн зарим зохицуулалтыг өөрчлөх хэрэгцээ, шаардлага, тухайн хуулийг хэрэгжүүлэхэд учирч байгаа хүндрэл, бэрхшээл, эрх зүйн зохицуулалтын ойлгомжгүй байдлыг судалсан байна.

Уг судалгааны хүрээнд шинэчлэн найруулсан “Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай” хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд процедурын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх шаардлагатай гэсэн дүгнэлт хийж, хуулийн шинэчилсэн найруулгын төслийг сайжруулах шаардлагатай гэж үзжээ.

“Монголын төр, эрх зүй” сэтгүүлийн 2018 (№4) дугаарт Хууль сахиулахын их сургуулийн багш, докторант Б.Алтансүх “Мансууруулах болон сэтгэц нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх асуудал” өгүүлэлдээ мансууруулах эмийн тухай НҮБ-ын конвенц, Монгол Улсын Үндэсний аюулгүй

байдлын үзэл баримтлал, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, Эрүүгийн хууль, зөрчлийн тухай хуульд энэ төрлийн бодисын хууль бус эргэлттэй тэмцэх зохицуулалт, оногдуулах хариуцлагыг судалж, 2013-2017 оны онд үйлэгдсэн гэмт хэргийн статистик, түгээмэл хэрэглэгддэг амфетамин, метамфетамин, мансууруулах үйлчилгээтэй бодисыг Монгол Улсад оруулж ирж байгаа үйлдлийн аргыг судалсан байна.

Уг судалгааны хүрээнд бүс нутгийн хэмжээнд хууль сахиулах байгууллагын мэдээлэл солилцох сувгийг сайжруулах, гэмт бүлэглэлийн сан үүсгэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх шинэ арга барилыг суралцах, тухайн гэмт хэрэгтэй тэмцэх нэгдсэн төлөвлөгөө боловсруулах шаардлагатай гэж үзжээ.

“Монголын төр, эрх зүй” сэтгүүлийн 2020 (№4) дугаарт магистрант Б.Тэмүүлэн “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял эдлүүлэх ажиллагааны өнөөгийн байдал” өгүүлэлдээ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн 2018-2020 онд үйлдэгдсэн гэмт хэргийн статистик, АНУ, БНХАУ, ОХУ, Канад, Испани, Ирланд, ХБНГУ, Нидерланд, Зүүн өмнөд Азийн орон, Монгол Улсад тухайн бодисыг нэвтрүүлж байгаа суваг, энэ төрлийн гэмт хэрэгт хорих ял эдэлж байгаа, цагдан хоригдож байгаа этгээдүүд болон тэдний нөхцөл зэргийг судалж, ШШГГ-аас “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх” Үндэсний хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, ШШГЕГ, ЦЕГ-ын даргын “Хамтран ажиллах журам”, Зэвсэгт хүчний харьяа анги байгууллагуудтай хамтран ажиллах ажиллагаа зэргийг судалсан байна.

Уг судалгааны хүрээнд ШШГ байгууллагыг хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй холбогдсон гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээдийг хяналтад авч, анхаарал татсан яриа өгүүлэл, эрсдэл бүхий байдал илэрсэн тохиолдолд харуул хамгаалалтын алба хаагчдад тусгайлсан үүрэг чиглэл өгч, үзлэг нэгжлэгийг чангаруулах, нөлөөллийн шинжтэй нийгмийн ажил явуулах зэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион явуулж байгаа ч хорих ял эдэлж байгаа хоригдолд тавих хяналтыг улам эрчимжүүлэн ажиллах шаардлагатай байна гэж гэж үзжээ.



МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТТЭЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ЯВДЛЫГ СУДАЛСАН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ



3.1. Магистр, докторын зэрэг горилсон бүтээл, суурь болон хэрэглээний судалгааны тайлангийн үр дүнд хийсэн дүн шинжилгээ

Монгол Улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт явдлын талаар бичигдсэн доктор, магистрын зэрэг горилсон бүтээлүүд, гүйцэтгэсэн захиалгат судалгааны тайлангуудыг нэгтгэн шинжлэхэд судалгааны чиглэл, арга зүй, агуулгын хүрээ болон онол, практикийн ач холбогдлын хувьд тодорхой хэв шинж, зөрүү, давуу тал болон сул талууд ажиглагдаж байна.

Эдгээр судалгааны дийлэнх нь энэ төрлийн гэмт хэргийг эрх зүй, тэр дундаа эрүүгийн эрх зүйн үүднээс авч үзсэн нь нийт судалгааны бүтээлийн 60 гаруй хувийг эзэлж байна. Эрүүгийн эрх зүйн чиглэлд хийгдсэн судалгаанууд гол төлөв мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой үйлдлийг гэмт хэргийн бүрэлдэхүүн, ялын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт, эрх зүйн орчны хийдэл, олон улсын гэрээ конвенцын нийцлийн асуудлаар төвлөрчээ.

Өөрөөр хэлбэл, судалгааны ажлуудыг агуулгын хүрээгээр авч үзвэл, нийт судалгааны дийлэнх хувь буюу 60 орчим хувь нь эрх зүйн зохицуулалтын чиглэлд, 25 орчим хувь нь нийгмийн эрүүл мэнд ба сэтгэл зүйн чиглэлд, үлдсэн 15 орчим хувь нь бодлого, институцийн зохион байгуулалт болон менежментийн чиглэлээр гүйцэтгэсэн байна.

График №3. Суурь болон хэрэглээний судалгааны ажил (Эрдмийн цол, зэрэг)




График №4. Суурь болон хэрэглээний судалгааны ажил



Тухайлбал, Т.Райса (2014), С.Чинзориг (2004), М.Түмэннаст (2015) нарын бүтээлүүдэд Эрүүгийн хуулийн холбогдох заалтуудыг задлан шинжилж, хууль хэрэгжилтийн зөрчил, хариуцлагын ялгаа, шүүхийн практикт гарч буй зөрүү, нотолгооны эрх зүйн чиглэлийг тодорхойлсон байдаг. Эдгээр судалгааны онцлог нь эрх зүйн хүрээнд хийгдсэн анхны системчилсэн оролдлогууд бөгөөд мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийг хууль тогтоомжийн түвшинд сайжруулах үндэс болох онолын дүгнэлтүүдийг гаргасан боловч тэдгээрийн практик хэрэгжилтийн нотолгоо хязгаарлагдмал байна.

Хоёрдугаарт, нийгмийн эрүүл мэнд, сэтгэл зүйн чиглэлд хийгдсэн судалгааны тоо харьцангуй бага боловч, энэ хүрээнд хийгдсэн ажлууд илүү хүн төвтэй буюу хэрэглэгчийн зан төлөв, мэдлэг, хандлага, донтолтын шалтгаан, урьдчилан сэргийлэх боловсролын ач холбогдлыг судалсан байдаг.

Тухайлбал, 2019 онд АШУҮИС-д хийгдсэн судалгаанд өсвөр үе, залуучуудын дунд мансууруулах бодисын талаарх мэдлэг дутмаг, хандлага сөрөг, хэрэглээний эрсдэл нэмэгдэж буйг тогтоож, энэ нь сургалт, мэдээллийн ажлын хүрээ, орчны нөлөөлөлтэй шууд холбоотой гэж үзсэн байна. Мөн судлаач М.Жавхлантөгс (2015)-ийн судалгаанд хүүхэд, өсвөр үеийг мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн эрх зүйн орчны хийдэл, гэр бүлийн орчны сөрөг нөлөө, нийгмийн соёлын хүчин зүйлсийг онцолсон нь онол, практикийн аль алинд ач холбогдол бүхий судалгаа болжээ. Гэвч эдгээр судалгаануудын сул тал нь тэдгээрийн үр дүнг бодлого боловсруулах, хууль хэрэгжилттэй уялдуулан дүгнэх, системийн хэмжээнд үнэлэх оролдлого дутмаг байгаад оршино.

Гуравдугаарт, бодлого, институцийн зохион байгуулалт болон хяналт-шинжилгээний чиглэлд хийгдсэн судалгаанууд нь сүүлийн жилүүдэд эрс нэмэгдсэн хандлагатай байна. IRIM судалгааны хүрээлэнгийн (2018) “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих үндэсний хөтөлбөрт хийсэн дүн шинжилгээ” болон Дотоод хэргийн их сургуулийн (2016) судалгааны ажлуудад төрийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт,

байгууллагын уялдаа холбоо, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо, хүний нөөцийн болон техникийн чадавхын асуудлыг нэгдсэн байдлаар авч үзсэн байна.

Эдгээр бүтээлүүдийн онцлог нь хууль зүйн хүрээнээс хальж, бодлого, институцийн зохион байгуулалт, санхүү, хяналт-шинжилгээний хүрээнд үнэлэлт хийсэн явдал юм. Тэдгээр судалгаанууд нотолгоонд суурилсан арга зүйг хэрэглэхийг зорьсон боловч, дүн шинжилгээний гүнзгийрэлт, тоон өгөгдлийн баталгаажуулалт, үр нөлөөний хэмжүүрийн ашиглалт харьцангуй сул хэвээр байна.

Судалгааны арга зүйн хувьд авч үзвэл, нийт судалгааны ажлуудын дийлэнх нь баримт бичгийн шинжилгээ, харьцуулалт, задлан шинжлэх аргуудыг ашигласан байна. Харин чанарын болон тоон аргуудыг хослуулсан, статистик боловсруулалт хийсэн бүтээлүүд хязгаарлагдмал бөгөөд IRIM (2018), АШУҮИС (2019) зэрэг судалгаанд л SPSS программ, фокус бүлэг, асуумж, ярилцлагын арга хослуулсан жишээ байна. Дийлэнх бүтээлд судалгааны түүвэрлэлтийн үндэслэл сул, эмпирик өгөгдөл хязгаарлагдмал, үр дүнг ерөнхий дүгнэлтэд хэт дөхүүлсэн хандлага ажиглагдсан. Эрх зүйн чиглэлийн судалгаанууд ихэвчлэн онолын шинжилгээнд тулгуурласан бөгөөд практик ба эмпирик нотолгоо бага, харин нийгмийн эрүүл мэндийн чиглэлд хийсэн судалгаанууд социологийн шинжилгээний аргуудыг хэрэглэсэн ч тэдгээрийг эрх зүйн хэм хэмжээнд уялдуулан тайлбарлаагүй байна. Энэ нь судалгааны арга зүйн салбар хоорондын уялдаа сул, нэг чиглэлийн хүрээнд хязгаарлагдах хандлага байгааг илтгэнэ.

Өмнө хийгдсэн судалгааны ажлуудын нийтлэг хандлага нь энэ төрлийн гэмт хэргийг хууль сахиулах байгууллагын хүрээнд авч үзэх, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, хяналт-шинжилгээний механизмыг боловсронгуй болгоход чиглэж байсан бол, сүүлийн жилүүдэд асуудлыг илүү өргөн хүрээнд - нийгмийн эрүүл мэнд, боловсрол, сэтгэл зүй, бодлогын уялдаа холбооны түвшинд авч үзэх оролдлого нэмэгдэж байна.

Энэ нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг зөвхөн хуулийн хүрээнд биш, харин нийгмийн дархлаа, хүний хөгжлийн баталгааг хангах иж бүрэн бодлогоор авч үзэх шаардлага байгааг харуулж байна. Гэвч судалгааны дүнгээс харахад, сэргээн засах үйлчилгээ, нийгэмд дахиннэгтгэх үйл ажиллагааны үр нөлөөний судалгаа, хил дамнасан гэмт хэргийн сүлжээ, цахим орчны шинэ хэлбэрийн хэрэглээ, эдийн засгийн хүчин зүйлийн нөлөөлөл зэрэг чиглэлүүд бараг судлагдаагүй хэвээр байна.

Мөн судалгааны ажлуудын дүгнэлт, зөвлөмжүүд ижил төстэй агуулгатай, харилцан давхардах шинжтэй байх бөгөөд хууль, эрх зүйн орчныг сайжруулах, хяналт-шинжилгээний тогтолцоо бүрдүүлэх, мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх, олон нийтийн боловсрол, урьдчилан сэргийлэх ажлыг өргөжүүлэх хэрэгцээг онцолдог боловч эдгээрийг нотолгоонд тулгуурлан тоон үзүүлэлтээр баталгаажуулах, үр нөлөөг хэмжих хэмжүүр (KPI) тогтоох, бодлогын хэрэгжилтийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр үнэлэх оролдлого маш хомс байна.

Сүүлийн долоон жилд хийгдсэн судалгаануудын нийтлэг онцлог нь мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийг салбар хоорондын шинжтэй үзэх хандлага нэмэгдсэнд оршино. Өмнөх судалгаануудтай харьцуулахад бодлого, байгууллагын чадавх, олон улсын туршлагыг хамарсан өргөн хүрээтэй шинжилгээ хийгдэж эхэлжээ. Гэвч судалгааны цар хүрээ, өгөгдлийн чанар, нотолгооны гүнзгийрэлт хангалтгүй хэвээр байна.

Нөгөө талаар, судалгааны сэдвүүдийн төвлөрөл “хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа”, “эрүүгийн хуулийн зохицуулалт”, “өсвөр үеийн хэрэглээний шалтгаан” зэрэг тодорхой хүрээнд хязгаарлагдаж, харин сэргээн засах үйлчилгээ, нийгэмд дахин нэгтгэх, даралт, стресс, цахим орчны нөлөө, эдийн засгийн хүчин зүйл, нийгмийн дархлаа, урьдчилан сэргийлэх соёлын судалгаа зэрэг шинэ чиглэлүүд хангалттай судлагдаагүй байна.

Эдгээрт тулгуурлан дүгнэхэд, Монгол Улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт явдлын судалгааны ажил тодорхой суурьтай болж төлөвшиж байгаа хэдий ч, судалгааны чиглэл, арга зүй, нотолгооны гүнзгийрэлт, бодлогын уялдаа хангалтгүй, сайжруулах хэрэгцээ, шаардлага байсаар байна. Судалгааны ажлуудын ихэнх нь тодорхой институцийн хүрээнд хийгдсэн, хязгаарлагдмал хүрээтэй, өгөгдлийн баталгаажуулалт бага, нэгдсэн мэдээллийн сан ашиглаагүй, бодлогын түвшинд холбох механизм бүрэн хөгжөөгүй байна.

Цаашид энэ чиглэлээр гүйцэтгэх судалгаанд дараах асуудлуудыг тусгайлан анхаарах шаардлагатай гэж судалгааны багаас үзлээ. Үүнд:

- Эрэлт төвтэй судалгаа буюу хэрэглэгчийн нийгэм-сэтгэл зүйн сэдэл, соёл, орчны хүчин зүйл, цахим нөлөөллийн хандлагыг нарийвчлан судлах;
- Сэргээн засах, нийгэмд дахин нэгтгэх үйлчилгээний үр нөлөөг шинжлэх ухааны үндэстэйгээр үнэлэх;
- Хил дамнасан болон зохион байгуулалттай гэмт хэргийн бүтэц, мэдээллийн технологийн хэрэглээ, шинэ төрлийн синтетик бодисын урсгал зэрэг сэдвийг гүнзгийрүүлэн судлах;
- Нотолгоонд суурилсан бодлогын судалгааны арга зүйг хөгжүүлж, бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээг KPI-тэй уялдуулах;
- Нийгмийн урьдчилан сэргийлэх боловсрол, соёлын хандлагын үр нөлөөг системтэй үнэлэх.

Дээрх судалгааны чиглэлүүдийг хөгжүүлснээр Монгол Улсад энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, хөтөлбөрийг шинжлэх ухаанд суурилсан, нотолгоотой, олон салбарын оролцоотой байдлаар хэрэгжүүлэх боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Мөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт явдлын судалгааны өнөөгийн түвшин нь тодорхой хэмжээний онол, арга зүйн үндэстэй болж төлөвшсөн боловч, эмпирик өгөгдлийн суурь сул, нийгмийн эрүүл мэнд, боловсрол, сэтгэл зүйн чиглэлээр хийгдсэн судалгаа хомс, бодлогын түвшний дүн шинжилгээ хангалтгүй байна. Иймд цаашид энэ төрлийн гэмт хэргийг судлахдаа хууль эрх зүй-нийгмийн эрүүл мэнд-сэтгэл зүй-бодлого,

институцийн уялдааг хослуулсан цогц судалгааны арга зүйг хөгжүүлж, нотолгоонд тулгуурласан бодлогын судалгаа руу шилжих шаардлагатай байна. Ийм чиглэлд хийгдэх цаашдын судалгаа нь мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийг зөвхөн хууль сахиулах хүрээнээс бус, нийгмийн дархлаа, хүний хөгжил, үндэсний аюулгүй байдлын хүрээнд шинжлэх ухааны үндэслэлтэйгээр ойлгох боломжийг нээж өгөх боломжтой.

Мөн суурь болон хавсарга судалгааны ажлууд эрдэм шинжилгээний ажлуудын бүтээлийн жагсаалтад орсон боловч тухайн бүтээлтэй танилцах нөхцөл боломж, эх сурвалжийн нээлттэй байдал хангалтгүй, байсныг судалгааны тайланд дурдах нь зүйтэй гэж үзлээ.

3.2. Гарын авлага, сурах бичиг, нэг сэдэвт бүтээлд хийсэн судалгааны үр дүн

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт явдлын чиглэлээр 2018 оноос хойш сэдэвт бүтээл 1, гарын авлага 3-ыг тус тус боловсруулсан байна.

Үүнээс Монгол Улсад мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлт, хэрэглээ, түүнтэй холбоотой гэмт хэрэг, зөрчил нэмэгдэхийн хэрээр энэ асуудалд чиглэсэн хууль, бодлого, судалгааны ач холбогдолтойг нэг сэдэвт бүтээл, гарын авлага боловсруулсан эрдэмтэн судлаачид бүтээлээ туурвисан байна.

Доктор Ж.Мөнхболдын “Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэх асуудал” нэг сэдэвт бүтээлд Монгол Улсын бодлого, эрүүгийн эрх зүйн орчин, ялын бодлого, хэрэгжилтийн асуудлыг судлахаас гадна ОХУ, АНУ, БНХАУ-ын туршлагыг харьцуулан дүн шинжилгээ хийсэн нь онол-практикийн өндөр ач холбогдолтой юм. Судалгаанд мансууруулах бодистой тэмцэх бодлогын хэрэгжилт, эрүүгийн эрх зүйн зохицуулалт, ялын бодлого, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны онцлогийг харьцуулж, гадаад туршлагаас манай улсад хэрэгжүүлж болох чиг хандлагыг тодорхойлжээ.

ХЗДХЯ, ГХУССАЗЗ-ийн “Мансууруулах эм, бодис хэрэглэсэн хүнийг таньж илрүүлэх, шаардлагатай арга хэмжээ авах, мэдлэг олгох сургалтын гарын авлага”, “Мансууруулах эм, бодис хэрэглэсэн хүнийг таних, илрүүлэх, шаардлагатай арга хэмжээ авах, мансууруулах бодис таньж ялгах мэдлэг олгох сургалтын гарын авлага”, “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөл” авлагууд нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай ерөнхий ойлголт, хэрэглээний хор уршиг, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хэрэглэгчийг илрүүлэх арга зүйг боловсруулсан байна. Эдгээр гарын авлага нь хууль сахиулах байгууллагын ажилтнууд болон олон нийтэд чиглэсэн мэдлэг олгох, урьдчилан сэргийлэх боловсролыг бэхжүүлэх зорилготой бөгөөд практик ач холбогдол өндөртэй бүтээл болсон.

МУДШ, УЕПГ, Азийн сангийн хамтран боловсруулсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа” гарын авлага нь эрүүгийн шүүх ажиллагааны шат бүрийг онол, хууль зүйн болон практикийн түвшинд судалж, мөрдөн шалгах ажиллагааны онцлог, прокурорын хяналт, шүүхийн нотолгооны үнэлгээ зэрэг асуудлыг гүнзгий авч үзсэн онол, практикийн өндөр ач холбогдолтой цогц бүтээл болсон байна.

Судалгаанд хамрагдсан бүтээлүүд нь мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэх бодлого, эрх зүйн орчныг онол, хууль зүйн болон практикийн түвшинд тодорхойлж, Монгол Улсад хэрэгжүүлэх шаардлагатай бодлогын чиглэл, олон улсын туршлагын харьцуулалт, шүүхийн практикийн арга зүйг боловсруулсан ач холбогдол бүхий судалгаанууд юм.

Гэвч судалгааны цар хүрээ, арга зүй, нийгмийн болон сэтгэл зүйн хэмжээсийг хангалттай хамраагүй учир, цаашид бодит тоон судалгаа, кейс шинжилгээ, эмпирик мэдээлэлд суурилсан бодлого боловсруулах шаардлагатай

байна. Ийнхүү эрх зүйн зохицуулалт, урьдчилан сэргийлэх боловсрол, эмчилгээ-сэргээн засах үйлчилгээний уялдаа холбоог сайжруулах нь Монгол Улсын хэмжээнд мансууруулах бодистой тэмцэх бодлогын үр нөлөөг бодитоор нэмэгдүүлэх үндэс суурь болох юм.

Гэсэн хэдий ч дээрх нэг сэдэвт бүтээл, гарын авлагад хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх цогц бодлогыг бүрэн хэмжээнд судалж чадаагүй бөгөөд дараах чиглэлийн хүрээнд гүнзгийрүүлэн судлах хэрэгцээ шаардлага байна гэж дүгнэлээ. Үүнд:

1. Урьдчилан сэргийлэх бодлогын талаар;
2. Хууль тогтоомжийн хэрэгжилт, шүүхийн практикийн талаар;
3. Байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагааны талаар;
4. Тухайн төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эдийн засаг, нийгмийн хүчин зүйлийн нөлөөллийн талаар иж бүрэн цогц судалгаа гэж үзлээ.

3.3. Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэлд хийсэн судалгааны үр дүн

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт явдлын чиглэлээр эрдэм шинжилгээний илтгэл 54, өгүүлэл 17, нийт 71 судалгааны ажил хийгдсэн байна. Тодруулбал, 2018 онд ХЗДХЯ, ЦЕГ, ДХИС-ын хамтран зохион байгуулсан Хар тамхины гэмт явдал, шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам” эрдэм шинжилгээний хуралд 22, ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газрын 25 жилийн ойг угтан зохион байгуулсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэхэд байгууллагуудын хамтын ажиллагаа” эрдэм шинжилгээний хуралд 32 эрдэм шинжилгээний илтгэл ирүүлснийг “Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл” болгон 350 ширхгийг хэвлүүлсэн байна.

Тус сэдвээр Монгол Улсын Шинжлэх ухааны академийн захирлын 2022 оны А/14 дугаартай тушаалаар баталсан “Дотоодын эрдэм шинжилгээний мэргэжлийн сэтгүүлийн жагсаалт”-д заасан онол, арга зүйн сэтгүүлд бичигдсэн, эрдэм шинжилгээний өгүүллийг судлахад “Хууль сахиулахуй”, “Тусгаар тогтнол”, “Хууль дээдлэх ёс”, “Монголын төр, эрх зүй” сэтгүүлүүдэд 2018 оноос хойш 17 эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлэгдсэн байна.

График №5. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт явдлын талаар судлагдсан эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлэгдсэн сэтгүүлийг харуулав.






График №6. Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллийн судлагдсан байдлын тоймыг бүлэглэн харуулав.



Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт явдлын талаар эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллийн судалсан байдал нь 40(56%) нь холимог байдлаар, хэт олон сэдвийг хөндөж судалсан, дүгнэлт, дэвшүүлсэн санал нь судалгаа, түүний үр дүнд нийцээгүй, өргөн хүрээнд тунхгийн шинж чанартай дэвшүүлсэн байна.

График №7. Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл нийтлэн судлаачдын эрдмийн зэрэг, цолыг харуулав.




Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллийн 18 хувийг доктор, 30 хувийг магистр цолтой, үлдсэн хувийг эрдмийн зэрэг, цолгүй судлаачид бичиж, нийтлүүлсэн байна.

График №8. Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл нийтлэн судлаачдын ажил эрхлэлтийн байдлыг харуулав.




Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл нийтлэн судлаачдын 42 хувь нь эрдэмтэн, багш, 16 хувь нь цагдаагийн алба хаагч, 16 хувь нь төрийн албан хаагч, 5.6 хувь нь прокурор, 1.4 хувь нь шүүгч албан тушаалтай байна.

График №9. Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл нийтлэн судлаачдын бичилтийн хэлбэрийг харуулав.



Дээрх судлаачдын 77 хувь нь ганцаар, 33 хувь нь хамтран, 2 хувь нь эрдэмтэн судлаачдаар удирдуулан эрдэм шинжилгээний илтгэл нийтэлсэн байна.

График №10. Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн харьцааг харуулав.



Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллийн хоорондын харьцааг харуулахад 76 хувь нь сүүлийн 8 жилд зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний хуралд, 24 хувь нь дотоодын хянан магадалгаа бүхий сэтгүүлд нийтлэгдсэн байна.

Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг, урьдчилан сэргийлэлт, хууль эрх зүйн орчин, байгууллагын уялдаа холбоо, эдийн засгийн болон сэтгэл зүйн нөлөө гэх мэт олон өнцгийг эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллийн судалсан ч зарим чиглэлүүд дутуу буюу хангалтгүй судлагдсан байна. Тодруулбал,

- Судалгааны арга зүйг тоон судалгааг 1-3 жилийн байдлаар статистик байдлаар хязгаарлагдмал ашигласан, чанарын судалгаа хийгдээгүй, түүнд дүн шинжилгээ хийгээгүй.

- Эрх зүйн зохицуулалтыг Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, Монгол Улсын нэгдэн орсон НҮБ-ын конвенцын хэрэгжилтийн байдлаар дурдах байдлаар судалсан. Түүнд тулгамдсан асуудлыг иж бүрэн байдлаар тодорхойлж дүгнэлт хийгдээгүй. Ялангуяа эрүүгийн эрх зүйн зохицуулалт, ялын бодлого, түүний үр нөлөөг судалсан судалгаа байхгүй.

- Олон улсын хамтын ажиллагааг бүс нутгийн хэмжээнд явуулах шаардлагатай талаар онцолсон боловч гүнзгийрүүлсэн судалгаа байхгүй,

- Монгол Улсад шинэ төрлийн синтетик бодисын хууль бус эргэлт өсөн нэмэгдэж байгаа талаар дурдсан ч түүнийг илрүүлэх, тухайн төрлийн бодисын онцлог, тэмцэх арга зүйн талаар дорвитой хийсэн судалгаа байхгүй


- Технологийн хурдацтай хөгжлийн Darknet, crypto-төлбөр, цахим наймааны урсгал зэрэг гэмт хэргийн үйлдлийн шинэ чиг хандлагуудын судалгаа хийгдээгүй.

Эрдэм шинжилгээний илтгэлийн зарим бүтээл шаардлага хангахгүй, танин мэдэхгүйн шинжтэй, эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд хавсаргах зорилгоор хэлбэрийн төдий бичилт хийгдсэн байсныг дурдах нь зүйтэй.

4.4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт явдлыг судалсан байдалд хийсэн дүн шинжилгээ

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус хэрэглээ, эргэлт, түүнтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал нэмэгдэхийн хэрээр энэхүү үзэгдэлтэй тэмцэх бодлого, эрх зүйн зохицуулалт, практикийн арга зүйг судлах, боловсронгуй болгох шаардлага улам бүр нэмэгдэж байгааг онцлон эрдэмтэн судлаачид, практик байгууллагын ажилтнууд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх талаар тодорхой судалгаануудыг хийж гүйцэтгэсэн байна.


График №11. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой судалгааны ажлын чиглэлийг дэлгэрэнгүй байдлаар харуулав



Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой судалгааны ажлын чиглэлийг харьцуулбал Эрх зүйн зохицуулалтын онцлог, хууль тогтоомжийн хэрэгжилтэд тулгамдсан асуудлыг судалсан 11, Урьдчилан сэргийлэх ажиллагаанд тулгамдсан асуудал, Олон улсын хамтын ажиллагаанд тулгамдсан асуудлыг судалсан тус бүр 7, энэ төрлийн гэмт хэргийн хууль бус эргэлтийг бүхий л талаас нь


хамаатуулан судалсан 32, судалгааны асуулгаас бусад байдлаар судалсан 19 бүтээл байгаа нь тухай чиглэлийн судалгааны ажлын тулгамдсан байдлыг “Эрх зүйн зохицуулалтын онцлог, олон улсын хамтын ажиллагаа, урьдчилан сэргийлэх асуудал” шууд тодорхойлж байна.

График №12. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой судалгааны ажил хийсэн хүмүүсийн эрдмийн зэрэг цолыг харуулав




Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой судалгааны ажил явуулсан судлаачдын 18 нь доктор зэрэгтэй, 23 хувь нь магистр зэрэгтэй буюу 41 хувь нь эрдмийн зэрэг цолтой судлаачид явуулсан байна.

График №14. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой судалгааг боловсруулсан байдлыг харуулав




Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой судалгааны ажлын 78 хувийг ганцаар, 22 хувийг хамтран боловсруулсан байна.

График №13. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой судалгааг явуулсан судлаачдын хөдөлмөр эрхлэлтийн байдлыг харуулав



Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой судалгааг явуулсан судлаачдын 31 хувь нь эрдэмтэн багш, 15 хувь нь судлаач, нийт 46 хувь нь эрдэмтэн, судлаачид боловсруулсан байна.



Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт явдлын судлагдсан байдалд 2018 оноос хойших докторын

судалгааны ажил 1, магистрын судалгааны ажил 4, суурь болон хэрэглээний судалгааны ажил 10, нэг сэдэвт бүтээл 1, гарын авлага 3, эрдэм шинжилгээний илтгэл 64, эрдэм шинжилгээний өгүүлэл 17 нэгтгэн судалж, тухайн бүтээлийн зорилго, зорилт, судалгааны арга зүй, ашигласан, эх сурвалж, тухайн сэдвийн тулгамдсан байдал, судалгааны үр дүн, дэвшүүлсэн санал, зөвлөмж зэргийг нэгтгэн, нэгдсэн боловсруулалт хийж, нийтлэг байдлаар дараах дүр дүнд хүрлээ. Үүнд:

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилт, үр нөлөөний талаар судалгаа хийгдээгүй тул хууль, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, үр нөлөөний хэмжилт, ашигласан төсвийн үр ашиг шинжилсэн судалгаа үгүйлэгдэж байна.

- Хэрэглэгчдийн нас, хүйсийн дүн гарсан боловч нийгмийн гарал, боловсрол, орлогын түвшин, гэр бүлийн орчин, нийгмийн сүлжээ, зан төлөвийн хэв маяг зэрэг социологийн гүнзгий судалгаа хийгдээгүй.

- Хар тамхи, мансууруулах бодисын цахим орчин дахь хууль бус эргэлт, түүний төлбөр тооцоо, гүйлгээний сүлжээ, хөрөнгийн урсгал, далд эдийн засагт үзүүлж байгаа нөлөө, түүнийг мөрдөн шалгах санхүүгийн мөрдлөгийн аргачлалын талаар судалгаа байхгүй

- Зөвийн энэ төрлийн гэмт хэргийн талаар судалгаа хийгдсэн ч давхар үйлдэгдэж, нэгтгэгдэн шалгагдаж байгаа хулгайлах, дээрэмдэх, залилах, мөнгө угаах зэрэг гэмт хэргийг хамаатуулсан судалгаа

- Цөөнгүй судалгаанд “Сэтгэлзүйн зөвлөгөө, эмчилгээ, сэргээх төв байгуулах шаардлагатай” гэж санал болгосон ч одоо байгаа сэргээн засах үйлчилгээний үр дүн, арга зүй, эмчилгээний үр ашгийг судалсан зүйл байхгүй.

- Конвенц, гэрээ, туршлагыг дурдаж, “хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай” гэж дурдсан ч Монгол Улс ба хөрш орнуудын хамтарсан мөрдөн шалгах ажиллагааны бодит үр дүн, мэдээлэл солилцооны механизмын бодит хэрэгжилт, тулгамдсан асуудал зэргийг огт судлагдаагүй.

- Урьдчилан сэргийлэх ажиллагааг нийгэм, соёлын орчны хандлага, хэвлэл мэдээллийн нөлөө, сэтгэл зүйн чиглэлээр хийгдсэн иж бүрэн судалгаа байхгүй байна.



ДҮГНЭЛТ, САНАЛ



Дүгнэлт

“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт явдлыг судалсан байдлын тойм” сэдэвт судалгааны ажлын хүрээнд хийсэн дүн шинжилгээ, судалгааны материалуудыг нэгтгэн үзэж дараах ерөнхий дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

1. Монгол Улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт явдлын судалгаа сүүлийн жилүүдэд эрчимжиж, онол, арга зүйн тодорхой суурь бүрэлдсэн хэдий ч, судалгааны хүрээ, арга зүйн уялдааг сайжруулах хэрэгцээ, шаардлага байсаар байна.

2. Судалгааны ажлуудын 60 орчим хувь нь эрх зүйн орчныг судлахад төвлөрч, хууль тогтоомжийн хийдэл, ял шийтгэлийн бодлого, хэрэгжилтийн үр нөлөөг судалсан байна. Гэвч эдгээр судалгаанд эмпирик нотолгоо, бодит тоон өгөгдөл, практик жишээнд тулгуурласан дүн шинжилгээ сул байна.

3. Нийгмийн эрүүл мэнд, сэтгэл зүй, соёлын хүчин зүйлсийн талаарх судалгаа харьцангуй бага хувь эзэлж байгаа бөгөөд хэрэглээний шалтгаан, сэтгэл зүйн хандлага, гэр бүлийн орчны нөлөөллийг нарийвчлан судалсан бүтээл хязгаарлагдмал байна. Энэ нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт явдлыг зөвхөн эрх зүйн хүрээнд бус, хүн төвтэй, сэтгэл зүйн болон нийгмийн шалтгаант өнцгөөс системтэйгээр судлах шаардлагатайг харуулж байна.

4. Бодлого, институцийн зохион байгуулалтын чиглэлд хийгдсэн судалгаанууд нь нэгдмэл бодлого, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцооны дутагдал, мэдээллийн нэгдсэн сангийн хомсдол, салбар хоорондын уялдаа сул байгааг ил тод харуулсан ч эдгээрийн үр нөлөөг хэмжих систем (KPI, үнэлгээний шалгуур, гүйцэтгэлийн үзүүлэлт) хөгжөөгүй байна.

5. Судалгааны арга зүйн хувьд баримт бичгийн шинжилгээ, харьцуулалт, задлан шинжлэх аргууд давамгайлж, чанарын болон тоон аргуудыг хослуулсан судалгаа цөөн байна. Судалгааны түүвэрлэлт, өгөгдлийн хэмжээ, дүн шинжилгээний гүнзгийрэлт нь олон улсын академик стандартад хүрэхүйц түвшинд хүрээгүй байна.

6. Судалгааны ажлуудын онцлог нь эрх зүй, нийгмийн эрүүл мэнд, бодлого, сэтгэл зүй зэрэг олон чиглэлд тархсан боловч уялдаа холбоо сул, нэг чиглэл давамгайлсан, салбар хоорондын интеграц хангалтгүй байна.

7. Судалгааны дүнгээс үзэхэд, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг нь зөвхөн хууль, эрх зүйн зүйн асуудал бус, нийгмийн эрүүл мэнд, боловсрол, соёл, эдийн засгийн орчны цогц нөлөөлөл бүхий нийгмийн аюулын илрэл болж байна.

8. Судалгааны дүгнэлт, зөвлөмжүүдийн агуулга давхцах хандлагатай бөгөөд эрх зүйн орчныг сайжруулах, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, олон нийтийн боловсролыг өргөжүүлэх шаардлагыг давтан онцолсон хэдий ч, эдгээр

дүгнэлт, зөвлөмжийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хэрэгжүүлэх арга зам, хэрэгжилтийн механизмыг тодорхойлоогүй байна.

9. Судалгааны хоосон орон зай нь дараах чиглэлд илэрч байна. Үүнд: хэрэглэгчийн зан төлөв ба эрэлт төвтэй судалгаа, сэргээн засах ба нийгэмд дахин нэгтгэх үйлчилгээний үр нөлөө, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн бүтэц, синтетик бодисын урсгал, цахим орчны шинэ хэлбэрийн хэрэглээ, бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээний шинжлэх ухааны арга зүй зэрэг чиглэл орхигдож байна.

10. Монгол Улсад энэ төрлийн гэмт хэргийг судлах, түүнтэй тэмцэх үйл ажиллагаанд шинжлэх ухааны нотолгоонд тулгуурласан, олон салбарын уялдаатай, бодит, өргөн хүрээг хамарсан өгөгдөлд суурилсан судалгааны тогтолцоо бүрдүүлэх шаардлага үүссэн байна.

Санал

1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг зөвхөн хууль зүйн үүднээс бус, нийгмийн эрүүл мэнд, сэтгэл зүй, соёл, боловсрол, эдийн засгийн уялдаатай байдлаар судлах “олон талын интеграцчилсан судалгааны тогтолцоо” бүрдүүлэх.
2. Судалгааны үр дүнг тоон ба чанарын өгөгдөлд тулгуурлан, статистик, эмпирик шинжилгээний үндэслэлтэйгээр боловсруулж, бодлогын зөвлөмжийг нотолгоонд тулгуурласан хэлбэрт шилжүүлэх.
3. “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг KPI буюу гүйцэтгэлийн гол үзүүлэлтэд тулгуурлан үнэлэх, хяналт-шинжилгээний нэгдсэн системийг хөгжүүлэх.
4. Донтогчдыг эмчлэх, сэргээн засах, нийгэмд дахин нэгтгэх үйлчилгээний үр нөлөө, үр ашиг, тогтолцооны сул тал, хүний нөөцийн чадавхыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлах.
5. Цахим орчны нөлөөлөл, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын худалдаа, хэрэглээний шинэ сувгууд, синтетик бодисын тархалтын онцлогийг технологийн судалгааны үүднээс шинжилж, урьдчилан сэргийлэх цахим бодлогыг боловсруулах.
6. Өсвөр үе, залуучуудын дунд хандлагын судалгаа хийж, урьдчилан сэргийлэх боловсролын хөтөлбөрийн үр нөлөөг шинжлэх ухааны аргаар үнэлэх, олон нийтийн боловсрол, соён гэгээрүүлэх ажлыг стратегийн хэмжээнд өргөжүүлэх.
7. Олон улсын хэмжээнд, үндэстэн дамнасан, зохион байгуулалттай үйлдэгдэж буй гэмт хэргийн сүлжээ, дамжин нэвтрэх суваг, хил гаалийн хяналтын үр нөлөө, мэдээлэл солилцооны механизмын талаар тусгай судалгаа хийх.
8. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн мэдээллийг цагдаа, шүүх, эрүүл мэнд, боловсролын байгууллагуудын хооронд уялдуулсан цахим мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо бий болгох.
9. Их, дээд сургууль, төрийн байгууллага, судалгааны хүрээлэн, олон улсын байгууллагуудын хамтарсан эрдэм шинжилгээний хөтөлбөр, хамтарсан өгөгдлийн сүлжээг хөгжүүлэх, олон төрөл салбарын мэргэжилтнүүдээс бүрдсэн судалгааны багаар цогц судалгааны ажил гүйцэтгүүлэх.
10. Эрүүгийн болон Зөрчлийн хуулийн холбогдох заалтуудыг олон улсын конвенцын шаардлагатай нийцүүлэн шинэчлэх, хариуцлагын ялгаа, тодорхой бус заалтуудыг нарийвчлан судлах.
11. Хууль сахиулах, эмнэлгийн, боловсролын, судалгааны байгууллагын ажилтнуудын ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэргэшлийн сургалтыг тогтмолжуулж, судалгаанд суурилсан шийдвэр гаргах чадварыг нэмэгдүүлэх.

12.Иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийн оролцоог нэмэгдүүлж, урьдчилан сэргийлэх ажлыг нийгмийн хөдөлгөөн хэлбэрт шилжүүлэх.

13.Ядуурал, ажилгүйдэл, орлогын ялгарал зэрэг эдийн засгийн хүчин зүйл мансууруулах бодисын хэрэглээ, гэмт хэрэгт үзүүлэх нөлөөг тодорхойлох нарийвчилсан судалгааны ажил гүйцэтгэх.

14. Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлэх, судалгааны үр дүнг бодлого боловсруулахад ашиглах зорилготой үндэсний хэмжээний судалгааны төвийг байгуулах.

15.UNODC, WHO, Interpol зэрэг байгууллагын зөвлөмж, сайн туршлагыг Монгол Улсын хууль, бодлого, хөтөлбөрт нийцүүлэн нутагшуулах, харьцуулсан судалгааг тогтмолжуулах.

16.ХЗДХЯ, түүний харьяа байгууллагууд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдсан асуудлын жагсаалтыг эрэмбэлэн боловсруулж, ДХИС-ын магистр, докторын болон захиалгат судалгааны ажлын жагсаалтад оруулах зохион байгуулалтын арга хэмжээ авах.

17.Энэ төрлийн гэмт хэргийн үйлдлийн шинэ арга, хэлбэрт нийцүүлэн цахим орчинд мөрдөн шалгах ажиллагаа, санхүүгийн мөрдлөг явуулах чиглэлээр аргачилсан заавар, зөвлөмж боловсруулах.

18. Хууль сахиулах байгууллага, прокурор, шүүхийн байгууллага, тэдгээрийн дэргэдэх эрдэм шинжилгээний хүрээлэн төвийн оролцоотой Монгол Улсын нэгдэн орсон энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын гэрээ, хэлэлцээрийн нэмэлт өөрчлөлтийг тайлбарлах, хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах.

**“МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТ”-
ТЭЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ЯВДЛЫГ СУДАЛСАН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ,
СУДАЛГААНЫ СУДАЛГААНЫ ЖАГСААЛТ**

№	Зохиогч	Бүтээлийн нэр	Тайлбар	Он
Докторын зэрэг горилсон бүтээл				
1.	Ж.Болдбаатар	“Хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар борлуулах гэмт хэргийн нотолгооны асуудал”	Хууль зүйн доктор зэрэг горилсон бүтээл	2003
2.	Р.Мөнхцэцэг	Хорт хавдрын болон мансууруулах хүчтэй өвчин намдаагч эмийн бэлдмэлүүдийн Монгол дахь зах зээлийн судалгаа	АШУҮИС	2005
3.	Ж.Мөнхболд	“Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, эм бэлдмэлийг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах гэмт хэргийн эрүүгийн эрх зүй, криминологийн асуудал”	Хууль зүйн доктор зэрэг горилсон бүтээл	2008
4.	Ш.Лхагвасүрэн	Монголын өсвөр үеийнхнийг хар тамхи, мансууруулах бодис хэрэглэхээс урьдчилан сэргийлэх ажлын агуулга, арга зүй	МУБИС	2009
5.	Б.Алтансүх	Хар тамхины гэмт явдалтай тэмцэж буй талаарх Монгол Улс, БНХАУ-ын харьцуулсан судалгаа	БНХАУ-ын Бээжингийн их сургууль	2018
6.	Б.Эрдэнэдалай	Хар тамхитай тэмцэх байгууллагын үйл ажиллагааны хяналтад хийсэн дүн шинжилгээ	ДХИС	2023
Магистрын зэрэг горилсон бүтээл				

7.	Б.Батмөнх	“Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар борлуулах гэмт хэргийг мөрдөн байцаах ажиллагаа”	Магистрын зэрэг хамгаалсан бүтээл	2002
8.	Г.Баттулга	“Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгт хамаарах хууль тогтоомжийг боловсронгуй болгох зарим асуудлууд”	Магистрын зэрэг хамгаалсан бүтээл	2004
9.	С.Чинзориг	Мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх зарим асуудал	Отгонтэнгэр их сургууль	2004
10.	М.Хүрэл-Эрдэнэ	“Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой мэдээллийг цагдаагийн байгууллагын хэв журмын албанаас шалгах ажиллагаа”	Магистрын зэрэг хамгаалсан бүтээл	2005
11.	С.Наранцэцэг	“Мансууруулах бодисоор бизнес хийх гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн болон криминологийн зарим асуудал”	Магистрын зэрэг хамгаалсан бүтээл	2005
12.	Ц.Мөнхцэцэг	Зэрлэг олс /Cannabis ruderalis/ ургамлын каннабиноидын бүрдэл	МУИС	2005
13.	Д.Долгорсүрэн	“Мансууруулах бодис хууль бусаар борлуулах гэмт хэрэг түүний эрүүгийн эрх зүйн болон криминологийн асуудал”	Магистрын зэрэг хамгаалсан бүтээл	2007
14.	Д.Долгорсүрэн	Мансууруулах бодис хууль бусаар борлуулах гэмт хэрэг түүний эрх зүйн болон криминологийн асуудал	МУИС	2007
15.	П.Өлзийсайхан	“Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодисыг борлуулахтай	Магистрын зэрэг хамгаалсан бүтээл	2008

		холбоотой гэмт хэргийг мөрдөн байцаах арга зүй”		
16.	Ж.Энхтөр	Донтох эмгэгээс урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх нийгмийн ажил	МУИС	2008
17.	Р.Баярмагнай	“Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар борлуулах гэмт хэргийг гүйцэтгэх тагнуулын ажлаар илрүүлэх ажиллагаа”	Магистрын зэрэг хамгаалсан бүтээл	2009
18.	Д.Наранбаатар	“Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар борлуулах гэмт хэргийг нотлох ажиллагаа”	Магистрын зэрэг хамгаалсан бүтээл	2010
19.	М.Ундармаа	“Хар тамхи, мансууруулах бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн болон криминологийн зарим асуудал”	Магистрын зэрэг хамгаалсан бүтээл	2010
20.	М.Ундармаа	Хар тамхи мансууруулах бодисыг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн болон криминологийн зарим асуудал	МУИС, ОУХНУС	2010
21.	А.Батсүх	“Мансууруулах бодис хууль бусаар борлуулах гэмт хэрэг түүний криминологийн асуудал”	Магистрын зэрэг хамгаалсан бүтээл	2010
22.	С.Хаш-Эрдэнэ	“Мансууруулах бодис агуулсан ургамлыг тарих, ургуулах, хурааж авах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж”	Магистрын зэрэг хамгаалсан бүтээл	2011
23.	Ч.Энх-Амгалан	“Хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар Монгол улсын хил нэвтрүүлэх гэмт хэргийн	Магистрын зэрэг хамгаалсан бүтээл	2011

		эрүүгийн болон криминологийн асуудал”		
24.	С.Отгонцэцэг	“Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг борлуулах гэмт хэргийг илрүүлэх ажиллагааны зарим асуудал”	Магистрын зэрэг хамгаалсан бүтээл	2012
25.	Г.Ганцэцэг	ЭМШИС-ийн оюутнуудын ХДХВ/ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага болон мансууруулах бодис, антибиотикийн хэрэглээ, хандлага Нийгмийн эрүүл мэнд	Олон Улсын Улаанбаатарын их сургууль	2012
26.	Б.Энхтуул	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих нь	ШУТИС	2012
27.	Д.Золзаяа	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг илрүүлэх хийн хроматографи ба масс спектрийн судалгаа	АШУУИС	2013
28.	Н.Мөнхзул	Хар тамхи болон сэтгэцэд нөлөөт эм бэлдмэлд тавих гаалийн хяналтыг боловсронгуй болгох арга зам Гадаад худалдаа гаалийн удирдлага	МУИС	2013
29.	Д.Идэрбаяр	Хил гаалийн байгууллагаас мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисыг илрүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт	Шихихутуг их сургууль	2013
30.	Б.Алтангэрэл	Хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар Монгол улсын хил нэвтрүүлэх гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн болон криминологийн зарим асуудал	Үндэсний батлах хамгаалахын их сургууль	2014
31.	Т.Райса	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл бодисын хууль бус эргэлтийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт,	Отгонтэнгэр их сургууль	2014

		түүнийг боловсронгуй болгох зарим асуудал		
32.	М.Жавхланөгс	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодсын хор хөнөөлөөс хүүхдийг урьдчилан сэргийлэх, түүний эрх зүйн зохицуулалтын зарим асуудал	Монголын Үндэсний дээд сургууль	2015
33.	М.Түмэннаст	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэргийг нотлох ажиллагааны онол, практикийн зарим асуудал	Отгонтэнгэр их сургууль	2015
34.	Б.Уранчимэг	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах гэмт хэргийн эрүүгийн эрх зүй, криминологийн зарим асуудал	Их засаг их сургууль	2015
35.	Б.Тулга	Хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэргийн криминологи шинж	Үндэсний батлах хамгаалахын их сургууль	2016
36.	А.Амарсанаа	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис, түүнтэй тэмцэж буй олон улсын жишиг	Монголын Үндэсний дээд сургууль	2016
37.	Э.Ариунзаяа	Монгол Улсын нийгмийн аюулгүй байдалд нөлөөлөх гадаад хүчин зүйлс. Хар тамхины жишээн дээр	МУИС	2016
38.	Абдулали Мегдади	Афганистан-Төв азийн харилцаа. Маш хол, маш ойрхон Олон улсын харилцааны магистрын зэрэг горилсон судалгааны ажил	МУИС	2016
39.	Б.Байгалмаа	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис,	АШУУИС	2017

		эм бэлдмэлтэй холбоотой гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, түүнийг боловсронгуй болгох арга зам		
40.	Л.Мэндсайхан	Хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт, зүйлчлэлийн асуудал	МУИС	2017
41.	Б.Нямжигжид	Хар тамхи мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэж буй хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдсан асуудал	Шихихутуг их сургууль	2017
42.	Э.Шинэ-Уянга	Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар ашиглах гэмт явдлын криминологи асуудал	Олон Улсын Улаанбаатарын их сургууль	2018
43.	С.Оюунбат	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, түүнийг боловсронгуй болгох арга зам	Шихихутуг их сургууль	2019
44.	Л.Баянболд	Мансууруулах эм болон сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн эрүүгийн хариуцлагын үндсэн асуудал	Отгонтэнгэр их сургууль	2021
45.	Э.Мөнхболд	“Мөнгө угаах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, зүйлчлэлийн тулгамдсан асуудал”	МУИС	2022
46.	Энх-амгалан	Хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар Монгол улсын хил нэвтрүүлэх гэмт хэргийн эрүүгийн болон криминологийн асуудал	Их засаг их сургууль	-

47.	О.Очирхуяг	Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах буюу хордуулах, цацраг идэвхт, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар монгол улсын хил нэвтрүүлэх гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал	Их засаг их сургууль	-
48.	Н.Барс-Од	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зам	Их засаг их сургууль	-
49.	Б.Нямбаяр	Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус хэрэглээ, түүний эрх зүйн зохицуулалт, тулгамдсан асуудал	Их засаг их сургууль	-
50.	С.Хаш-эрдэнэ	Мансууруулах бодис агуулсан ургамлыг тарих, ургуулах, хурааж авах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж, онцлог	Их засаг их сургууль	-
51.	Г.Ариунаа	Насанд хүрээгүй хүнийг согтуурал, мансуурал, биеэ үнэлэх, тэнүүчлэл, гуйланчлалд татан оруулах гэмт хэрэг, түүний криминологийн асуудал	Их засаг их сургууль	-
52.	П.Эрдэнэцэцэг	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх криминологийн асуудал	Их засаг их сургууль	-
53.	А.Банзрагч	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг олж авах, борлуулах гэмт хэргийг	Их засаг их сургууль	-

		илрүүлэх ажиллагааны зарим асуудал		
54.	Ц.Мөнхтуяа	Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэж буй олон улсын эрх зүйн орчин, чиг хандлага	Их засаг их сургууль	-
Суурь болон хавсарга судалгааны ажил				
55.	АШУУИС	Улаанбаатар хотын хүн амын дунд хар тамхи, мансууруулах бодис, архинд донтох өвчний тархалт, эрт илрүүлэлт, оновчтой эмчилгээ		2000-2003
56.	Судалгааны ажлуудыг нэгтгэсэн тайлан	Донтох эмгэгтэй хүмүүсийн тархалт		2019
57.	АШУУИС	Архи, тамхи, мансууруулах сэтгэцэд нөлөөт эм, бодист донтогсдын эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаарх хууль эрх зүйн судалгааны тайлан		2010
58.	НГХУСАЗЗ	Нийслэлийн өсвөр үе, залуучуудын дундах мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл, бодисын хэрэглээ, ойлголтын талаарх тандалт, судалгааны тайлан		2010
59.	ЗГХА-ЭМГ, НЭМГ, СЭМҮТ, ХТМБИХН	Мансууруулах болон сэтгэц идэвхт эм, бодис, хэрэглэгчдийн хэрэглээ, тэдний мэдлэг, хандлага, хор уршгийн талаарх сандалт судалгаа		2012
60.	ХЗҮХ	Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, түүнтэй тэмцэх асуудал		2013
61.	ХЗҮХ	“Донтох өвчнөөр өвчлөгсдөд ногдуулах		2013

		захиргааны арга хэмжээ бусад орны туршлага-лавлагаа”		
62.	ХЭҮК, Нийслэлийн шүүх, Хүний аюулгүй байдлын судалгааны төв ТББ,	Монгол Улс дахь мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэрэгт ногдуулж буй ял шийтгэл, тулгамдаж буй асуудал		2013
63.	ХЗҮХ	Мөрдөх алба, гадаадын зарим орны туршлага		2013
64.	ХЗҮХ	Мансууруулах эмийн ба сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэх талаарх олон улсын стандарт		2014-2015
65.	ХЗҮХ	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн нөхцөл байдал		2016-2017
66.	ДХИС	Хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал, судалгааны тайлан		2016
67.	ХЗҮХ	“Цахим орчин дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох эрх зүйн зохицуулалт /Харьцуулсан судалгаа/”		2018
68.	МУИС	Гэмт хэрэг, зөрчил, урьдчилан сэргийлэх ажлын талаарх хүн амын ойлголт, хандлага Судалгааны тайлан		2018
69.	Independent research institute of Mongolia - IRIM судалгааны хүрээлэн	“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих Үндэсний хөтөлбөрт хийсэн дүн шинжилгээ”		2018
70.	Этүгэн их сургууль	Мансууруулах бодисын талаарх мэдлэг, хандлагыг оюутнуудын дунд тодорхойлсон судалгаа		2019

71.	Эс Ай Си Эй (SICA) ХХК	“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн дунд хугацааны үнэлгээ”		2020 он
72.	Эс Ай Си Эй (SICA) ХХК	“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ”		2023 он
73.	Хууль зүй, дотоод хэргийн яам	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ		2023
74.	ГХУСАЗЗ, “Түгээмэл эрх, эрх зүйн боловсрол” НҮТББ	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх донтой этгээд дахин хэрэглэхэд нөлөөлж буй хүчин зүйлийг тогтоох, дүн шинжилгээ хийх судалгааны тайлан		2024
75.	Нийгэм эдийн засгийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх сургалт, судалгааны хүрээлэн НҮТББ	“Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч нарын дунд дахь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийн талаарх мэдлэг, ойлголт болон тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид үнэлгээ, дүн шинжилгээ хийх судалгааны тайлан”		2024
76.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба	“Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном – 2023” бүтээл.		2024
77.	“Имижлоги” сургалт судалгааны төв	“Иргэдийн дунд дахь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор		2024

	НҮТББ	уршгийн талаарх мэдлэг, ойлголт болон далд хэрэглээг тогтоох судалгааны тайлан”		
78.	ЭМЯ, Сэтгэцийн эрүүл мэндийн төв	“Монгол Улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэх мэдээллийн санг бүрдүүлж холбогдох байгууллагуудын нэгдсэн сүлжээг үүсгэх” эрүүл мэндийн дэмжих сангийн санхүүжилттэй судалгаа		2024
79.	ХЭҮК	ДОХ ба мансууруулах бодисын хэрэглээ, нөхцөл байдлыг оролцооны аргаар үнэлсэн судалгаа		-
Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл				
80.	ХЗДХЯ, ОХУ-ын МБЭХТ холбоо	Хар тамхины эргэлтэд хяналт ба хамтын ажиллагаа		2007
81.	Т.Дамбийням, Б.Аадарсүх	“Таны амьдрал мансууралгүй орчин” онол практикийн бага хурлын эмхэтгэл		2010
82.	Б.Мөнхсэргэлэн, О.Уулзахжаргал, М.Эрдэнэбаяр	Хар тамхины гэмт явдал: шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам	ДХИС	2018
83.	С.Гантулга, П.Сандагсүрэн, Д.Энхтөр, Э.Хандармаа	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэхэд байгууллагуудын хамтын ажиллагаа	ДХИС	2025
Нэг сэдэвт зохиол, хамтын бүтээл, ном, сурах бичиг, гарын авлага				
84.	Ш.Цогтоо, Б.Туул	Хар тамхи эрх зүйн зохицуулалт		2000
85.	Ж.Болдбаатар	Хар тамхи, мансууруулах бодистой холбогдсон гэмт		2001

		хэргийн эрүүгийн эрх зүйн болон криминологийн шинж		
86.	Ж.Болдбаатар	Хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй хийх тэмцлийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт		2001
87.	Л.Эрдэнэбаяр	Мансуурал судлалын үндэс		2001
88.	Ж.Болдбаатар, Б.Болдбаатар	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар борлуулах гэмт хэргийг нотлох ажиллагаа		2004
89.	Ж.Болдбаатар	“Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар борлуулах гэмт хэргийн нотлох ажиллагаа”		2004
90.	Б.Баттөмөр, Б.Сүхбаатар	Хар тамхи – цагаан тахал		2006
91.	Ш.Лхагвасүрэн	Монголын өсвөр үеийнхнийг хар тамхи, мансууруулах бодис хэрэглэхээс урьдчилан сэргийлэх ажлын агуулга, арга зүй		2010
92.	Ц.Дарьжав, Б.Сосорбарам	Цагаан тахал – Олон улсын эрх зүйн зохицуулалт, олон улсын хамтын ажиллагаа, Монгол дахь өнөөгийн байдал, эрх зүйн зохицуулалт		2011
93.	Б.Болдбаатар, Ж.Мөнхболд	“Мансууруулах сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг ажиллагаа”		2012
94.	Б.Болдбаатар, С.Жанцан	“Хар тамхины гэмт явдалтай тэмцэх асуудал”		2012
95.	ГЕГ	Хар тамхи ба олон улсын хяналтын систем		2012
96.	Ж.Мөнхболд	Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг ажиллагаа		2012

97.	Ж.Болд, Б.Батбилэг нар	Хар тамхитай холбоотой гэмт хэргийг шалгахад анхаарах зарим асуудал		2014
98.	Ж.Мөнхболд	Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэх асуудал		2015
99.	Т.Дамбийням, Б.Аадарсүх, Ц.Өлзийбаяр, Г.Давааням	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажиллагаа		2015
100.	Б.Эрхэсбаатар	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнийг таних, илрүүлэхэд анхаарах асуудал		2019
101.	ХЗДХЯ, МУГХУСАЗЗ	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөл		2019
102.	ХЗДХЯ, МУГХУСАЗЗ	Мансууруулах эм, бодис хэрэглэсэн хүнийг таньж илрүүлэх, шаардлагатай арга хэмжээ авах, мэдлэг олгох сургалтын гарын авлага		2019
103.	Ж.Мөнхболд	Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэх асуудал		2024
Эрдэм шинжилгээний өгүүлэл				
104.	Ж.Болдбаатар	“Хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй хийх тэмцлийн эрүүгийн эрх зүй зохицуулалт”	“Эрх зүй,ол практик, арга зүй, мэдээллийн цуврал” №4-5.	2001
105.	Ж.Болдбаатар	“Хар тамхи, мансууруулах бодисыг борлуулах гэмт хэрэг ба нотлох ажиллагааны онцлог”	“Эрх зүй,ол практик, арга зүй, мэдээллийн цуврал” №8-9.	2002
106.	Ж.Болдбаатар	“Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодист хийх шинжилгээ”	Гэмт явдалтай тэмцэх асуудал №2.	2002
107.	О.Пунцагдаш	“Мансууруулах бодис ба хууль бус үйл ажиллагаа”	Хууль дээдлэх ёс №1	2003

108.	Р.Мөнхцэцэг, Л.Цэрэндулам, Ж.Мөнхцэцэг, Ф.Е. Шарахова	Хорт мансууруулах эмийн хэрэглээнд хийсэн судалгааны үндэс	№4 (126) Монголын анагаах ухаан	2003
109.	О.Нарьяахүү	Архаг архичин ба мансуурах донтны мансуурах донтны уушгины хатгалгааны эмнэл зүйн рентген	Онош №4/20/	2003
110.	С.Хаш-Эрдэнэ	“Мансууруулах олсны ургамлын хууль бус хэрэглээтэй холбоотой зарим асуудал”	Хууль дээдлэх ёс №4	2007
111.	Н.Орёл	Сэтгэцэд нөлөөт эмүүд	Эмийн мэдээлэл №6 (17)	2007
112.	Ж.Мөнхболд	“Мансууруулах зүйл, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл бодис”-ын хууль, эрх зүйн орчинд тулгамдсан асуудал	Монголын төр, эрх зүй №3	2007
113.	Б.Эрдэнэбилэг	“Мансууруулах сэтгэцэд нөлөөлөх зүйлийн Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал”	Гэмт явдалтай тэмцэх асуудал №4	2009
114.	Н.Баясгаланбат	“Эрүүгийн хэрэг үүсгэх үе шатанд мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэргүүдийн шинж тэмдгийг нотлох ажиллагааны тулгамдаж буй зарим асуудал”	Гэмт явдалтай тэмцэх асуудал №3	2009
115.	Б.Бат-Эрдэнэ	“Мансууруулах болон сэтгэцэд хүчтэй нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн шийдвэрлэлт, ялын бодлого”	Монголын төр, эрх зүй.	2010
116.	Б.Сосорбарам	“Монгол Улс дахь мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хууль бусаар эргэлтэд оруулах гэмт хэргийн	МУИС эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл №13	2010

		өнөөгийн байдал, эрх зүйн зохицуулалт”		
117.	Б.Болдбаатар	“Хар тамхины гэмт хэрэг, түүний хор хөнөөл”	Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал №2.	2012
118.	С.Ганбат	“Хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх асуудал. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал”	Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл	2012
119.	Ц.Дарьжав	“Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хууль бусаар эргэлтэд оруулах гэмт хэргийн өнөөгийн байдал, эрх зүйн зохицуулалтын асуудал”. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал	Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл	2012
120.	С.Жанцан	“Хар тамхи, мансууруулах бодис, эм бэлдмэлийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргээ урьдчилан сэргийлэх арга зам”	Гэмт явдалтай тэмцэх асуудал №2	2012
121.	С.Мядагмаа	“Монгол Улс дахь мансууруулах бодисын хэрэглээ, түүний хор аюул”	Гэмт явдалтай тэмцэх асуудал №3,4	2012
122.	С.Жанцан	“Хар тамхины гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг боловсронгуй болгох асуудал”.Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал	Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл	2012
123.	Судалгааны тайлан	“Хар тамхины гэмт явдлын шалтгаан, нөхцөл”	Гэмт явдалтай тэмцэх асуудал №3,4	2012
124.	С.Цэрэнчимэд	“Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын	Олон улсын эрдэм	2012

		нэр төрөл, ангилал, шинжилгээний аргууд, илрүүлэлт. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал”	Шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл	
125.	Т.Очирбат Ж.Өнгөтхүү	Хууль сахиулах байгууллагуудын уялдаа холбоо, цахим мэдээллийн сан, техник технологийн шинэчлэлийн асуудал		2015
126.	Г.Бямбадорж	Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт хийх биечилсэн судалгаа, түүнийг хэрэглэсэн этгээдийг тогтооход анхаарах асуудал		2016
127.	Г.Төмөрбаатар	БНХАУ болон олон улс дахь хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлт	Тусгаар тогтнол 3 (39) 2017	2017
128.	Вал-Ганг, Т.Бямбаа, Т.Ганцэцэг, Д.Оюунсүрэн, С.Долгорсүрэн, Н.Өлзийхутаг, Б.Даваалхагва, З.Хишигсүрэн	Мансууруулах бодисын хэрэглээний улмаас СЭМҮТ-ийн стационарт хэвтэн эмчлүүлэгсдийн түүхэнд хийсэн судалгааны үр дүнгээс	Онош №2(77)	2017
129.	З.Хишигсүрэн, Вал-Ганг, Т.Бямбаа, Т.Ганцэцэг, Д.Оюунсүрэн, С.Долгорсүрэн, Б.Даваалхагва,	Мансууруулах бодисын хэрэглээтэй холбоотой хуулийн болон сэтгэцийн эрүүл мэндийн зарим асуудлууд	Journal mental health №1	2017
130.	Л.Эрдэнэбаяр, Л.Насанцэнгэл	Хар тамхи-Эрүүл мэнд	Монголын анагаах ухаан №4/186/	2018
131.	Б.Алтансүх, О.Уулзахжаргал, М.Отгонбаатар	Хар тамхитай холбоотой гэмт хэрэгтэй хэрхэн үр дүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх вэ	Гэмт явдалтай тэмцэх асуудал №04(66)	2018

132.	Ц.Нямгэрэл	“Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын үндэсний эрх зүйн зохицуулалтын зарим түүхэн эх сурвалж баримт	Тусгаар тогтнол 2020 №1 (49)	2020
133.	Н.Мөнхзул, Н.Батнасан	Хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл гаалийн хяналтын боловсронгуй болгох арга зам		2023
134.	-	Хар тамхи, мансууруулах бодисын тухай ойлголт, өнөөгийн нөхцөл байдал тулгамдаж буй асуудал мөн болох нь		2021
135.	Ц.Нямгэрэл	Хар тамхи татах ба хязгаараар оруулж худалдахыг хориглосон үндэсний эрх зүйн зохицуулалтын зарим түүхэн эх сурвалж (1921-1996 он)	Тусгаар тогтнол 2024 №1 (64)	2024

Хавсралт №2

МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТТЭЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ЯВДЛЫГ СУДАЛСАН
БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРААНГУЙЛСАН ХҮСНЭГТ

№	№	Агуулга	Докторын зэрэг горилсон бүтээл	Магистрын дипломын ажил	Суурь болон хэрэглээний судалгааны ажил	Ном, сурах бичиг, гарын авлага	Нэг сэдэвт бүтээл	Эрдэм шинжилгээний илтгэл	Эрдэм шинжилгээний өгүүлэл	БҮГД
Судалгааны хүрээ, чиглэл	1.	Эрүүгийн эрх зүйд тулгамдсан асуудал	0	0	0	0	0	3	1	4
	2.	Ялын бодлогод тулгамдсан асуудал	0	0	1	0	0	1	0	2
	3.	Мөрдөн шалгах ажиллагаанд тулгамдсан асуудал	0	1	0	1	0	3	0	5
	4.	Урьдчилан сэргийлэх ажиллагаанд тулгамдсан асуудал	0	0	0	1	1	5	0	7
	5.	Олон улсын хамтын ажиллагаанд тулгамдсан асуудал	0	0	0	0	0	4	3	7
	6.	Олон улсын баримт бичиг, гэрээ конвенцын хэрэгжилтэд тулгамдсан асуудал	0	0	0	0	0	0	1	1
	7.	Эрх зүйн зохицуулалтын онцлог, хууль тогтоомжийн хэрэгжилтэд тулгамдсан асуудал	0	1	1	0	0	8	1	11
	8.	Хяналт, шинжилгээнд тулгамдсан асуудал	0	0	0	0	0	0	0	0

	9.	Шүүх шинжилгээнд тулгамдсан асуудал	0	0	0	0	0	2	0	2
	10.	Техник хэрэгсэлд тулгамдсан асуудал	0	0	0	0	0	0	0	0
	11.	Удирдлага зохион байгуулалтад асуудал	0	0	0	0	0	1	0	1
	12.	Бусад	1	2	6	2	0	0	8	19
	13.	Холимог	0	0	2	0	0	27	3	32
	НИЙТ		1	4	10	4	1	54	17	91
Эрдмийн зэрэг, цол	1.	Доктор	0	0	0	0	0	16	2	18
	2.	Магистр	1	0	0	0	0	21	1	23
	3.	Судлаач	0	4	10	4	1	26	14	59
	4.	Тодорхойгүй						3		3
	НИЙТ		1	4	10	3	1	67	17	103
Ажлын байдал	1.	Шүүгч	0	0	0	0	0		1	1
	2.	Прокурор	0	0	0	0	0	4	0	4
	3.	Цагдаагийн алба хаагч	0	0	0	1	0	12	0	13
	4.	Эрдэмтэн, багш	0	0	1	1	0	29	1	32
	5.	Судлаач	0	0	4	1	1	7	2	15
	6.	Бусад төрийн байгууллагын алба хаагч	0	0	1	0	0	11	1	13
	7.	ТББ-ын ажилтан	0	0	2	0	0	3	0	5
	8.	Бусад	1	4	2	1	0		12	20
	9.	Тодорхойгүй						1		1
	НИЙТ		1	4	10	4	1	67	17	104
Гүйцэтгэгч	1.	Доктор	0	0	0	0	0	11	2	13
	2.	Магистр	1	0	0	0	0	7	0	8
	3.	Эрдэмтэн, багш	0	0	0	1	0	25	1	27

Бичилт ийн хэлбэр	4.	Судлаач	0	4	10	3	1	24	14	56
	НИЙТ		1	4	10	3	1	67	17	103
	1.	Ганцаар	1	4	10	0	1	40	15	71
	2.	Хамтарсан	0	0	0	4	0	12	2	18
	3.	Эрдэмтэн, судлаачаар удирдуулсан	0	0	0	0	0	2	0	2
	НИЙТ		1	4	10	4	1	54	17	91

